

АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН  
ЖИЛД ХҮНИЙ ИХ ЭМЧ МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН ЖИШИГ СОРИЛ - I

Сорилын зөв хариулт

1-С, 2-D, 3-A, 4-E, 5-A, 6-B, 7-С, 8-B, 9-D, 10-A, 11-D, 12-D, 13-E, 14-С, 15-E, 16-E,  
17-E, 18-С, 19-E, 20-С, 21-B, 22-B, 23-B, 24-D, 25-D, 26-A, 27-С, 28-B, 29-B, 30-D, 31-  
С, 32-A, 33-B, 34-A, 35-A, 36-D, 37-B, 38-С, 39-D, 40-С, 41-B, 42-D, 43-D, 44-D, 45-С,  
46-E, 47-С, 48-С, 49-D, 50-D, 51-E, 52-B, 53-B, 54-С, 55-D, 56-С, 57-E, 58-D, 59-D, 60-  
E, 61-A, 62-D, 63-E, 64-D, 65-B, 66-D, 67-E, 68-D, 69-B, 70-С, 71-D, 72-B, 73-D, 74-D,  
75-D, 76-A, 77-B, 78-С, 79-D, 80-B, 81-D, 82-D, 83-E, 84-B, 85-D, 86-D, 87-E, 88-С, 89-  
A, 90-B, 91-E, 92-E, 93-E, 94-B, 95-С, 96-D, 97-С, 98-E, 99-D, 100-A, 101-B, 102-D,

Сорилын түлхүүр:

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
  - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (А.)
  - Зөв, Зөв, Буруу (В.)
  - Зөв, Буруу, Буруу (С.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (E.)

Сонгогдсон сорил

- /1./ Бөөрний архаг өвчний 3-р үед ТШХ яаж өөрчлөгдөх вэ?
  - А. ТШХ бага зэрэг буурсан 60-89 мл/мин
  - В. ТШХ бага зэрэг буурсан 30-60 мл/мин
  - С. ТШХ буурсан 30-59 мл/мин
  - Д. ТШХ буурсан 30-49 мл/мин
  - Е. ТШХ маш их буурсан 15-29 мл/мин
- /2./ Бөөрний архаг өвчний үл зохицуулагдах эрсдэлт хүчин зүйл
  - А. Нас, хүйс, хорт зуршил, удамшлын хүчин зүйл
  - В. Амьдарлын буруу хэв маяг, удамшлын хүчин зүйл, нас, хорт зуршил
  - С. Хорт зуршил, дислипидеми, даралт ихдэлт, эмийн буруу хэрэглээ
  - Д. Нас, гарал үүсэл, удамшлын хүчин зүйл, хүйс
  - Е. Нас, гарал үүсэл, удамшил, амьдарлын буруу хэв маяг
- /3./ АД ихсэлттэй, ЧШтэй, протейнури илэрсэн өвчтөнд хэрэглэх 1-р сонголтын эм аль нь вэ?
  - А. АСЕ ингибитор
  - В. АТ2 рецепторын саатуулагч
  - С. Диуретик
  - Д. Кальцийн антагонист
  - Е. Бетта блокатор
- /4./ БАӨ үед бөөр хамгаалах зорилгоор хэрэглэдэггүй эмийн бүлэг аль нь вэ?
  - А. АСЕ ингибитор
  - В. АТ-2 рецепторын блокатор

- C. Антикоагулянт
  - D. Нон-дигидропиридин
  - E. Дигидропиридин
- /5./ Шээсний шинжилгээнд ямар төрлийн бортгонцор илэрвэл хэвийн гэж үзэх вэ?
- A. Гиалин
  - B. Зернистый
  - C. Восковидный
  - D. Эритроцитын
  - E. Лейкоцитын
- /6./ Бөөрний ямар өвчний үед Ходсоны шинж илрэх вэ?
- A. Архаг гломерулонефрит
  - B. Архаг пиелонефрит
  - C. Бөөрний амилоидоз
  - D. Бөөрний поликистоз
- /7./ Артерийн гипертензийн хожуу үед шээсэнд гарах өөрчлөлт
- A. Лейкоцидури
  - B. Гематури+глюкозури
  - C. Протеинури+гематури
  - D. Оксалатури
  - E. Гипостенури
- /8./ Артерийн гипертензийн нефропатийн эрт үед шээсэнд гарах өөрчлөлт
- A. Лейкоцидури
  - B. Микроальбуминури
  - C. Протеинури+гематури
  - D. Оксалатури
  - E. Гипостенури
- /9./ Диабетийн нефропатийн эрт үед шээсэнд гарах өөрчлөлт
- A. Лейкоцидури
  - B. Гематури+глюкозури
  - C. Протеинури+гематури
  - D. Микроальбуминури
  - E. Гипостенури
- /10./ Бенс-Джонсын уураг ямар өвчний үед шээсээр ялгардаг вэ?
- A. Миелом
  - B. Миелолейкоз
  - C. Подагр
  - D. Лимфолейкоз
  - E. Гемофили
- /11./ Преднизолоны сорилоор юуг илрүүлэх вэ?
- A. Далд гематури
  - B. Далд лейкоцидуриг илрүүлэх
  - C. Далд протеинуриг илрүүлэх
  - D. БШЗ-ын далд үрэвслийг илрүүлэх
  - E. Дээрхи бүгд
- /12./ Доплерт сонографи дараахь тохиолдлоос нэгээс бусдад хийх шаардлагатай.
- A. Бөөрний хавдар
  - B. Шалтгаан тодорхойгүй шээс цустах
  - C. Шалтгаан тодорхойгүй даралт ихсэх
  - D. Архаг гломерулонефрит
  - E. Бөөрний унжилт
- /13./ Хоногийн шээсний хэмжээ 100 мл-ээс багасахыг юу гэж нэрлэх вэ ?
- A. Полиури
  - B. Никтири
  - C. Поллакури
  - D. Дизури
  - E. Анури

- /14./ Шээсний доод замын үрэвслийн үед шээс ялгаралтын өөрчлөлтийн аль нь илрэх вэ?
- A. Анури
  - B. Гематури
  - C. Странгури
  - D. Никтури
  - E. Олигури
- /15./ Өдөрт олон удаа шээхийг юу гэж нэрлэх вэ?
- A. Олигоури
  - B. Никтури
  - C. Странгури
  - D. Энурез
  - E. Поллакури
- /16./ Хүүхэд шөнө орондоо шээхийг юу гэж нэрлэх вэ?
- A. Олигоури
  - B. Дизури
  - C. Никтури
  - D. Странгури
  - E. Энурез
- /17./ 1 минутанд ялгарах шээсэнд агуулагдах дүрст элементийг дараахь аргаар шинжилнэ.
- A. Аддис Каковский
  - B. Ребергийн сорил
  - C. Нечипоренкогийн сорил
  - D. Фольгардын сорил
  - E. Амбуржийн сорил
- /18./ Нечипоренкогийн сорилоор
- A. 1 мин-ын диурез бөөрний түүдгэнцэрийн шүүх үйл ажиллагааг үзнэ
  - B. Шингэний ачаалал өгч, бөөрний шингэрүүлэлтийн үйл ажиллагааг үзнэ.
  - C. 1 мл-ын эзэлхүүнд дүрст элементийг тодорхойлно.
  - D. 24 цагийн шээсэнд дүрст элементийг тодорхойлно
  - E. 3,3 цагийн зайтай шээсэнд бөөрний үйл ажиллагааг үзнэ
- /19./ Шээс цустах хам шинж хамгийн их илрэх өвчин
- A. Амилоидоз
  - B. Поликистоз
  - C. Архаг пиелонефрит
  - D. Архаг гломерулонефрит
  - E. Бөөрний сүрьеэ
- /20./ Нефрозийн кризийн гол шалтгаан
- A. Цусны даралт ихсэх
  - B. Цустай шээх
  - C. Хэт их хавагнах
  - D. Зүрхний дутагдал
  - E. Тархи хавагнах
- /21./ Нефроз хам шинжийн үед бөөрний дутагдлын оношлогоонд аль нь чухал вэ?
- A. Түүдгэнцэрийн шүүлт
  - B. Сийвэн дэх креатинин
  - C. Сийвэн дэх холестерин
  - D. Сувганцарын эргэн шимэгдэлт
  - E. Протеинурийн түвшин
- /22./ Фольгардын сорилоор дараахь зүйлийг тодорхойлно
- A. 1 мин-ын диурез, бөөрний фильтраци үзэх
  - B. Шингэний ачаалал өгч, бөөрний шингэрүүлэх үйл ажиллагааг үзэх
  - C. 1 мин-ын эзэлхүүнд дүрст элемент тодорхойлох
  - D. 24 цагийн шээсэнд дүрст элемент тодорхойлох
  - E. 3,3 цагийн зайтай шээс цуглуулж бөөрний үйл ажиллагааг үзнэ
- /23./ Доорхи шинж тэмдэгээс нэгээс бусад нь амилоидозын үед гарна
- A. Диаррей

- В. Дизури
  - С. Шээсний өөрчлөлт
  - Д. Хаван
  - Е. Ууц нуруугаар өвдөх
- /24./ Хоёрдогч пиелонефритийн үед доорхи шинжүүдээс нэгээс бусад нь илрэнэ
- А. Дизури
  - В. 1мл шээсэнд 100000-аас дээш нян илэрнэ
  - С. Бөөрний аяганцар тэвшинцэрийн деформаци
  - Д. Түүдгэнцэрийн шүүлт буурах
  - Е. Сувганцаарын эргэн шимэгдэлт буурах
- /25./ Архаг гломерулонефритын холимог үед илэрдэггүй шинж
- А. Хаван, их хэмжээний трансудат
  - В. Даралт ихдэлт
  - С. Лейкоцитури
  - Д. Зимницкийн сорилд шээсний хувийн жин жигд буурсан байх
  - Е. Ренографийн шинжилгээнд бөөрний үйл ажиллагаа жигд буурах
- /26./ Шээсний шинжилгээнд гарч буй аль өөрчлөлт нь түүдгэнцрийн гэмтлийг илтгэх вэ?
- А. Уураг 3гр/л их
  - В. Уураг 1гр/л бага
  - С. Шээсний хувийн жин 1005 бага
  - Д. Их хэмжээний уурагтай
  - Е. Цустай шээх
- /27./ Архаг пиелонефритын эмчилгээнд доорхи эмийн бүлгийн нэгээс бусдыг нь хэрэглэнэ
- А. Фторхинолон
  - В. Циклоспорин
  - С. Кортикостероид
  - Д. Сульфаниламид
  - Е. Налидиксийн хүчлийн бэлдмэлүүд
- /28./ Жирэмсний эрт үед пиелонефритын эмчилгээнд хэрэглэх эм
- А. Нитрофураны бүлэг
  - В. Пенициллины бүлэг
  - С. Цефалоспорины бэлдмэлүүд
  - Д. Сульфаниламид
  - Е. Нитроксолины бүлэг
- /29./ Нечипоренкогийн сорил ямар гарвал өөрчлөлттэй гэж үзэх вэ ?
- А. Бактериури
  - В. Лейкоцитури 2000 дээш
  - С. Лейкоцитури 2000 хүртэл
  - Д. Лимфоцитури
  - Е. Протейнури 1 гр/л
- /30./ Глюкоз болон аминхүчлүүдийн эргэн шимэгдэх процесс хаана явагддаг вэ ?
- А. Холын тахир сувганцар
  - В. Генлийн гогцооны өгсөх бүдүүн хэсэг
  - С. Генлийн гогцооны уруудах нарийн хэсэг
  - Д. Ойрын тахир сувганцар
  - Е. Цуглуулах сувганцар
- /31./ Гликокаликс гэж аль ойлголтыг нэрлэдэг вэ
- А. Подоцитийн элемент
  - В. Мезангиумын элемент
  - С. Суурин мембраны хасах цэнэгтэй хэсгүүд
  - Д. Ялгаруулах аппарат
  - Е. Ренин
- /32./ Бөөрний гаралтай гематурийн үед 3 аяганы сорилд дараах өөрчлөлт илэрнэ
- А. 3 аяганд улаан эсийн хэмжээ адилхан байна
  - В. Эхний аяганы улаан эсийн хэмжээ их, сүүлийн 2 аяганых бага
  - С. Эхний 2 аяганы улаан эсийн хэмжээ их ,сүүлийн аяганых бага

D. 3 аяганы улаан эсийн хэмжээ бага

E. 3 аяганд улаан эс илрэхгүй

/33./ Архаг гломерулонефритийн үед гормон эмчилгээний эсрэг заалт

A. Гематури

B. Артерийн даралт ихсэлт

C. Бөөрний архаг дутагдал

D. Нефроз хам шинж

E. Сэдрэлээс сэргийлэх зорилгоор

/34./ Ямар эмгэгийн үед рентген шинжилгээнд Ходсоны шинж илрэх вэ?

A. Пиелонефритийн хатингаршил

B. Бөөрний уйланхай

C. Бөөрний поликистоз

D. Бөөрний түүдгэнцэрийн үрэвсэл

E. Бөөрний чулуу

/35./ Нефроны аль хэсэгт натрийн ихэнх хувь нь эргэн шимэгддэг вэ?

A. Ойрын тахир сувганцарт

B. Генлийн гогцооны өгсөх хэсэг

C. Холын тахир сувганцарт

D. Цуглуулах сувганцарт

E. Түүдгэнцэрт

/36./ ЮГА-ийн үүрэг

A. Усны эргэн шимэгдэлт

B. Хагас цэнэгт молекулыг барих

C. Фосфатын эргэн шимэгдэлт

D. Ренинийг нийлэгжүүлэх

E. Простагландин нийлэгжүүлэх

/37./ Бөөрний түүдгэнцэрт дараах процесс явагдана

A. Реабсорц

B. Филтрац

C. Секрец

D. Филтрац болон секрет

E. Секрет болон филтрац

/38./ Альдостерон даавар хаанаас ялгардаг вэ?

A. Гипофиз

B. Бөөр

C. Бөөрний дээд булчирхай

D. Бөөрний тархилаг давхрага

E. ЮГА

/39./ Архаг гломерулонефритийн даралт ихдэх хэлбэрийн сэдрэлийн үед дараах нэг шинжээс бусад нь илэрнэ.

A. Протеинури

B. Гематури

C. Цилиндрури

D. Хаван

E. Артерийн даралт ихсэлт

/40./ Биохимийн шинжилгээний ямар өөрчлөлтөөр бөөрний архаг дутагдлын үе шатыг үнэлж болох вэ?

A. Сийвэн дэх мочевины хэмжээ

B. Сийвэнгийн үлдэгдэл азот

C. Сийвэнгийн креатинины хэмжээ

D. Сийвэн дэх калийн хэмжээ

E. Сийвэн дэх кальцийн хэмжээ

/41./ Бөөрний архаг дутагдлын эхэн үед дараах шинж тэмдгүүд илэрнэ.

A. Артерийн даралт ихсэх

B. Их уух, их шээх

C. Цусан дахь калийн хэмжээ ихсэх

- D. Цусан дахь кальцийн хэмжээ ихсэх  
E. Цусан дахь фосфорын хэмжээ буурах
- /42./ Жирэмсэний пиелонефриттэй эмэгтэйчүүдийн жирэмсэний явц төрөлтийн үед доорхи хүндрэл нэгээс бусад нь гарч болно
- A. Хожуу үеийн хордлого
  - B. Үр зулбалт
  - C. Ургийн халдварт хүндрэлүүд
  - D. Ургийн гипертрофи илрэх
  - E. Бактеремийн шок
- /43./ ST сегмент өргөгдөөгүй зүрхний шигдээсийн үед цус алдах эрсдэл өндөр байвал ямар антикоагулянтийг хамгийн түрүүнд сонгох вэ?
- A. Бивалирудин
  - B. Эноксипарин
  - C. Фраксипарин
  - D. Фондапаринукс
  - E. Гепарин
- /44./ Зүрхний зүүн ховдлын доод ханы шигдээсийн үед цахилгаан бичлэгийн аль холболтуудад эмгэг өөрчлөлт илрэх вэ?
- A. V1, V2, V3, V4
  - B. I, aVL, V5, V6
  - C. I, II, aVR
  - D. II, III, aVF
  - E. III, aVR, aVL
- /45./ Б. 58 настай, эрэгтэй, АД =140/90. Онош: Анхдагч артерийн гипертензи II үе шат , эрсдлийн зэрэг III. Ямар эмчилгээ тохиромжтой вэ?
- A. Эмийн бус
  - B. Нэг эм
  - C. Хоёр эмийн хослол
  - D. Гурван эмийн хослол
  - E. Дөрвөн эмийн хослол
- /46./ Зүрхний шигдээстэй өвчтөнд титэм судасны дотуурх эмчилгээний өмнө өгөх клопидогрелийн анхны тун ямар байх вэ?
- A. 75 мг
  - B. 100 мг
  - C. 150 мг
  - D. 225 мг
  - E. 300 мг
- /47./ Зүүн ховдлын урд ханын цочмог шигдээсийн үед ямар титэм судас бөглөрсөн байх магадлалтай вэ?
- A. Зүүн титмийн артерийн багана
  - B. Зүүн титэм судасны тойрогч артери
  - C. Зүүн титэм судасны уруудах салаа
  - D. Баруун титмийн артери
  - E. Зүүн титэм судасны уруудах салаа ба тойрогч артери
- /48./ Зүрхний шигдээстэй өвчтөнд яаралтай тусламж үзүүлэхдээ аспириныг ямар тунгаар өгөх вэ?
- A. 75-81мг
  - B. 100 мг
  - C. 162-325мг
  - D. 500 мг
  - E. 162-500мг
- /49./ ST сегмент өргөгдөөгүй зүрхний шигдээсийг тогтворгүй стенокардигаас ялгахын тулд ямар шинжилгээ хийх хэрэгтэй вэ?
- A. Зүрхний цахилгаан бичлэг
  - B. Зүрхний хэт авиан шинжилгээ
  - C. Нийт КФК, ЛДГ

- D. Тропонин
- E. Коронарны ангиографи

/50./ Титэм судсан дотуурх эмчилгээ хийх явцад зүрхний шигдээс үүссэн. Энэ нь ямар хэлбэрийн шигдээс вэ?

- A. I хэлбэр
- B. II хэлбэр
- C. III хэлбэр
- D. IV хэлбэр
- E. V хэлбэр

/51./ ЗЦБ-ийн V1-V6 холболтод ST сегмент голч тэнхлэгээс дээш 2 мм өргөгдөж, T шүд сөрөг туйлтай болсон байв. Шигдээсийн байршил, хамарсан давхарга, үе шатыг тодорхойлох

- A. Зүүн ховдлын урд ханын субэпикардын шигдээс, хурцавтар үе шат
- B. Зүүн ховдлын урд ханын субэпикардын шигдээс, хурц үе шат
- C. Зүүн ховдлын урд ба хажуу ханын субэпикардын шигдээс, хурц үе шат
- D. Зүүн ховдлын урд ханын субэндокардын шигдээс, хурц үе шат
- E. Зүүн ховдлын урд ба хажуу ханын субэпикардын шигдээс, хурцавтар үе шат

/52./ Титэм судасны дотуурх эмчилгээ хийх үед том молекулт гепариныг ямар үзүүлэлтийн хяналтан дор хэрэглэдэг вэ?

- A. A PTT
- B. ACT
- C. INR
- D. TT
- E. Фибриноген

/53./ ЗЦШ-ийн үед чагнахад хоёр уушгины арын доод хэсгээр нойтон хэрчигнүүр сонсогдож байвал зүрхний цочмог дутагдлын (Киллипийн ангилалаар) хэд дүгээр зэрэг байж болох вэ?

- A. I зэрэг
- B. II зэрэг
- C. III зэрэг
- D. IV зэрэг
- E. V зэрэг

/54./ Зүрхний цочмог шигдээсийн шинж тэмдэг бүхий өвчтөн эмнэлэгт ирэхэд хамгийн түрүүнд ямар шинжилгээг төлөвлөх вэ?

- A. Цуврал ЗЦБ
- B. Цуврал биохимийн маркер
- C. Цуврал ЗЦБ, биохимийн маркер
- D. Эхлээд нэг удаа ЗЦБ, дараа нь цуврал биохимийн маркер
- E. ЗЦБ, Эхокардиографи

/55./ Америкийн Зүрхний Холбооны удирдамжид заасны дагуу ST сегмент өргөгдөөгүй зүрхний шигдээстэй өвчтөн яаралтай журмаар титэм судасны дотуурх эмчилгээ хийлгэх тохиолдолд ямар антиагрегант хэрэглэвэл илүү тохиромжтой вэ?

- A. Аспирин дангаар
- B. Клопидогрел дангаар
- C. Гликопротейны IIb/IIIa рецепторын хоригч дангаар
- D. Аспирин + Гликопротейны IIb/IIIa рецепторын хоригч
- E. Тиклодипин дангаар

/56./ Зүрхний хэт авиан шинжилгээний ямар үзүүлэлтээр зүрхний зүүн ховдлын систолын дутагдлыг тодорхойлдог вэ?

- A. Зүүн ховдлын диастолын үеийн хэмжээ
- B. Зүрхний минутын эзлэхүүн
- C. Цацалтын үзүүлэлт
- D. Зүүн ховдлын систолын үеийн хэмжээ
- E. Зүүн ховдлын ханын хөдөлгөөн

/57./ Дигоксины үйлчлэлийн нөлөөгөөр ЗЦБ-д ямар өөрчлөлт гардаг вэ?

- A. ST сегмент голч тэнхлэгээс дээш өргөгдөх

- B. T шүд өндөрсөх
- C. PR зай богиносох
- D. QRS иж бүрдэл өргөсөх
- E. ST сегмент голч тэнхлэгээс доош буух

/58./ Зүрхний дутагдлыг эрт илрүүлэх зорилгоор ямар шинжилгээг хийвэл илүү үр дүнтэй вэ?

- A. Зүрхний хэт авиан шинжилгээ
- B. Зүрхний ачаалалтай сорил
- C. Тропонин
- D. Натри ялгаруулагч пептид
- E. Зүрхний сцинтиграфи

/59./ Өвчтөн 29 настай, эмэгтэйг чагнахад зүрхний I цэгт диастолын, II цэгт систолын тод шуугиан сонсогдоно. Зүрхний ямар гажиг байх магадлалтай вэ?

- A. Митрал хавхлагын ба аортын хавхлагын дутагдал хавсарсан гажиг
- B. Митрал хавхлагын дутагдал ба аортын хавхлагын нарийсал хавсарсан гажиг
- C. Митрал хавхлагын нарийсал ба аортын хавхлагын дутагдал хавсарсан гажиг
- D. Митрал хавхлагын ба аортын хавхлагын нарийсал хавсарсан гажиг
- E. Митрал хавхлагын нарийсал ба уушгины хавхлагын дутагдал хавсарсан гажиг

/60./ Митрал хавхлагын нээлтийн талбайн хэвийн хэмжээг сонгоно уу?

- A. 2.0-2.5 см<sup>2</sup>
- B. 2.5- 3.0 см<sup>2</sup>
- C. 3.5 -4.0 см<sup>2</sup>
- D. 3.0-3.5 см<sup>2</sup>
- E. 4.0-6.0 см<sup>2</sup>

/61./ Митрал хавхлагын нарийслын ямар тохиолдолд мэс заслын эмчилгээ хийх заалттай вэ?

- A. Митрал хавхлагын нээлтийн талбай <1.5 см<sup>2</sup>
- B. Митрал хавхлагын нээлтийн талбай ≤2.5 см<sup>2</sup>
- C. Митрал хавхлагын нээлтийн талбай < 0.7 см<sup>2</sup>
- D. Митрал хавхлагын нээлтийн талбай <1.8 см<sup>2</sup>
- E. Митрал хавхлагын нээлтийн талбай < 2.0 см<sup>2</sup>

/62./ Халдвар-харшлын миокардитын гол шалтгаан юу вэ?

- A. Нян
- B. Мөөгөнцөр
- C. Хордлого
- D. Вирус
- E. Аутоимуны өвчин

/63./ Халдварт эндокардитыг эмнэлгийн дотоод халдвар гэж үздэг, яагаад?

- A. Амьсгалын замаар халдвар дамждаг
- B. Бохир гараар халдвар дамждаг
- C. Эмнэлгийн ариун цэвэр хангалтгүйн улмаас
- D. Тариураар халдварлагддаг
- E. Халдвар хамгаалалын дэглэм алдагдсаны улмаас халдвар цусаар дамждаг

/64./ Халдварт эндокардитын үед ямар эмчилгээ хамгийн чухал вэ?

- A. Дархлаа дэмжих
- B. Үрэвслийн эсрэг
- C. Хордлого тайлах
- D. Антибиотик
- E. Харшлын эсрэг

/65./ Эмнэл зүйн ямар хэлбэрийн перикардитийн үед цээжний өвдөлт ба перикардын шүргэлцэх чимээ илэрдэг вэ?

- A. Цочмог перикардит
- B. Хуурай перикардит
- C. Шүүдэст цочмог перикардит
- D. Шүүдэст архаг перикардит
- E. Наалдаст перикарди



- /66./ Эмнэл зүйн ямар хэлбэрийн перикардит нь зөвхөн архаг явцтай байдаг вэ?
- A. Хуурай
  - B. Наалдаст
  - C. Шүүдэст
  - D. Шүүдэст ба наалдаст
  - E. Хуурай ба наалдаст
- /67./ Эмнэл зүйн ямар хэлбэрийн перикардит нь зөвхөн цочмог явцтай байдаг вэ?
- A. Хуурай
  - B. Наалдаст
  - C. Шүүдэст
  - D. Шүүдэст ба наалдаст
  - E. Хуурай ба шүүдэст
- /68./ Синкопийг ямар эмгэгээс хамгийн түрүүнд ялган оношлох шаардлагатай вэ?
- A. Гипогликеми, комын байдал
  - B. Эпилепсийн уналт, коллапс
  - C. Истерийн уналт, шок
  - D. Гипогликеми, эпилепсийн ба истерийн уналт
  - E. Эпилепсийн ба истерийн уналт, коллапс
- /69./ Синкопийн эмнэл зүйн шинж тэмдэгийн онцлогийг тэмдэглэнэ үү?
- A. Шинж тэмдэг нь гэнэт эхэлж, удаан үргэлжилдэг
  - B. Гэнэтийн эхлэл, богино хугацааны үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэнэ
  - C. Гэнэтийн эхлэл, богино хугацааны үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэхгүй
  - D. Аажим эхлэл, богино хугацааны үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэнэ
  - E. Аажим эхлэл, удаан үргэлжлэл, тархины үйл ажиллагаа бүрэн эргэн сэргэнэ
- /70./ Зүрх судасны эрсдэлтэй нас, хүйсний байдлыг тодорхойлно уу?
- A. Эрэгтэй >40, эмэгтэй >50
  - B. Эрэгтэй >45, эмэгтэй >50
  - C. Эрэгтэй >45, эмэгтэй >55
  - D. Эрэгтэй >50, эмэгтэй >60
  - E. Эрэгтэй >55, эмэгтэй >65
- /71./ Зүрхний Дэлхийн Холбоо зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх гол арга замыг юу гэж тодорхойлсон вэ?
- A. Амьдралын зөв хэв маягийг хэвшүүлэх
  - B. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх
  - C. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах
  - D. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэн, тэдгээрийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах
  - E. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдах
- /72./ Атеросклерозын ямар үе шатанд фиброзон товруу үүсдэг вэ?
- A. I үе шат
  - B. II үе шат
  - C. III үе шат
  - D. IV үе шат
  - E. V үе шат
- /73./ Амилуулах суурь тусламж үзүүлэх үед цээжний шахалт-амьсгалуулалтын харьцаа ямар байвал зохистой вэ?
- A. 15:2
  - B. 15:4
  - C. 30:4
  - D. 30:2
  - E. 30:6
- /74./ Аль нь зүрхний хамгийн өвөрмөц фермент вэ?
- A. ГОТ

- B. ЛДГ
- C. КФК
- D. Тропонин
- E. ГПТ

/75./ Дараах оношлогооны аргуудаас аль нь миокардын ишемийг эрт оношлох боломжтой вэ?

- A. Зүрхний цахилгаан бичлэг
- B. Зүрхний хэт авиан шинжилгээ
- C. Анамнез
- D. Зүрхний ачаалалтай бичлэг
- E. Сийвэнд фермент үзэх

/76./ 50 настай эрэгтэй, 20 –оод хоногийн өмнөөс анх удаа зүрхээр өвдсөн, өвдөлт нь сэтгэл санааны болон биеийн хүчний ачаалалтай холбоотой гэсэн өгүүлэмжтэй. Өвдөлтийн хүч хүчтэй бус, биеийн хүчний ачаалаа зогсоож, тайвшрахаар өвдөлт намддаг гэнэ. Тохиолдлоор хийсэн ЭКГ-т ST сегментийн ба Т шүдний өөрчлөлт илрээгүй. Та ямар хэлбэрийн стенокарди гэж таамаглаж байна вэ?

- A. Анхдагчаар үүссэн , ачаалалын үеийн стенокарди
- B. Ачаалалын үеийн тогтвортой стенокарди
- C. Гэнэт үүссэн тайван үеийн стенокарди
- D. Даамжрах явцтай стенокарди
- E. Тайван үеийн стенокарди

/77./ Ямар ч өвдөлтгүй, эмнэл зүйн илрэлгүй хүмүүст титэм судасны эмгэгийг илрүүлэх зорилгоор эмийн сорилтой зүрхний хэт авиан оношлогоо хийдэг. Ямар эмийн бэлдмэлийг энэхүү сорилд түлхүү ашигладаг вэ?

- A. Пропроналол
- B. Добутамин
- C. Атропин
- D. Допамин
- E. Нитроглицерин

/78./ Зүрхний шигдээсийн эхний 24 цагт булчин тариа хийхийг зөвлөдөггүй. Яагаад?

- A. Тарианы үйлчилгээ удаан эхэлдэг
- B. Эмчилгээний үр дүн хангалтгүй
- C. Сийвэнд ферментийн идэвхжлийг зөв тодорхойлоход бэрхшээл учруулдаг
- D. Хүндрэл өгдөг
- E. Судсанд хийх нь илүү үр дүнтэй

/79./ Зүрхний цахилгаан бичлэгийн V1-V6 холболтод ST сегмент бууж, урвуу Т шүд илэрчээ. Энэ нь ямар өөрчлөлт вэ?

- A. Миокардын дистрофийн өөрчлөлт
- B. Урд ханын субэндокардын шигдээс
- C. Урд ханын ишемийн өөрчлөлт
- D. Урд хажуу ханын ишемийн өөрчлөлт
- E. Хажуу ханын ишемийн өөрчлөлт

/80./ Дараах бэлдмэлүүдээс аль нь артерийн даралт бууруулах, миокардын хүчилтөрөгчийн хэрэгцээг багасгах, зүрхний хэм алдагдал засах үйлчилгээтэй вэ?

- A. Лизиноприл
- B. Атенолол
- C. Изосорбид
- D. Амiodарон
- E. Нифедипин

/81./ Зүрхний шигдээсийн үед анхны яаралтай тусламжийг MONA гэдэг схемээр үзүүлдэг. Энэ нь ямар үгсийн товчлол вэ?

- A. Морфин, хүчилтөрөгч, нитрат, антикоагулянт
- B. Морфин, хүчилтөрөгч, нитрат, антиагрегант
- C. Морфин, хүчилтөрөгч, нитрат, анальгетик
- D. Морфин, хүчилтөрөгч, нитроглицерин, аспирин
- E. Морфин, хүчилтөрөгч, нитроглицерин, антиаритмик

- /82./ Зүрхний шигдээс эхлэснээс хойш ямар хугацаанд бүлэн уусгах эмчилгээ хийвэл үр дүнтэй вэ?
- A. Эхний 24 цагт
  - B. Эхний 48 цагт
  - C. Эхний 18 цагт
  - D. Эхний 12 цагт
  - E. Эхний 36 цагт
- /83./ Артерийн гипертензийг цус хөдлөл зүйн хэлбэрээр ангилах нь ямар ач холбогдолтой вэ?
- A. Өвчний явцыг үнэлэх
  - B. Ялган оношлох
  - C. Тавиланг тодорхойлох
  - D. Оношлох
  - E. АД бууруулах эмийг зөв сонгох
- /84./ Артерийн даралт ихсэх өвчний үед ЗЦБ –р илрэх зүүн ховдлын томролын Корнеллийн шинж тэмдэгийг заах
- A.  $Rv5 = 24\text{мм}$
  - B.  $Sv3 + Ravl \geq 28\text{ мм}$
  - C.  $Rv4 > Rv5$
  - D.  $Rv5 + Sv1 = 30\text{мм}$
  - E.  $Rv5 + Sv1 = 34\text{мм}$
- /85./ Бөөрний судасны гаралтай гипертензийн үед хамгийн үр дүнтэй эмчилгээ юу вэ?
- A. Шээс хөөх бэлдмэл
  - B. Бета-адреноблокатор
  - C. Давсгүй хоол
  - D. Мэс заслын эмчилгээ
  - E. Апрессин
- /86./ Ямар тохиолдолд артерийн гипертензийн түвшингийн ангилалыг хэрэглэхэд тохиромжгүй вэ?
- A. Дан систолын АД ихдэлт
  - B. Анх удаа оношлогдсон тохиолдол
  - C. Даралт бууруулах эм хэрэглээгүй үед
  - D. Даралт бууруулах эм хэрэглэж байгаа үед
  - E. Хоёрдогч АД ихдэлт
- /87./ Гипертензийн кризын үед АД-н түвшинг эхний 2 цагт хэдэн хувиар бууруулвал тохиромжтой вэ?
- A. 20%-р
  - B. 35%-р
  - C. 10%-р
  - D. 15%-р
  - E. 25%-р
- /88./ Цусны сийвэнд АСЛО эерэг гарвал юуны тухай бодох вэ?
- A. Хэрлэг өвчтэй байна
  - B. Архаг тонзиллит өвчтэй байна
  - C. Стрептококкийн халдвар авч эсрэг биет үүссэн байна
  - D. Стрептококкийн эсрэг төрөгч илэрсэн байна
- /89./ Зүрхний шигдээс сорвижих үед ЗЦБ-д гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү?
- A. Эмгэг Q шүд илрэх
  - B. ST-T сегмент голч тэнхлэгээс доош буух
  - C. ST-T сегмент голч тэнхлэгээс дээш өргөгдөх
  - D. T шүд урвуу болох
  - E. R шүд намсах
- /90./ Шигдээсийн ямар хэлбэрийн үед бүлэн уусгах эмчилгээ заалттай вэ?
- A. Субэндокардын шигдээс
  - B. Субэпикардын шигдээс
  - C. Хүндрэлттэй шигдээс

- D. Дахисан шигдээс  
E. Давтан шигдээс
- /91./ Цусны даралт бууруулах эмүүдээс нь аль нь цусны ренины идэвхжлийг багасгадаг вэ?  
A. Каптоприл  
B. Атенолол  
C. Празоцин  
D. Нифедипин  
E. Лозартан
- /92./ Зүрхний архаг архаг дутагдлын Америкийн Зүрхний Холбооны ангиллаар “C” үе шатанд илрэх шинжийг нэрлэнэ үү?  
A. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлс илэрсэн байх  
B. Биеийн хүчний ачаалалын үед зүрхний дутагдлын эмнэл зүйн шинж илрэх  
C. Зүрхний бүтцийн өөрчлөлт илрсэн боловч зүрхний дутагдлын эмнэл зүйн шинж тэмдэггүй байх  
D. Зүрх бүтцийн өөрчлөлттэй, зүрхний дутагдлын шинж тайван үед тод илрэх  
E. Зүрхний бүтцийн өөрчлөлтэй байх, зүрхний дутагдлын шинж тэмдэг илрээд удаагүй байх
- /93./ Анхдагч артерийн гипертензийн үед ЗЦБ –р илрэх зүүн ховдлын томролын Лион-Соколовын шинж тэмдэгийг заах  
A.  $Rv5 > 25\text{мм}$   
B.  $Sv3 + Rv1 > 24\text{ мм}$   
C.  $Rv4 > Rv5$   
D.  $Rv5 + Sv1 > 30\text{мм}$   
E.  $Rv5 + Sv1 > 35\text{мм}$
- /94./ Миокардитын гол шалтгаан юу вэ?  
A. Нянгийн халдвар  
B. Вирусын халдвар  
C. Эмийн нөлөөлөл  
D. Хордлого хоолны хүчин зүйл  
E. Шалтгаан тодорхойгүй аутоиммуны хүчин зүйл
- /95./ Гипертрофийн кардиомиопатийг оношлох хамгийн мэдээлэлтэй арга бол:  
A. ЭКГ  
B. Фонокардиографи  
C. ЭхоКГ  
D. Цээжний хөндийн эрхтэний рентгенографи  
E. Коронароангиографи
- /96./ Титэм судасны хэдэн хувь нарийсвал цус хөдлөлд мэдэгдэхүйц саад учруулах вэ?  
A. 15 хувь  
B. 25 хувь  
C. 40 хувь  
D. 50 хувь  
E. 75 хувь
- /97./ Уушгины артерийн систолын даралтын хэвийн хэмжээг хэлнэ үү?  
A. 18-20 мм, муб  
B. 18-25 мм, муб  
C. 18-30 мм, муб  
D. 18-35 мм, муб  
E. 18-40 мм, муб
- /98./ Аль нь миокардын үхжлийг илэрхийлдэг ЗЦБ-ийн шинж тэмдэг вэ?  
A. ST сегмент голч тэнхлэгээс доошлох  
B. ST сегмент голч тэнхлэгээс дээш өргөгдөх  
C. QRS иж бүрдэл өргөсөх  
D. Хуучин эмгэг шүд  
E. Шинээр үүссэн эмгэг Q шүд
- /99./ Нитроглицерины гол гаж нөлөөг заана уу  
A. Бөөлжис цутгах

- B. Суулгах
- C. Ханиалгах
- D. Толгой өвдөх
- E. Хоолонд дүргүй болох

/100./ 1 мл гепарины уусмал хэдэн нэгж гепарин байдаг вэ?

- A. 5000
- B. 1000
- C. 10000
- D. 15000
- E. 1500

/101./ Зүрхний зүүн ховдлын ханын зузааралтыг анхдагч артерийн гипертензийн үед тодорхойлох нь ямар ач холбогдолтой вэ?

- A. Шалтгааныг олох
- B. Өвчний үе шатыг тодорхойлох
- C. Эмчилгээг сонгох
- D. Хүндрэлийг тодорхойлох
- E. Ялган оношлох

/102./ Аль нь X хам шинж вэ?

A. Стенокардийн өвдөлт илэрсэн боловч миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй

B. Стенокардийн өвдөлт илэрч, сийвэнд ферментийн идэвхжил ихэссэн боловч титэм судасны рентген шинжилгээ хэвийн

C. Стенокардийн өвдөлт илэрч, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй боловч титэм судасны рентген шинжилгээ эмгэг өөрчлөлттэй

D. Стенокардийн өвдөлттэй, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илэрсэн боловч титэм судасны рентген шинжилгээ хэвийн

E. Стенокардийн өвдөлтгүй, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй боловч титэм судасны рентген шинжилгээ эмгэг өөрчлөлттэй

**АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙГ 2019 ОНЫ  
ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ХҮНИЙ ИХ ЭМЧ МЭРГЭЖЛЭЭР ТӨГСӨГЧДИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН ЖИШИГ СОРИЛ - II**

Сорилын зөв хариулт

1-B, 2-E, 3-C, 4-C, 5-B, 6-C, 7-A, 8-B, 9-D, 10-C, 11-B, 12-B, 13-B, 14-C, 15-D, 16-A, 17-A, 18-C, 19-C, 20-B, 21-A, 22-C, 23-A, 24-C, 25-D, 26-E, 27-B, 28-B, 29-D, 30-C, 31-C, 32-C, 33-A, 34-A, 35-D, 36-B, 37-C, 38-C, 39-B, 40-D, 41-D, 42-C, 43-B, 44-B, 45-A, 46-D, 47-A, 48-A, 49-E, 50-B, 51-C, 52-E, 53-A, 54-A, 55-E, 56-E, 57-E, 58-E, 59-E, 60-E, 61-E, 62-C, 63-E, 64-E, 65-E, 66-A, 67-E, 68-A, 69-E, 70-E, 71-E, 72-E, 73-A, 74-C, 75-A, 76-C, 77-E, 78-E, 79-C, 80-A, 81-D, 82-C, 83-A, 84-E, 85-C, 86-D, 87-D, 88-E, 89-C, 90-A, 91-C, 92-C, 93-C, 94-A, 95-C, 96-B, 97-C, 98-B, 99-C, 100-B, 101-B, 102-E, 103-B, 104-B, 105-B, 106-C, 107-A, 108-B, 109-C, 110-C, 111-A, 112-C, 113-D, 114-C, 115-A, 116-E, 117-D, 118-A, 119-A, 120-E, 121-A, 122-C, 123-B, 124-D, 125-A, 126-D, 127-E, 128-D, 129-D, 130-C, 131-E, 132-E, 133-E, 134-C, 135-E, 136-C, 137-B, 138-B, 139-B, 140-D, 141-D, 142-A, 143-C, 144-B, 145-B, 146-C, 147-E, 148-A, 149-B, 150-E, 151-E, 152-E, 153-A, 154-E, 155-E, 156-E, 157-A, 158-C, 159-D, 160-D, 161-B, 162-E, 163-A, 164-A, 165-A, 166-A, 167-C, 168-E, 169-E, 170-C, 171-A, 172-D, 173-A, 174-E, 175-E, 176-E, 177-A, 178-E, 179-A, 180-A, 181-A, 182-C, 183-A, 184-A, 185-D, 186-C, 187-C, 188-A, 189-E, 190-E, 191-C, 192-D, 193-E, 194-E, 195-C, 196-E, 197-A, 198-C, 199-E, 200-E, 201-D, 202-D, 203-A, 204-D, 205-E, 206-C, 207-A, 208-E, 209-C, 210-A, 211-C, 212-E, 213-A, 214-D, 215-A, 216-A, 217-D, 218-D, 219-C, 220-C, 221-A, 222-A, 223-A, 224-B, 225-C, 226-C, 227-D, 228-A, 229-E, 230-A, 231-B, 232-B, 233-C, 234-D,

235-D, 236-C, 237-D, 238-D, 239-D, 240-E, 241-D, 242-E, 243-D, 244-D, 245-B, 246-D,  
247-B, 248-D, 249-D, 250-D, 251-E, 252-C, 253-D, 254-C, 255-C, 256-C, 257-C, 258-A,  
259-C, 260-A, 261-E, 262-E, 263-A, 264-E, 265-C, 266-E, 267-E, 268-C, 269-A, 270-A,  
271-E, 272-A, 273-E, 274-A, 275-A, 276-C, 277-A, 278-A, 279-C, 280-A, 281-E, 282-E,  
283-C, 284-A, 285-D, 286-D, 287-C, 288-A, 289-A, 290-C, 291-A, 292-C, 293-A, 294-C,  
295-C, 296-A, 297-C, 298-A, 299-E, 300-C, 301-A, 302-A, 303-C, 304-A, 305-E, 306-A,  
307-D, 308-A, 309-A, 310-C, 311-E, 312-A, 313-E, 314-A, 315-A, 316-E, 317-A, 318-A,  
319-C, 320-D, 321-E, 322-A, 323-A, 324-A, 325-E, 326-C, 327-D, 328-E, 329-D, 330-A,  
331-A, 332-E, 333-A, 334-A, 335-D, 336-A, 337-B, 338-A, 339-C, 340-A, 341-A, 342-A,  
343-A, 344-A, 345-C, 346-E, 347-E, 348-A, 349-C, 350-E, 351-B, 352-A, 353-A, 354-A,  
355-E, 356-C, 357-A, 358-D, 359-A, 360-A, 361-E, 362-D, 363-A, 364-A, 365-A, 366-E,  
367-E, 368-A, 369-E, 370-A, 371-A, 372-A, 373-A, 374-C, 375-E, 376-C, 377-D, 378-C,  
379-C, 380-C, 381-D, 382-B, 383-A, 384-C, 385-C, 386-B, 387-E, 388-D, 389-D, 390-B,  
391-B, 392-C, 393-E, 394-C, 395-A, 396-B, 397-A, 398-A, 399-A, 400-C, 401-B, 402-B,  
403-E, 404-E, 405-C, 406-E, 407-A, 408-D, 409-D, 410-E, 411-B, 412-D, 413-B, 414-C,  
415-B, 416-B, 417-B, 418-D, 419-B, 420-C, 421-D, 422-E, 423-C, 424-C, 425-D, 426-C,  
427-D, 428-E, 429-A, 430-E, 431-B, 432-D, 433-C, 434-B, 435-C, 436-A, 437-A, 438-A,  
439-C, 440-C, 441-A, 442-E, 443-E, 444-C, 445-E, 446-E, 447-E, 448-D, 449-E, 450-D,  
451-C, 452-B, 453-D, 454-B, 455-E, 456-C, 457-A, 458-D, 459-B, 460-A, 461-A, 462-E,  
463-C, 464-B, 465-B, 466-A, 467-A, 468-A, 469-D, 470-A, 471-E, 472-A, 473-B, 474-D,  
475-A, 476-B, 477-C, 478-A, 479-A, 480-D, 481-A, 482-E, 483-A, 484-C, 485-A, 486-D,  
487-C, 488-C, 489-C, 490-B, 491-C, 492-C, 493-A, 494-D, 495-B, 496-C, 497-A, 498-A,  
499-C, 500-C, 501-D, 502-A, 503-A, 504-A, 505-C, 506-C, 507-E, 508-B, 509-B, 510-E,  
511-E, 512-B, 513-A, 514-C, 515-E, 516-E, 517-B, 518-B, 519-A, 520-E, 521-D, 522-B,  
523-E, 524-C, 525-D, 526-B, 527-A, 528-B, 529-C, 530-A, 531-D, 532-D, 533-B, 534-D,  
535-A, 536-C, 537-C, 538-B, 539-C, 540-D, 541-C, 542-A, 543-E, 544-D, 545-E, 546-A,  
547-A, 548-C, 549-B, 550-C, 551-B, 552-E, 553-B, 554-C, 555-B, 556-A, 557-C, 558-B,  
559-B, 560-A, 561-D, 562-C, 563-E, 564-A, 565-C, 566-D, 567-B, 568-C, 569-E, 570-A,  
571-E, 572-B, 573-C, 574-B, 575-B, 576-D, 577-C, 578-B, 579-C, 580-D, 581-C, 582-A,  
583-C, 584-C, 585-E, 586-B, 587-A, 588-C, 589-A, 590-A, 591-B, 592-B, 593-D, 594-C,  
595-E, 596-C, 597-D, 598-D, 599-E, 600-C, 601-D, 602-C, 603-C, 604-A, 605-C, 606-C,  
607-E, 608-D, 609-E, 610-E, 611-C, 612-C, 613-D, 614-C, 615-D, 616-A, 617-A, 618-E,  
619-C, 620-C, 621-D, 622-E, 623-A, 624-D, 625-C, 626-D, 627-D, 628-A, 629-E, 630-A,  
631-D, 632-A, 633-A, 634-D, 635-C, 636-B, 637-D, 638-C, 639-A, 640-C, 641-C, 642-C,  
643-C, 644-E, 645-C, 646-A, 647-A, 648-C, 649-C, 650-E, 651-C, 652-E, 653-A, 654-B,  
655-A, 656-A, 657-C, 658-E, 659-E, 660-E, 661-C, 662-A, 663-A, 664-E, 665-A, 666-E,  
667-A, 668-C, 669-A, 670-A, 671-E, 672-E, 673-A, 674-E, 675-C, 676-E, 677-A, 678-E,  
679-E, 680-E, 681-B, 682-E, 683-A, 684-E, 685-D, 686-A, 687-D, 688-C, 689-E, 690-D,  
691-E, 692-A, 693-B, 694-A, 695-D, 696-A, 697-C, 698-B, 699-E, 700-C,

### Сорил хариулах заавар

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
  - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (А.)
  - Зөв, Зөв, Буруу (В.)
  - Зөв, Буруу, Буруу (С.)

Буруу, Зөв, Буруу (D.)  
Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Багтрааны гурвал шинжийг нэрлэнэ үү:

- A. Эритроцит+лейкоцит+салс
- B. Эозинофил+Куршманы мушгиа+Шарко-Лейдены талст
- C. Лейкоцит+эритроцит+эпителийн эсүүд
- D. Гематогены талст+эозинофил+эпителийн эсүүд
- E. Лейкоцит+эозинофил+эпителийн эсүүд

/2./ Уушгины архаг бөглөрөлт өвчний цочмог сэдрэлийн үед:

- A. Өвчний өдөр тутамд нэг хэвийн илэрч байсан шинжүүд нэмэгдэнэ
- B. Тахикарди эсвэл депресс зэрэг зарим өвөрмөц бус шинжүүд дагалдан гарч болно
- C. Өвчний эхэнд ачаалал даах чадвар буурах эсвэл халуурах шинжүүд илэрч болно
- D. Нийт тохиолдлын талаас дээш хувьд амьсгалын замын халдвараас сэдэрнэ
- E. Эмчилгээнд системийн кортикостероид ба антибиотик хэрэглэнэ

/3./ Өвчтөн Н. Уушгины архаг бөглөрөлт өвчний сэдрэл оноштой эмнэлэгт хэвтсэн. Түүний суурь FEV1 52% \хүндэвтэр явц\, чихрийн шижин хавсарсан. Тэр нэг сарын өмнө уушгины архаг бөглөрөлт өвчний сэдрэлийн улмаас эмнэлэгт хэвтэн амоксилав хэрэглэсэн. Одоо түүнд ямар антибиотик хэрэглэх нь зүйтэй вэ?

- A. Тетрациклин
- B. Триметоприм-сульфаметоксазол
- C. Левофлоксацин
- D. Азитромицин
- E. Ампициллин

/4./ 38 настай тамхи татдаггүй эмэгтэй 6 сарын турш ханиалгасан. Анамнез болон үзлэгт анхаарал татах зүйлгүй. Цээжний рентген зураг болон спирометрийн шинжилгээ хэвийн. Эмчилгээний дараачийн алхам юу байх вэ?

- A. Хамрын дайвар хөндийн рентген зураг авах
- B. Ходоод дурандуулах
- C. Метахолины сорил хийх
- D. Гуурсан хоолой дурандуулах
- E. Кодеин уулгах

/5./ Уушгины архаг бөглөрөлт өвчтэй хүнд агаарын урсгалын саад юутай илүү холбоотой байх вэ?

- A. Гуурсан хоолойн гөлгөр булчин агших
- B. Уушги хийгээр тэлэгдэх
- C. Агаарын жижиг зам үрэвсэж, нарийсах
- D. Агаарын том замын салсын гиперсекреци болох
- E. Хундаган эсүүдийн метаплази үүсэх

/6./ “Шувуун цээж” үүсэх шалтгаан:

- A. Уушгины фиброз
- B. Өвчүүний гаж хөгжил
- C. Сульдаа өвчин
- D. Уушгины гипоплази
- E. Уушгины эмфизем

/7./ 23 настай эмэгтэй хоногийн өмнөөс ханиалгаж, халуурч байгаа өвчтөнд чагналтаар баруун уушгины доод хэсэгт ширүүссэн амьсгал, нойтон хэржигнүүр тодорхойлогдсон бол эхний ээлжинд ямар шинжилгээ төлөвлөх вэ?

- A. Цээжний эгц ба хажуу рентген зураг
- B. Цээж гэрэлд харуулах
- C. Цээжний компьютерт томографи
- D. Цэрэнд хүчилд тэсвэртэй нян хайх
- E. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ

/8./ Эмнэлгийн бус нөхцөлд үүссэн уушгины дэлбэнгийн үрэвслийн хамгийн элбэг тохиолддог үүсгэгч бол:

- A. Staphylococcus aureus
- B. Streptococcus pneumoniae
- C. Pseudomonas aeruginosa
- D. Proteus
- E. Streptococcus viridans

/9./ Хөхрөлт үүсэх механизм:

- A. Гемоглобин буурах
- B. Захын судас нарийсах
- C. Захын судас тэлэх
- D. Оксигемоглобин буурах
- E. Эритропени

/10./ Пневмотораксын үед илрэх нийтлэг шинжийг нэрлэнэ үү.

- A. Ханиалгана
- B. Аюулхайд өвдөнө
- C. Цээж өвдөх, амьсгаадах
- D. Цустай цэрээр ханиах
- E. Тогшилтоор хэнгэргэн дуутай байх

/11./ Уушгины архаг бөглөрөлт өвчний үед ямар хэлбэрийн эмфизем үүсэх вэ

- A. Периацинар
- B. Центриацинар
- C. Иррегуляр
- D. Панацинар
- E. Викар

/12./ Уушгины артерийн том хэмжээний бүлэнт бөглөрлийн эмчилгээний чухал бүрэлдэхүүн хэсэг бол:

- A. Өвдөлтийг намдаах
- B. Фибринолитик эмчилгээг эрт эхлэх
- C. Антикоагулянт эмчилгээг эрт эхлэх
- D. Эуфиллин тарих
- E. Гуурсан хоолойн нарийслыг арилгах

/13./ Анафилаксийн үеийн антиген юу байж болох вэ?

- A. Вирус
- B. Ургамлын тоосонцор
- C. Шилжүүлэн суулгасан эрхтэн
- D. Нян
- E. Гаптен

/14./ Буглааны хөндийд гарах шингэний түвшин юутай холбоотой байх вэ?

- A. Хөндийд сорвижлын өөрчлөлт гарах
- B. Хөндийн эргэн тойронд сорвижлын өөрчлөлт гарах
- C. Дренажийн гуурсан хоолой байх
- D. Уушгины үрэвсэл хавсрах
- E. Өвчний явцын онцлог

/15./ I зэргийн амьсгалын дутагдлын эмнэлзүйн үндсэн шинж бол:

- A. Гадаад амьсгалын үйл ажиллагааны үзүүлэлтүүд хэвийн хэмжээнээс хазайх
- B. Хөхрөх \артерийн гипоксеми үүсэх\
- C. Амьсгалын туслах булчингуудын гипертрофи
- D. Урьд нь даадаг байсан ачаалалд амьсгааддаг болох
- E. Амьсгалын булчингуудын биоцахилгаан идэвх нэмэгдэх

/16./ Т-супрессорын үндсэн үүрэг бол:

- A. Антителын үүсэлтийг зогсооно
- B. Антителын үүсэлтийг нэмэгдүүлнэ
- C. Эс хордуулах үйлчилгээ үзүүлнэ
- D. Лимфокины нийлэгжилтийг зохицуулна
- E. Макрофагийн хавдрын эсрэг идэвхийг нэмэгдүүлнэ

/17./ Гадаад амьсгалын рестриктив хэлбэрийн дутагдал юутай холбоотой үүсдэг вэ?

- A. Уушгины сунамхай чанар багасах



- B. Гистамины үйлчлэл
- C. Гуурсан хоолойн салсын гиперсекреци
- D. Гуурсан хоолойн салст бүрхүүл зузаарах
- E. Уушгины перфузи багасах

/18./ Рестриктив хэлбэрийн агааржилтын дутагдлын үед уушгины агааржилтын ямар үзүүлэлт багасах нь ач холбогдолтой вэ?

- A. Амьсгалын эзлэхүүн
- B. Уушгины үлдэгдэл агаарын эзлэхүүн
- C. Уушгины амьдралын багтаамж
- D. Уушгины нийт багтаамж
- E. Уушгины үйл ажиллагааны үлдэгдэл багтаамж

/19./ Гялтангийн шингэнд ямар эс давамгайлах тохиолдолд хурц үрэвслийн тухай бодож болох вэ?

- A. Лимфоцит
- B. Эозинофил
- C. Нейтрофил
- D. Эритроцит
- E. Моноцит

/20./ Насанд хүрэгсдийн цочмог дистресс хам шинжийн үед дараах шинж зайлшгүй гарна:

- A. Уушгинд жижиг голомтот сүүдэр гарах
- B. Уушгины уян харимхай чанар буурах
- C. САмьсгалын минутын эзлэхүүн буурсан фон дээр оксигенаци хэвийн байх
- D. PaCO<sub>2</sub> ихсэх
- E. Уушгины бүлэнт бөглөрөл

/21./ Багтрааны үед амьсгалын замын бөглөрөл үүсэх механизм бол:

1. Гуурсан хоолойд цэр хуримтлагдах
2. Гуурсан хоолойн гөлгөр булчин агших
3. Гуурсан хоолойн салст бүрхүүл хавагнах
4. Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолойн дискинези
5. Перибронхийн үрэвсэл

/22./ Уушгины буглааны рентген шинжийг нэрлэнэ үү:

- A. Зах, ирмэг нь тодорхой дугуй сүүдэр
- B. Агаар агуулсан нимгэн ханатай хөндий
- C. Шингэний түвшинтэй хөндий
- D. Их хэмжээний сүүдэр үүссэн фон дээр олон тооны хөндий гарсан
- E. Зах, ирмэг нь тодорхой бус, нэг төрлийн бус дугуй сүүдэр

/23./ Сүрьеэгийн каверныг уушгины буглаанаас ялгах шинжийг тодорхойлно уу:

- A. Хөндий цацагдсан голомтуудын хамт
- B. Гөлгөр ханатай, шингэний түвшинтэй хөндий
- C. Цустай цэр гарна
- D. Хордлогын шинж
- E. Эритроцитын тунах хурд ихсэх

/24./ Уушгины цус алдалтын гол аюул юунд орших вэ?

- A. Амьсгалын хурц дутагдал
- B. Геморрагийн шок
- C. Аспираци, асфикси
- D. Халдвар нэгдэх
- E. Зүрхний хурц дутагдал

/25./ Пиквикийн хам шинжийн үед уушгины ямар өөрчлөлт уушги-зүрхний хам шинж үүсэхэд нөлөөлөх вэ?

- A. Пневмосклероз
- B. Уушгины эмфизем
- C. Ателектаз
- D. Цулцангийн гиповентиляци
- E. Уушгины судасны гэмтэл

/26./ Цустай цэр гарах үед ямар арга хэмжээ авах вэ?

- A. Цус юүлэх
- B. Викасол
- C. Аминокапроны хүчил
- D. Ханиалга дарах
- E. Шалтгаан тодруулах шинжилгээ хийх

/27./ Уушгины артерийн бүлэнт бөглөрлийн үед дараахаас бусад шинжүүд гарна:

- A. Гипоксеми
- B. Перикардын шүргэлцэх чимээ
- C. Гиперкапни
- D. Баруун ховдлын дутагдал
- E. Гүний венийн тромбоз

/28./ Тархмал хуурай хэржигнүүр сонсогдох нь ямар эмгэг өөрчлөлттэй холбоотой байдаг вэ?

- A. Уушгин дахь агаарын хэмжээ ихсэх
- B. Гуурсан хоолойн аргаар дамжилт алдагдах
- C. Уушгинд хөндий үүсэх
- D. Уушгины завсрын эдийн үрэвсэл
- E. Уушгинд нэвчдэс үүсэх

/29./ 30 настай өвчтөнд 2 долоо хоногийн турш бие сулрах, хөлрөх, амархан ядрах, амьсгал авахад хэвлийн баруун талд өвдөх, 38°C халуурах шинж илэрсэн. Үзлэгт амьсгалын тоо 28, пульс минутанд 100 удаа. Цээжний баруун тал амьсгалд хоцорно, тэр талд дууны доргион дамжихгүй, тогшилтоор дүлий чимээтэй, чагнахад баруун доод хэсэгт амьсгал эрс суларсан.

Урьдчилсан онош тавина уу:

- A. Уушгины нэвчдэст сүрьеэ
- B. Плевропневмони
- C. Уушгины ателектаз
- D. Шүүдэст плеврит
- E. Аяндаа үүссэн пневмоторакс

/30./ 25 настай өвчтөнд 3 хоногийн өмнө гэнэт чичрүүлж, хий ханиаж, хэвлийн баруун талд өвдөж, 38.9°C халуурсан. Өвдөлт гүнзгий амьсгал авахад нэмэгддэг. Анамнезд 14 настайгаас тамхи татсан, сүүлийн 10 жил өглөөн цагаар цэртэй ханиалгадаг, сүрьеэтэй хүнтэй контакттай байсан. Үзэхэд цээжний баруун тал амьсгалд хоцорно, баруун дунд хэсгээр тогшилтын дуу дүлий, амьсгал сонсогдохгүй. Урьдчилсан онош тавина уу:

- A. Уушгины доод дэлбэнгийн үрэвсэл
- B. Уушгины доод дэлбэнд байрласан голомтот үрэвсэл
- C. Шүүдэст плеврит
- D. Гуурсан хоолойн архаг үрэвсэл
- E. Уушгины ателектаз

/31./ Уушгины үрэвсэл буглаагаар хүндрэхэд дараахаас бусад хүчин зүйлс нөлөөлж болно.

- A. Ателектаз үүсэх
- B. Чихрийн шижин
- C.  $\alpha$ 1-антитрипсины дутагдал
- D. алкоголизм
- E. Дархлаа дарангуйлагдсан байдал

/32./ 49 настай эмэгтэй бие суларч, ядарна гэсэн зовиуртай. Хүүхэд насандаа сүрьеэгээр өвдсөн. Зүүн талд далны хооронд тогшилтоор бүдэг дуутай, амьсгал суларсан, ханиахад цөөн тооны жижиг цэврүүт нойтон хэржигнүүртэй. Цээжний рентген зураг дээр зүүн уушгины талбайд эгэмний доор 2х3 см дугуй, дунд зэргийн тодролтой, нэг төрлийн бус, голдоо зөв бус хэлбэрийн цайваржилттай. Эргэн тойрны эдэд цөөн тооны голомтот сүүдэртэй. Ямар онош тавих вэ?

- A. Сүрьеэгийн анхдагч бүрдэл
- B. Цээжний хөндийн лимфийн булчирхайн сүрьеэ
- C. Нэвчдэст хэлбэрийн сүрьеэ
- D. Уушгины хавдар
- E. Туберкулём

/33./ Н., 60 настай, өдөрт 30 ширхэг тамхи татдаг. 2 долоо хоногийн турш ханиалгаж, цустай цэр гарч эмчидхандсан. Үзлэг, цээжний рентген зурагт эмгэг өөрчлөлтгүй. Юуны өмнө ямар өвчний тухай бодох вэ?

- A. Гуурсан хоолойн хавдар
- B. Уушгины сүрьеэ
- C. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
- D. Гуурсан хоолойн архаг үрэвсэл
- E. Уушгины үрэвсэл

/34./ Дараахаас бусад өвчний үед гялтангийн болон хэвлийн хөндийд нэгэн зэрэг шингэн хурж болно

- A. Шүүдэст плеврит
- B. Элэгний цирроз
- C. Зүрхний дутагдал
- D. Нефроз хам шинж
- E. Гипоальбуминеми

/35./ Дараахаас бусад нь багтраа өвчнийг тодорхойлно

- A. Багтрал вентолин цацлагаар хэрэглэхэд намдана
- B. Цэрэнд Шарко-Лейдены талст илэрч болно
- C. Уушгины эмфизем үүснэ
- D. Багтрал сунжрахад нойтон хэржигнүүр сонсогдоно
- E. Өвчин аль ч насанд үүсч болно

/36./ Уушгины дэлбэнгийн үрэвслийн үед дараахаас бусад хүндрэл илэрч болно.

- A. Пневмосклероз
- B. Уушгины цус алдалт
- C. Шүүдэст плеврит
- D. Уушгины буглаа
- E. Рестриктив хэлбэрийн амьсгалын дутагдал

/37./ Шүүдэст плевритын үед дараахаас бусад шинжүүд илэрнэ

- A. Эмгэгтэй хэсгийн дээр тогшилтын дуу дүлий болно
- B. Амьсгал болон бронхофони суларна
- C. Голтын эрхтэнүүд эмгэгтэй тал руу шилжиж байрлана
- D. Зүүн талын шүүдэст плевритын үед Траубегийн зай багасна эсвэл алга болно
- E. Дууны доргион суларна

/38./ Уушгины том хэмжээний нээгдсэн буглааны үед дараахаас бусад шинжүүд гарна:

- A. Цэрний хэмжээ ихсэх
- B. Хордлогын шинжүүд багасах
- C. Голомтотнд тогшилтын дуу богиносч, амьсгал суларсан
- D. Голомтонд тогшилтоор хэнгэргэн дуутай, гуурсан хоолойн эсвэл амфорын амьсгалтай
- E. Биеийн халуун буурах

/39./ Анхдагч сүрьеэгийн үед үүссэн шүүдэст плевритын хувьд дараахаас бусад нь онцлог байдаг

- A. Залуу насанд илүүтэй тохиолдоно
- B. Сүрьеэгийн эсрэг эмчилгээг гялтангийн хөндийд шингэн байх үед л хийнэ
- C. Экссудат серозон шинжтэй
- D. Шингэнд лейкоцит цөөн, лимфоцит давамгайлна
- E. Уушгинд өөрчлөлт илрээгүй байна

/40./ Амьсгалын архаг дутагдлын хоёрдогч илрэлд дараахаас бусад шинжүүд илэрнэ

- A. Зүрхний хэм алдагдах
- B. Ухаан санаа өөрчлөгдөх
- C. Эритроцитоз
- D. Гепатомегали
- E. Уушгины артерийн гипертензи

/41./ Харшлын хам шинжид хамаарахгүй шинжийг сонгоно уу

- A. Крапивница
- B. Квинкийн хаван
- C. Цус, цэрэнд эозинофили илрэх

D. Зангилаат эритем

E. Ринит

/42./ Аминофиллины үйлчлэх механизмыг нэрлэнэ үү

A. Вагусын нөлөөг дарангуйлах

B. Харшлын урвалын медиаторт хориг үүсгэх

C. Адренорецепторыг идэвхижүүлэх

D. Амьсгалын төвийг дарангуйлах

E. бветта2-рецепторыг идэвхжүүлэх

/43./ Дараах шинжээс бусад нь багтраат байдлын үед илэрнэ:

A. Парадоксаль пульс

B. Хуурай хэржигнүүр нэмэгдэх

C. Хурц уушги-зүрхний хам шинж

D. Цээжний хэнхэрцэг хийгээр тэлэгдэж, займчих хөдөлгөөн багасах

E. Цэр хуримтлагдах

/44./ БЦЖ вакциныг

A. Арьсан дор тарина

B. Арьсанд тарина

C. Булчинд тарина

D. Уулгана

E. Хамарт дусаана

/45./ 24 настай, ямар нэгэн зовиургүй эмэгтэйн баруун уушгинд зах, ирмэг нь тодорхой, нимгэн ханатай хөндий тодорхойлогдоно. Эргэн тойрны эдэд эмгэг өөрчлөлтгүй, цэрэнд сүрьеэгийн савханцар илрээгүй. Ямар өвчний тухай бодох вэ?

A. Уушгины уулинхай

B. Сүрьеэгийн каверна

C. Актиномикоз

D. Уушгины буглаа

E. Аспергиллём

/46./ Ямар өвчний үед эвгүй үнэртэй цэр гарах вэ?

A. Гуурсан хоолойн цочмог үрэвсэл

B. Багтраа

C. Уушгины үрэвсэл

D. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин

E. Хөндийт сүрьеэ

/47./ Милиар сүрьеэ үүсэх үндсэн механизм бол:

A. Цусаар

B. Гуурсан хоолойгоор

C. Лимфээр

D. Лимф-гуурсан хоолойгоор

E. Цус-гуурсан хоолойгоор

/48./ Милиар сүрьеэгийн үед уушгинд гарах голомтот сүүдрийн онцлог

A. Жижиг, нэг хэвийн

B. Уушгины оройд, янз бүрийн хэмжээтэй

C. Уушгины нийт талбайд, янз бүрийн хэмжээтэй

D. Уушгины оройд 6 мм хүртэл хэмжээтэй

E. Уушгины талбайн доод хэсэгт 6 мм хүртэл хэмжээтэй

/49./ Уушгины тархмал сүрьеэгийн үед хамгийн элбэг гэмтэх эрхтэн бол

A. Яс

B. Бөөр

C. Гэдэс

D. Дэлүү

E. Серозон бүрхүүл

/50./ Өвчний явц хурц байх, нойтон хэржигнүүр сонсогдох, уушгины талбайн дунд, доод хэсэгт зөөлөн, жижиг голомтот сүүдэр тодорхойлогдох, эерэг динамик хурдан гарах тохиолдолд ямар эмгэгийн тухай бодох вэ?

A. Уушгины милиар сүрьеэ

- B. Уушгины голомтот үрэвсэл
- C. Саркоидоз
- D. Пневмокониоз
- E. Аденоматоз

/51./ Ямар байрлалтай фибринозон плевритын үед цээжний өвдөлт илрэхгүй байж болох вэ?

- A. Оройн
- B. Өрцний дээр
- C. Дэлбэн завсрын
- D. Хавирга дагасан
- E. Парамедиастиналь

/52./ Туберкулём ихэвчлэн юуны суурин дээр үүсдэг вэ?

- A. Цээжний хөндийн лимфийн булчирхайн сүрьеэ
- B. Фиброзон-хөндийт сүрьеэ
- C. Сушгины тархмал сүрьеэ
- D. D. Уушгины нэвчдэст сүрьеэ
- E. Уушгины голомтот сүрьеэ

/53./ 54 настай эрэгтэй амьсгаадна, цээж өвдөнө гэсэн зовиуртай. Өвдөлт нэмэгдэх хандлагатай. Цээжний рентген шинжилгээнд баруун уушгины дунд дэлбэнд 2 см голчтой нэг төрлийн, зах, ирмэг нь тодорхой бус, угтай холбоотой тод сүүдэр тодорхойлогдоно. Ямар онош тавих вэ?

- A. Уушгины хорт хавдар
- B. Туберкулём
- C. Бэтэг
- D. Уушгины үрэвсэл
- E. Уушгины буглаа

/54./ Уушгины архаг бөглөрөлт өвчний гол эрсдэлт хүчин зүйл бол:

1. Тамхины утаа
2. Гэрийн доторх агаарын бохирдол
3. Ажлын тоостой нөхцөл
4. Сүрьеэ
5. Өндөр нас

/55./ Уушгины архаг бөглөрөлт өвчний оношийг дараах шинжүүдийн үндсэн дээр сэжиглэж болно:

1. Тогтвортой амьсгаадах, цээж шуугих, ханиаж, цэр гарах
2. Удаан хугацаанд тамхи татсан байх
3. Өвчин аажим даамжрах
4. Өвчтөн 50-иас дээш настай байх
5. Гуурсан хоолой бөглөрөх шинж бүрэн арилахгүй байх

/56./ Спирометри нь:

1. Уушгины архаг бөглөрөлт өвчнийг оношлох, гуурсан хоолойн бөглөрлийн хүндийн зэргийг тодорхойлох ач холбогдолтой

2. Амьсгал гаргах дээд хурдыг тодорхойлно
3. Ингаляцийн гуурсан хоолой тэлэгч эмийг хангалттай тунгаар хэрэглэсний дараа давтан хийгдэнэ
4. Уушгины үйл ажиллагааны бууралтыг хянах боломж олгоно
5. Уушгины архаг бөглөрөлт өвчин ба багтрааны ялган оношлогоонд ач холбогдолтой

/57./ Тамхинаас гарахад туслах үр дүнтэй аргад:

1. Никотин орлуулах эмчилгээ
2. Өвчтөнд зөвлөгөө өгөх
3. Өөрөө өөртөө туслах хөтөлбөрүүд
4. Нийгэмд суурилсан тамхинаас гарах арга хэмжээ
5. Бүлгээр тамхинаас гарах хөтөлбөрүүд

/58./ Уушгины архаг бөглөрөлт өвчний намжмал үед хийгдэх эмийн эмчилгээнд ямар эмүүд сонгодог вэ?

1. Богино хугацааны үйлдэлтэй ингаляцийн  $\beta_2$ -агонист
2. Богино хугацааны үйлдэлтэй ингаляцийн антихолинерг

3. Ингальяцийн глюкокортикои
4. Ингальяцийн гуурсан хоолой тэлэх эм ба глюкокортикоидын хавсарсан эмчилгээ
5. Урт хугацааны үйлдэлтэйингальяцийн антихолинерг

/59./ Өвчтөн Д. 20 хайрцаг\жил тамхи татсан анамнезтай, бага зэрэг хаиаж, цэр гардаг. Түүний FEV1 \FVC 0.69 ба FEV1 81%. Энэ өвчтөний зохистой эмчилгээнд юу багтах вэ?

1. Тамхинаас гарахыг зөвлөх, арга замыг зааж өгөх
2. Жил бүр томуугийн вакцин хийлгэж байх
3. Богино үйлдэлтэй  $\beta$ 2-агонистыг шаардлагатай үед хэрэглэх
4. Сэргээн засах эмчилгээ
5. Богино үйлдэлтэй антихолинерг эмийг шаардлагатай үед хэрэглэх

/60./ Э. 65 настай. 15 жилийн өмнө түүнд уушгины архаг бөглөрөлт өвчин оношлогдсон. Ихэнх хугацаанд өвчин намжмал байдалтай байсан боловч одоогоор ойр ойрхон сэдэрч, сүүлийн сэдрэлийн улмаас эмнэлэгт хэвтсэн. Сэдрэлээс сэргийлэх арга хэмжээнд юу орох вэ?

1. Тамхи татахыг зогсоох
2. Жил бүр томуугийн вакцин хийлгэх
3. Пневмококкийн вакцин хийлгэх
4. Эмчийн зааврыг биелүүлэх
5. Эмээ зөв хэрэглэх арга техникт сургах

/61./ Уушгины суурь хэсэгт тогшилтын дуу дүлий болох шалтгааныг нэрлэнэ үү:

1. Шүүдэст плеврит
2. Гялтангийн наалдац
3. Уушгины нэвчдэс
4. Уушгины коллапс
5. Өрц дээр байрлах

/62./ Транссудатын шалтгааныг сонгоно уу.

1. СКВ
2. Нефроз хам шинж
3. Лимфом
4. Гипотиреоз
5. Сүрьеэ

/63./ Гялтангийн шингэнд лимфоцитоз гарсан тохиолдолд ямар эмгэгийн тухай бодож болох вэ?

1. Сүрьеэ
2. Холбогч эдийн эмгэгүүд
3. Уушгины хавдар
4. Лимфом
5. Саркоидоз

/64./ Гялтангийн хөндийд цусархаг шингэн хурах шалтгааныг нэрлэнэ үү.

1. Уушгины хавдар
2. Уушгины артерийн бүлэнт бөглөрөл
3. Уушгины сүрьеэ
4. Цээжний гэмтэл
5. Гепарин эмчилгээ

/65./ Цээжний хэт авиан шинжилгээний ач холбогдлыг нэрлэнэ үү.

1. Уутлагдсан шингэнийг оношлох
2. Торацентез хийх цэг сонгох
3. Гялтангийн биопси хийх
4. Гялтангийн шингэн ба наалдацыг ялгах
5. Гялтангийн хөндийд гуурс тавих

/66./ Дараах эмүүд гялтангийн хөндийд шингэн хурахад нөлөөлж болно.

1. Прокарбазин
2. Нитрофурантоин
3. Метотрексат
4. Амоксиклав
5. Диклофенак

/67./ Багтрах шинжээр илэрдэг эмгэгийг нэрлэнэ үү.

1. Уушгины архаг бөглөрөлт өвчин
2. Зүүн ховдлын дутагдал
3. Уушгины эозинофилт өвчин
4. Зангилаат полиартериит
5. Уушгины артерийн дахилтат бүлэнт бөглөрөл

/68./ Уушгины архаг бөглөрөлт өвчний үед гуурсан хоолойн бөглөрөл үүсэх механизмыг нэрлэнэ үү:

1. Гуурсан хоолойн ханын үрэвсэл
2. Цулцангийн ханын уян харимхай чанар буурах
3. Гуурсан хоолой цэр, салсаар бөглөрөх
4. Диффузлэх талбайн хэмжээ буурах
5. Перибронхийн эдийн үрэвсэл

/69./ Уушгины үрэвслийн нэвчдэс “удаан” шимэгдэж байх шалтгааныг нэрлэнэ үү

1. Уушгины хавдар
2. Гуурсан хоолойн гадны биет
3. Уушгины сүрьеэ
4. Антибиотик эмчилгээ оновчтой бус байх
5. Уушгины секвестр

/70./ Уушгины үрэвслийн нийтлэг бус үүсгэгч юу вэ?

1. Микоплазм
2. Легионелл
3. Хламиди
4. Томуугийн вирус
5. Цитомегаловирус

/71./ Уушгины фиброз үүсэх шалтгааныг дурьдана уу:

1. Ревматоид артрит
2. Пневмокониоз
3. Саркоидоз
4. Туяа эмчилгээ
5. Уушгины архаг хаван

/72./ Нойрсох үеийн бөглөрөлт анноэ оношлогдсон өвчтөнд ямар эмчилгээ хийж болох вэ?

1. Мэс засал эмчилгээ
2. Эмийн эмчилгээ
3. Хамраар СРАР
4. Биеийн жинг бууруулах
5. Тамхи, архи хэрэглэхээс татгалзах

/73./ 28 настай эмэгтэй. Ханиалгаж, 50 мл орчим цус гарсан. Юуны өмнө ямар эмгэгийн тухай бодож болох вэ?

1. Уушгины сүрьеэ
2. Төрөлхийн артери-венийн холбоос
3. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
4. Уушгины хорт хавдар
5. Муковисцидоз

/74./ Торх хэлбэрийн цээж үүсэх шалтгаан:

1. Уушгины сүрьеэ
2. Уушгины эмфизем
3. Цээжний булчингийн миастени
4. Уушгины архаг бөглөрөлт өвчин
5. Өвчүүний гаж хөгжил

/75./ Эмнэлгийн бус нөхцөлд үүссэн уушгины голомтот үрэвслийн хамгийн элбэг тохиолддог шалтгаан бол:

1. *Staphylococcus aureus*
2. *H. influenzae*
3. *Streptococcus pneumoniae*
4. *E.coli*

5. Pseudomonas aeruginosa

/76./ 16 настай гуурсан хоолой тэлэгдэх өвчний шинж илэрсэн хүүд ямар шинж илэрвэл Картагенерын хам шинж сэжиглэж болох вэ?

1. Стеаторея
2. Декстракарди
3. Уушгины артерийн нарийсал
4. Синусит
5. Багтраа

/77./ Цээжээр өвдөх механизмыг нэрлэнэ үү.

1. Гялтанд байрлах өвдөлтийн рецептор цочрох
2. Хавирга завсрын мэдрэлийн үрэвсэл
3. Цээжний гэмтэл
4. Хэвлийн өвдөлт цээж рүү дамжих
5. Цээжний радикулит

/78./ Багтраа болон уушгины архаг бөглөрөлт өвчний нийтлэг шинжүүдийг нэрлэнэ үү:

1. Ханиалгана
2. Цээж шуугина
3. Амьсгаадна
4. FEV1 жилд J 30 мл-ээр буурна
5. Бронхолитик эмийн сорил эерэг байна

/79./ Уушгины хаван үүсэх механизмыг нэрлэнэ үү:

1. Уушгины артерийн даралт ихсэх
2. Судасны ханын нэвчимхий чанар ихсэх
3. Уушгины перфузи багасах
4. Уушгины венийн гидростатик даралт ихсэх
5. Уушгины шунт үүсэх

/80./ Багтрааны оношийг батлах зорилгоор ямар шинжилгээ төлөвлөх вэ?

1. Spiroграфи
2. Метахолины сорил
3. Гуурсан хоолой тэлэгч эмийн сорил
4. Цээжний рентген шинжилгээ
5. Бронхоскопи

/81./ Уушгины эмфиземийн оношийг батлах зорилгоор ямар шинжилгээ төлөвлөх вэ?

1. Цэрний шинжилгээ
2. Уушгины эдийн шинжилгээ
3. Биеийн плетизмографи
4. Өндөр нарийвчлалтай компьютерт томографи (HRCT)
5. Эхокардиографи

/82./ Шалтгаан тодорхой бус уушгины фиброзон альвеолитын үед ямар эмчилгээ хэрэглэх заалттай байх вэ?

1. Дааврын бус гаралтай үрэвслийн эсрэг эм
2. Системийн кортикостероид
3. Халдварын эсрэг эм
4. Цитостатик
5. Дархлаа дэмжих

/83./ Уушгины архаг бөглөрөлт өвчин үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү:

1. Тамхи
2. Ажлын тоостой нөхцөл
3. Агаарын бохирдол
4. Амьсгалын замын цочмог халдвар
5. Уушгины үрэвсэл

/84./ Дараах эмгэг архаг уушги-зүрхний хам шинж үүсгэж болно.

1. Уушгины саркоидоз
2. Уушгины архаг бөглөрөлт өвчин
3. Уушгины хурц бөглөрөлт өвчин
4. Уушгины артерийн дахилтат бүлэнт бөглөрөл



5. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
- /85./ Ямар эмгэгийн үед цэрэнд уян ширхэг тодорхойлогдож болох вэ?
1. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
  2. Уушгины задарсан хавдар
  3. Уушгины үхшил
  4. Уушгины буглаа
  5. Уушгины шигдээс
- /86./ Баруун ховдлын хурц дутагдлын хамгийн элбэг тохиолддог шалтгаан бол:
1. Багтрааны сэдрэл
  2. Аяндаа үүсэх пневмоторакс
  3. Уушгины дэлбэнгийн ателектаз
  4. Уушгины артерийн бүлэнт бөглөрөл
  5. Шүүдэст плеврит
- /87./ Силикозын үед хамгийн түгээмэл гардаг ач холбогдол бүхий хүндрэл бол:
1. Уушгины үрэвсэл
  2. Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
  3. Пневмоторакс
  4. Сүрьеэ
  5. Багтраа
- /88./ Гуурсан хоолой тэлэгдэх өвчний үед илрэх шинжүүдийг сонгоно уу:
1. Ханиалгаж, цэр гарна
  2. Дунд цэврүүт нойтон хэржигнүүр сонсогдоно
  3. “Бөмбөрийн цохиур”, “цагны шил”-ний шинж илэрнэ
  4. Нэг газарт давтан хатгаа үүсэх
  5. Багадаа хүүхдийн халдварт өвчин, уушгины үрэвслээр “хүнд” өвдсөн
- /89./ Уушгины дэлбэнгийн үрэвслийн үед ямар шинж тодорхойлогдох вэ?
1. Амьсгал эрс сулрах, эсвэл сонсогдохгүй байх
  2. Бронхофони ба дууны доргион ихсэх
  3. Тогшиход хэргэргэн дуутай байх
  4. Гуурсан хоолойн амьсгал сонсогдох
  5. Бронхофони ба дууны доргион сулрах
- /90./ Уушгины сүрьеэ үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бол:
1. Ходоод, дээд гэдэсний шархлаа
  2. Чихрийн шижин
  3. Силикоз
  4. Лимфогранулематоз
  5. Артерийн гипертензи
- /91./ 25 настай Э. 38 С халуурна, ханиалгана, амьсгаадна, хэвлийн баруун талд хүчтэй өвдөнө гэсэн зовиуртай. Өвдөлт уушгины ямар өвчинтэй холбоотой байж болох вэ?
1. Уушгины хорт хавдар
  2. Баруун талын шүүдэст плеврит
  3. Баруун уушгины доод дэлбэнгийн гуурсан хоолой тэлэгдэх өвчин
  4. Баруун уушгины доод дэлбэнгийн үрэвсэл
  5. Баруун талын пневмоторакс
- /92./ Багтраа сэдэрсэн үед илрэх эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу
1. Нойтон хэржигнүүр
  2. Экспиратор амьсгаадалт
  3. “Чимээгүй уушги
  4. Исгэрсэн хуурай хэржигнүүр
  5. Ширүүссэн амьсгал
- /93./ 58 настай эрэгтэйн уушгины эдэд задарсан хөндий гарч, лимфийн булчирхайнууд томорсон. Онош тодруулах зорилгоор ямар шинжилгээ хийх нь зүйтэй вэ?
1. Цээж гэрэлд харах
  2. Цээжний рентген зураг эгц ба хажуу байрлалд авах
  3. Бронхоскопи хийх
  4. Цээжний компьютерт томографи хийх

5. Цэрний цитологи шинжилгээ хийх

/94./ Цэрэнд эозинофили тодорхойлогдож болох шалтгаан

1. Багтраа
2. Аспергиллём
3. Гадаад шалтгаант харшлын альвеолит
4. Уушгины архаг бөглөрөлт өвчин
5. Уушгины сүрьеэ

/95./ бөөр хамгаалах эмчилгээний багц нь Бөөрний архаг өвчний даамжралыг сэргийлэх ач холбогдолтой юм. Энэ зорилгоор үрэвслийн эсрэг, шээс хөөх үйлдэлтэй олон тооны ургамлын бэлдмэл хэрэглэж бөөрийг хамгаална.

/96./ Хүүхэд жин багатай төрөх нь бөөрний архаг өвчний эрсдэлт хүчин зүйл болдог. Иймд Эхийн хоол тэжээлийн дуталыг шалтгааныг эрт илрүүлэн эмчилснээр үүнийг сэргийлэх боломжтой юм.

/97./ Бөөрний архаг өвчнийг даамжруулдаг эрсдэлт хүчин зүйлсийг зохицуулагдах ба үл зохицуулагдах гэж ангилдаг. Эмнэлэгийн нөхцөлд зохицуулахад бэрхшээлтэй. Амьдарлын буруу хэв маяг, удамшлын хүчин зүйл, хорт зуршил зэргийг үл зохицуулагдах эрсдэлт хүчин зүйлс гэж тодорхойлдог.

/98./ БАӨ-өөр өвдөх эрсдэл өндөртэй хүмүүсийг илрүүлэн хянах нь чухал. Хянахдаа 12 сард 1 удаа хяналтын үзлэг хийхийн зэрэгцээ жилд 2-3 удаа хэвтүүлж эмчилснээр БАӨ-г сэргийлэх боломжтой болдог.

/99./ Нефроз хам шинжийн үед цусанд липид холестерин хэмжээ эрс ихэссэн байдаг. Үүнтэй холбоотой өвчтөний БЖИ маш их ихэссэн, хаван ч бас их байдаг.

/100./ Нефроз хам шинжийн үед шээсээр их хэмжээний уураг алдаснаас цусны уураг багсаж үүнээсээ үүдэн шээсний хувийн жин ч буурдаг.

/101./ Ребергийн сорилоор бөөрний үйл ажиллагааг үзэхэд эрүүл хүмүүст бөөрний сувганцарын эргэн шимэгдэлт нь шөнийн цагт ихэссэн байдаг.

/102./ СРТ нь бөөрний эмгэг судлалын практикт өргөн хэрэглэгддэг хоёр бөөрний үйл ажиллагааг харьцуулан судалдаг рентген шинжилгээний арга мөн.

/103./ Изотопт ренографи нь бөөрний эмгэг судлалын практикт өргөн хэрэглэгддэг хоёр бөөрний үйл ажиллагааг харьцуулан судалдаг рентген шинжилгээний арга мөн.

/104./ БЦД-ын 2-р үед бөөрний цусан хангамж алдагдаж цус эргэлт буурсанаас шээсний хэмжээ багасна. Яагаад гэвэл завсрын эдэд ишеми үүсэж сувганцарын эргэн шимэгдэлт эрс ихэсдэг.

/105./ Люпус нефритын үед шээсэнд уураг, бортгонцор их гарч өвчний эхэн үеэс цусны даралт хоруу явцтай илэрнэ. Энэ нь бөөрөнд хагас саран хэлбэрт өөрчлөлт үүссэнээс түүдгэнцрийн суурь мембран зузаарсантай холбоотой

/106./ Архаг гломерулонефритын эмнэлзүйн аль ч хэлбэрийн үед бөөрний түүдгэнцэрт дархлалын үрэвсэл явагдана. Тийм ч учраас эмчилгээнд үрэвслийн эсрэг үйлдэлтэй антибиотик сонгон хэрэглэнэ.

/107./ Зимницкийн сорилоор бөөрний үйл ажиллагааг үзэхэд эрүүл хүмүүст өдөр шөнийн шээс 4:1 харьцаатай байдаг. Шөнийн шээсний хэмжээ бага байдаг нь бөөрний сувганцрын эргэн шимэгдэлт нь шөнийн цагт ихэссэн байдагтай холбоотой.

/108./ Бөөрний цочмог дутагдлын III үед түүдгэнцрийн шүүлт сэргэж, сувганцрын регенараци явагдана. Сувганцарын регенарацитай холбоотой сувганцарт К-ийн эргэн шимэгдэлт ихсэж өвчтөнд гиперкалиемийн шинж илэрч их шээнэ.

/109./ Өвчтөн Л. эр, 28 настай хавагнан, шээсний шинжилгээнд протеинури 3,75г/л, Рентген шинжилгээнд архаг остеомиелит илэрсэн байлаа. Уг өвчтөнд гломерулонефрит онош тавиад кортикостероид эмчилгээг эхэлнэ.

/110./ Өвчтөн О. эм, 26 настай халуурч бөөр нь өвдөж, шээсний шинжилгээнд протеинури 0,35г/л, нян илэрсэн байлаа. Уг өвчтөнд гломерулонефрит онош тавиад кортикостероид эмчилгээг эхэлнэ.

/111./ Архаг пиелонефритээр олон жил өвчилсөн өвчтөнд бөөрний тархилаг эдийн хэмжээ илүүтэйгээр багсаж чанд авиан шинжилгээнд хоёр бөөрний хэмжээ жигд бус жижгэрнэ.

/112./ Пиелонефрит нь халдварын шалтгаантай бөөрний эдийн үрэвсэлт өвчин учир эмчилгээнд стероид үйлдэлтэй үрэвслийн эсрэг эмийг удаан хэрэглэнэ.

- /113./ Гломерулонефрит нь халдварын шалтгаантай бөөрний эдийн үрэвсэлт өвчин учир эмчилгээнд стероид үйлдэлтэй үрэвслийн эсрэг эмийг дундчаар14 хоног хэрэглэнэ
- /114./ Архаг гломерулонефритын далд хэлбэрийн үед бөөр хамгаалах эмчилгээний багцыг хэрэглэнэ. Үүнд стероид үйлдэлтэй үрэвслийн эсрэг эмийг дундчаар1 сар хэрэглэнэ
- /115./ Ангиотензины рецепторын блокатор лизиноприл нь Бөөр хамгаалах бэлдмэл юм. Энэ нь Түүдгэнцрийн дотоод даралт бууруулдаг.
- /116./ Архаг гломерулонефритын цусны даралт ихдэх хэлбэрийн үед преднизолон эмчилгээг, даралт буулгах эмтэй хослуулах нь үр дүнтэй. Учир нь преднизолон нь нянгийн гаралтай үрэвслийг дарахаас гадна, цусны даралтын бууралтыг дэмжинэ.
- /117./ Бөөрний архаг өвчний үл зохицуулагдах эрсдэлт хүчин зүйл
- A. Нас, хүйс, хорт зуршил, удамшлын хүчин зүйл
  - B. Амьдарлын буруу хэв маяг, удамшлын хүчин зүйл, нас, хорт зуршил
  - C. Хорт зуршил, дислипидеми, даралт ихдэлт, эмийн буруу хэрэглээ
  - D. Нас, гарал үүсэл, удамшлын хүчин зүйл, хүйс
  - E. Нас, гарал үүсэл, удамшил, амьдарлын буруу хэв маяг
- /118./ АД ихсэлттэй, ЧШтэй, протейнури илэрсэн өвчтөнд хэрэглэх 1-р сонголтын эм аль нь вэ?
- A. ACE ингибитор
  - B. AT2 рецепторын саатуулагч
  - C. Диуретик
  - D. Кальцийн антагонист
  - E. Бетта блокатор
- /119./ БАӨ үед бөөр хамгаалах зорилгоор хэрэглэдэггүй эмийн бүлэг аль нь вэ?
- A. ACE ингибитор
  - B. AT-2 рецепторын блокатор
  - C. Антиагрегант
  - D. Витамин Д
  - E. Салидоксийн хүчил
- /120./ Бөөрний экскретор урограмд дараах зүйлийг тодруулна
1. Бөөрний байрлал
  2. Бөөрний аяганцар тэвшинцэрийн байдал
  3. Бөөрний хэмжээ
  4. Үйл ажиллагааны байдал
  5. Ренортикаль индекс
- /121./ Шээсний шинжилгээнд ямар төрлийн бортгонцор илэрвэл хэвийн гэж үзэх вэ?
- A. Гиалин
  - B. Зернистый
  - C. Восковидный
  - D. Эритроцитын
  - E. Лейкоцитын
- /122./ Артерийн гипертензийн хожуу үед шээсэнд гарах өөрчлөлт
- A. Лейкоцитури
  - B. Гематури+глюкозури
  - C. Протейнури+гематури
  - D. Оксалатури
  - E. Гипостенури
- /123./ Артерийн гипертензийн нефропатийн эрт үед шээсэнд гарах өөрчлөлт
- A. Лейкоцитури
  - B. Микроальбуминури
  - C. Протейнури+гематури
  - D. Оксалатури
  - E. Гипостенури
- /124./ Диабетийн нефропатийн эрт үед шээсэнд гарах өөрчлөлт
- A. Лейкоцитури
  - B. Гематури+глюкозури
  - C. Протейнури+гематури

- D. Микроальбуминури
  - E. Гипостенури
- /125./ Бенс-Джонсын уураг ямар өвчний үед шээсээр ялгардаг вэ?
- A. Миелом
  - B. Миелолейкоз
  - C. Подагр
  - D. Лимфолейкоз
  - E. Гемофили
- /126./ Преднизолоны сорилоор юуг илрүүлэх вэ?
- A. Далд гематури
  - B. Далд гломерулонефрит илрүүлэх
  - C. Далд протейнуриг илрүүлэх
  - D. БШЗ-ын далд үрэвслийг илрүүлэх
  - E. Дээрхи бүгд
- /127./ Бөөрний архаг дутагдлын үед зайлшгүй хийх шинжилгээг нэрлэнэ үү?
1. Цусан дах креатинин
  2. Цусны PH үзэх
  3. Цусны электролит үзэх
  4. Зимницкийн сорил
  5. ЦЕШ
- /128./ Доплерт сонографи дараахь тохиолдлоос нэгээс бусдад хийх шаардлагатай.
- A. Бөөрний хавдар
  - B. Шалтгаан тодорхойгүй шээс цустах
  - C. Шалтгаан тодорхойгүй даралт ихсэх
  - D. Архаг гломерулонефрит
  - E. Бөөрний унжилт
- /129./ Хоногийн шээсний хэмжээ 100 мл-ээс багасахыг юу гэж нэрлэх вэ ?
- A. Полиури
  - B. Никтири
  - C. Поллакури
  - D. Анури
  - E. Дизури
- /130./ Шээсний доод замын үрэвслийн үед шээс ялгаралтын өөрчлөлтийн аль нь илрэх вэ?
- A. Анури
  - B. Гематури
  - C. Странгури
  - D. Никтури
  - E. Олигури
- /131./ Өдөрт олон удаа шээхийг юу гэж нэрлэх вэ?
- A. Олигоури
  - B. Никтури
  - C. Странгури
  - D. Энурез
  - E. Поллакури
- /132./ Хүүхэд шөнө орондоо шээхийг юу гэж нэрлэх вэ?
- A. Олигоури
  - B. Дизури
  - C. Никтури
  - D. Странгури
  - E. Энурез
- /133./ 1 минутанд ялгарах шэсэнд агуулагдах дүрст элементийг дараахь аргаар шинжилнэ.
- A. Аддис Каковский
  - B. Ребергийн сорил
  - C. Нечипоренкогийн сорил
  - D. Фольгардын сорил
  - E. Амбуржийн сорил

- /134./ Нечипоренкогийн сорилоор
- A. 1 мин-ын диурез бөөрний түүдгэнцэрийн шүүх үйл ажиллагааг үзнэ
  - B. Шингэний ачаалал өгч, бөөрний шингэрүүлэлтийн үйл ажиллагааг үзнэ.
  - C. 1 мл-ын эзэлхүүнд дүрст элементийг тодорхойлно.
  - D. 24 цагийн шээсэнд дүрст элементийг тодорхойлно
  - E. 3,3 цагийн зайтай шээсэнд бөөрний үйл ажиллагааг үзнэ
- /135./ Шээс цустах хам шинж хамгийн их илрэх өвчин
- A. Амилоидоз
  - B. Поликистоз
  - C. Архаг пиелонефрит
  - D. Архаг гломерулонефрит даралт ихдэх хэлбэр
  - E. Бөөрний сүрьеэ
- /136./ Нефрозийн кризийн гол шалтгаан
- A. Цусны даралт ихсэх
  - B. Цустай шээх
  - C. Хэт их хавагнах
  - D. Зүрхний дутагдал
  - E. Тархи хавагнах
- /137./ Нефроз хам шинжийн үед бөөрний дутагдлын оношлогоонд аль нь чухал вэ?
- A. шээсний уургийн хэмжээ
  - B. Сийвэн дэх креатинин
  - C. Сийвэн дэх холестерин
  - D. Сувганцарын эргэн шимэгдэлт
  - E. Протеинурийн түвшин
- /138./ Фольгардын сорилоор дараахь зүйлийг тодорхойлно
- A. 1 мин-ын диурез, бөөрний фильтраци үзэх
  - B. Шингэний ачаалал өгч, бөөрний шингэрүүлэх үйл ажиллагааг үзэх
  - C. 1 мин-ын эзэлхүүнд дүрст элемент тодорхойлох
  - D. 24 цагийн шээсэнд дүрст элемент тодорхойлох
  - E. 3,3 цагийн зайтай шээс цуглуулж бөөрний үйл ажиллагааг үзнэ
- /139./ Доорхи шинж тэмдэгээс нэгээс бусад нь амилоидозын үед гарна
- A. Диаррей
  - B. Дизури
  - C. Шээсний өөрчлөлт
  - D. Хаван
  - E. Ууц нуруугаар өвдөх
- /140./ Хоёрдогч пиелонефритийн үед доорхи шинжүүдээс нэгээс бусад нь илрэнэ
- A. Дизури
  - B. 1мл шээсэнд 100000-аас дээш нян илэрнэ
  - C. Бөөрний аяганцар тэвшинцэрийн деформаци
  - D. Түүдгэнцэрийн шүүлт буурах
  - E. Сувганцрын эргэн шимэгдэлт буурах
- /141./ Архаг гломерулонефритын холимог хэлбэрийн үед илэрдэггүй шинж
- A. Хаван, их хэмжээний транссудат
  - B. Даралт ихдэлт
  - C. Лейкоцитури
  - D. Зимницкийн сорилд шээсний хувийн жин жигд буурсан байх
  - E. Ренографийн шинжилгээнд бөөрний үйл ажиллагаа жигд буурах
- /142./ Шээсний шинжилгээнд гарч буй аль өөрчлөлт нь түүдгэнцэрийн гэмтлийг илүүд илтгэх вэ?
- A. Уураг 3гр/л их
  - B. Уураг 1гр/л бага
  - C. Шээсний хувийн жин 1005 бага
  - D. Шээсний хувийн жин 1025-аас их
  - E. Лейкоцитури
- /143./ Архаг пиелонефритын эмчилгээнд доорхи эмийн бүлгийн нэгээс бусдыг нь хэрэглэнэ

- A. Фторхинолон
  - B. Циклоспорин
  - C. Кортикостероид
  - D. Сульфаниламид
  - E. Налидиксийн хүчлийн бэлдмэлүүд
- /144./ Жирэмсний эрт үед пиелонефритын эмчилгээнд хэрэглэх эм
- A. Нитрофураны бүлэг
  - B. Пенициллины бүлэг
  - C. цефалоспорины бэлдмэлүүд
  - D. Сульфаниламид
  - E. Нитроксолины бүлэг
- /145./ Нечипоренкогийн сорил ямар гарвал өөрчлөлттэй гэж үзэх вэ ?
- A. Бактериури
  - B. Лейкоцитури 2000 дээш
  - C. Лейкоцитури 2000 хүртэл
  - D. Лимфоцитури
  - E. Протейнури 1 гр/л
- /146./ Гликокаликс гэж юуг нэрэлдэг вэ
- A. Подоцитийн элемент
  - B. Мезангиумын элемент
  - C. Суурин мембраны хасах цэнэгтэй хэсгүүд
  - D. Ялгаруулах аппарат
  - E. Ренин
- /147./ Транзитор уураг алдалт нь дараах тохиолдолд илэрнэ
1. Биеийн эмгэг галбир
  2. Даарч хөрөх
  3. Биеийн хүчний хүнд ажил хийх
  4. Удаан хугацаагаар халуурах
  5. Фитнес хийх
- /148./ Бөөрний гаралтай гематурийн үед 3 аяганы сорилд дараах өөрчлөлт илэрнэ
- A. 3 аяганд улаан эсийн хэмжээ адилхан байна
  - B. Эхний аяганы улаан эсийн хэмжээ их, сүүлийн 2 аяганых бага
  - C. Эхний 2 аяганы улаан эсийн хэмжээ их ,сүүлийн аяганых бага
  - D. 3 аяганы улаан эсийн хэмжээ бага
  - E. 3 аяганд улаан эс илрэхгүй
- /149./ Архаг гломерулонефритийн үед гормон эмчилгээний эсрэг заалт
- A. Гематури
  - B. Артерийн даралт ихсэлт
  - C. Бөөрний архаг дутагдал
  - D. Нефроз хам шинж
  - E. Сэдрэлээс сэргийлэх зорилгоор
- /150./ Бөөрний цочмог дутагдлыг эмнэл зүйн явцаар нь
1. Шалтгаан хамаарлын үе
  2. Шээс багасах-Огт ялгарахгүй үе
  3. Шээсний ялгаралт сэргэх үе
  4. Бөөрний үйл ажиллагаа бүрэн сэргэж эдгэрэх үе
  5. Полиури
- /151./ Бөөрний цочмог дутагдлын үед Гемодиализ хийх эсрэг заалт
1. Зүрхний шигдээс
  2. Тархины цус харвалт
  3. Ходоод гэдэсний хурц цус алдалт
  4. Хурц халдварт өвчин
  5. Хурц психоз
- /152./ Тубулоинтерстициал нефритын шалтгааныг нэрлэнэ үү?
1. Эм
  2. Вирус

3. Нян
4. Дархлаа
5. Тан

/153./ Ямар эмгэгийн үед рентген шинжилгээнд Ходсоны шинж илрэх вэ?

- A. Пиелонефритийн хатингаршил
- B. Бөөрний уйланхай
- C. Бөөрний поликистоз
- D. Бөөрний түүдгэнцэрийн үрэвсэл
- E. Бөөрний чулуу

/154./ Бөөрнөөс ялгардаг биологийн идэвхит бодисыг нэрлэнэ үү ?

1. Ренин
2. Серотонин
3. Эритропоэтин
4. Брадикинин
5. Простагландин E

/155./ Нефроз хам шинжийн үед дараах шинж тэмдгүүд илэрнэ

1. Псевдоанеми
2. Цээжний хөндийд шингэн үүснэ
3. Хэвлийн хөндийд шингэн үүснэ
4. Гидроперикард үүснэ
5. Тархи хавагнах

/156./ Нефроз хам шинжийн кризийн үед өвчтөнд дараах шинж тэмдгүүд илэрнэ.

1. Өвчтөн халуурна
2. Хэвлийн гялтангийн хальс цочирно
3. Артерийн даралт буурна
4. Бөөрний үйл ажиллагаа алдагдана
5. Хэвлийгээр хүчтэй өвдөнө

/157./ Нефроны аль хэсэгт натрийн ихэнх хувь нь эргэн шимэгддэг вэ?

- A. Ойрын тахир сувганцарт
- B. Генлийн гогцооны өгсөх хэсэг
- C. Холын тахир сувганцарт
- D. Цуглуулах сувганцарт
- E. Түүдгэнцэрт

/158./ Альдостерон даавар хаанаас ялгардаг вэ?

- A. Гипофиз
- B. Бөөр
- C. Бөөрний дээд булчирхай
- D. Бөөрний тархилаг давхрага
- E. ЮГА

/159./ Архаг гломерулонефритийн даралт ихдэх хэлбэрийн сэдрэлийн үед дараах нэг шинжээс бусад нь илэрнэ.

- A. Протеинури
- B. Гематури
- C. Цилиндрури
- D. Хаван
- E. Артерийн даралт ихсэлт

/160./ Биохимийн шинжилгээний ямар үзүүлэлтийг ашиглан бөөрний архаг өвчний үе шатыг үнэлж болох вэ?

- A. Сийвэн дэх мочевины хэмжээ
- B. Сийвэнгийн үлдэгдэл азот
- C. Сийвэн дэх калийн хэмжээ
- D. Сийвэнгийн креатинины хэмжээ
- E. Сийвэн дэх кальцийн хэмжээ

/161./ Бөөрний архаг дутагдлын эхэн үед дараах шинж тэмдгүүд илэрнэ.

- A. Артерийн даралт ихсэх
- B. Их уух, их шээх

- C. Цусан дахь калийн хэмжээ ихсэх
- D. Цусан дахь кальцийн хэмжээ ихсэх
- E. Цусан дахь фосфорын хэмжээ буурах

/162./ Бөөр хамгаалах бэлдмэл болох лизиноприл ямар механизмаар үйлчилдэг вэ?

- 1. Цусны даралт бууруулах
- 2. Түүдгэнцрийн дотоод даралт бууруулах
- 3. Түүдгэнцрийн гипертрофиг багасгах
- 4. Протеинуриг багасгах
- 5. Мезангиаль эсийн өсөлтийг бууруулах

/163./ Изотопт Ренограммын бүрэлдэхүүн хэсгүүдэд юу орох вэ?

- 1. Судасны үе
- 2. Шүүрлийн үе
- 3. Ялгаруулах үе
- 4. Эхлэх үе
- 5. Паренхимийн үе

/164./ Бөөрний судасны шалтгаант гипертензийг ямар аргаар оношлох вэ?

- 1. Радиозотопийн шинжилгээ
- 2. Ангиографийн шинжилгээ
- 3. Хэт авиан доплерографи
- 4. Хэт авиан шинжилгээ
- 5. Бөөрний эдийн шинжилгээ

/165./ Бөөрний цочмог дутагдлын үед зайлшгүй хийх шинжилгээг нэрлэнэ үү?

- 1. Цусан дахь креатинин
- 2. Цусны PH үзэх
- 3. Цусны электролит үзэх
- 4. Зимницкийн сорил
- 5. Шээсэн дэх давсны агууламж

/166./ Бөөрний судасны шалтгаант даралт ихдэлтийг оношлох арга

- 1. Доплерт сонографи
- 2. Соронзон резонанст томографи
- 3. Бөөрний ангиографи
- 4. Бөөрний рентген зураг
- 5. Компьютерт томографи

/167./ Бөөрний гаж хөгжлийг нэрлэнэ үү?

- 1. Төрөлхийн ганц бөөр
- 2. Тэнэмэл бөөр
- 3. Бөөрний төрөлхийн дутуу хөгжил
- 4. Бөөр унжилт
- 5. Бөөр усжилт

/168./ Экскретор урографи хийх эсрэг заалт нэрлэнэ үү?

- 1. Иодын бэлдмэлд хэт мэдрэг
- 2. Бөөрний дутагдал
- 3. Элэгний үйл ажиллагааны ээнэгшил алдагдсан
- 4. Зүрхний үйл ажиллагааны алдагдал
- 5. Хүнд хэлбэрийн тиреотоксикоз

/169./ Бөөрний ангиографи хийх заалт нэрлэнэ үү?

- 1. Бөөрний судасны гаралтай АДИ
- 2. Бөөрний вений бүлэн
- 3. Донорын бөөрийг мэс заслын өмнө шинжлэх
- 4. Суулгасан бөөрний артерт эмгэг үүссэн эсэх .
- 5. Бөөрний хавдар

/170./ Шээс ялгаралтын доорхи өөрчлөлтийг Анури гэнэ

- 1. Хоногт 600 мл –ээс бага шээх
- 2. Шээс огт ялгарахгүй байх
- 3. Ойр ойрхон шээх
- 4. Хоногт 100 мл-ээс бага шээх



5. Шээсний сүвээр өвдөх

/171./ Гематурийг шалтгаанаар яаж ангилдаг вэ ?

1. Пререналь
2. Реналь
3. Постреналь
4. Түүдгэнцрийн
5. Аяганцар тэвшинцэрийн

/172./ Глюкоз болон аминхүчлүүдийн эргэн шимэгдэх процесс хаана явагддаг вэ ?

- A. Холын тахир сувганцар
- B. Генлийн гогцооны өгсөх бүдүүн хэсэг
- C. Генлийн гогцооны уруудах нарийн хэсэг
- D. Ойрын тахир сувганцар
- E. Цуглуулах сувганцар

/173./ Эрүүл хүний шээс сүрлэн шар өнгөтэй байх нь шээсээр ямар будагч бодисууд ялгардагтай холбоотой вэ?

1. Урохром
2. Урозеин
3. Уроэритин
4. Урат
5. Урон

/174./ Бөөрний түүдгэнцэрийн гаралтай уураг алдалтын шалтгаан болж болох өвчин эмгэгийг нэрэлнэ уу

1. Түүдгэнцэрийн анхдагч эмгэгүүд
2. Халдварууд
3. Чихрийн шижин
4. Холбогч эдийн эмгэгүүд
5. Эмийн бодисууд

/175./ Бөөрний эмгэгийн идэвхжлийг доорхи эмнэл зүйн шинж тэмдэгт үндэслэн тогтооно.

1. Нефроз хам шинж илрэх
2. Протеинури ихсэх
3. Гематури ихсэх
4. Артерийн даралт тогвортой ихсэх
5. Бөөрний түүдгэцэрийн шүүлтийн хурд огцом буурах

/176./ Сувганцарын гаралтай уураг алдалтын шалтгаан

1. Бөөрний поликистоз
2. Бөөр шээсний замын халдвар
3. Бөөрний уйланхай
4. Завсрын эдийн нефрит
5. Бөглөрөл, давсаг шээлүүрийн сөргөө

/177./ Бөөрний гаралтай хавангийн онцлог

1. Цайвар өнгөтэй
2. Шилжимтгий
3. Хөвсгөр зөөлөн
4. Ихэнхдээ ууц нуруугаар үүснэ
5. Оройн цагаар ихэсдэг

/178./ Пиелонефрит үүсэхэд дараах хүчин зүйлүүд нөлөөлнө.

1. Шээсний замын саатал бөглөрөл болсоноос салст бүрхэвч нь сунаж нимгэрэх
2. Шээсний замын багажийн шинжилгээ , эмчилгээний үед халдваршууд зөөгдөн тархах
3. Жирэмсэн үед дааврын өөрчлөлтөөс болон умайн томролтоос болж шээсний урсгал хөдөлгөөнд шууд ба шууд бус замаар саатал үүсэх
4. Чихрийн шижин өвчний үед бөөрний эдийн цусан хангамж муудах
5. Дархлаа дарангуйлах эмчилгээний улмаас бие махбодийн дархлааны өөрчлөлт

/179./ Архаг пиелонефрит өвчний сэдэрлийн үеийн эмчилгээний ерөнхий зарчим

1. Антибиотик эмчилгээ
2. Уросептик эмийг зохих тунгаар хэрэглэх
3. Шээсний замын саадыг арилгах

4. Глюкокортикостероид эмчилгээ
  5. Цитостатик эмийг зохих тунгаар хэрэглэх
- /180./ Бөөрний архаг дутагдлыг ямар үе шатанд хуваадаг вэ ?
1. Ээнэгшлийн үе
  2. Ээнэгшлээ алдах үе
  3. Уремийн үе
  4. Шалтгаан хүчин зүйлийн үе
  5. Олигоанурийн үе
- /181./ Гломерулонефрит үүсэхэд нөлөөлөх гадаад хүчин зүйлд
1. Сийвэн , эм ,химийн бодис
  2. Зохисгүй хооллолт , архи ихээр хэрэглэх
  3. Хорхой шавьжинд хазуулах
  4. Т, В лимфоцитуудын хэвийн харьцаа алдагдах
  5. Т лимфоцитын төрөлхийн болон олдмол дутмагшил
- /182./ Гломерулонефрит үүсэхэд нөлөөлөх дотоод хүчин зүйлд
1. Сийвэн , эм ,химийн бодис
  2. Т, В лимфоцитуудын хэвийн харьцаа алдагдах
  3. Даарч хөрөх
  4. Т лимфоцитын төрөлхийн болон олдмол дутмагшил
  5. Гэмтэл бэртэл
- /183./ Нефроз хам шинжийн үед дараах шинж тэмдгүүдээс аль нь илрэх вэ?
1. Хаван
  2. Гипопротеинеми
  3. Протеинури
  4. Лейкоцитури
  5. Гематури
- /184./ Нефроз хам шинжийг шалтгаанаар нь яаж ангилдаг вэ?
1. Олдмол
  2. Удамшлын
  3. Төрөлхийн
  4. Эмэгтэйчүүдийн
  5. Өндөр настны
- /185./ Архаг гломерулонефритийн үед гормон эмчилгээ хийх заалт
1. Гематури
  2. Артерийн даралт ихсэлт
  3. Бөөрний архаг дутагдал
  4. Нефроз хам шинж
  5. Сэдрэлээс сэргийлэх зорилгоор
- /186./ Архаг гломерулонефритийн үед цитостатик эмчилгээ хийх заалт
1. Гематури
  2. Артерийн даралт их хэлбэр
  3. Бөөрний архаг дутагдал
  4. Глюкокортикостероид эмчилгээ үр дүнгүй тохиолдол
  5. Нефроз хам шинж
- /187./ Нефроз хам шинж илэрдэг өвчнүүдийг нэрлэнэ үү?
1. Бөөрний чулуу
  2. бөөрний амилоидоз
  3. Бөөрний поликистоз
  4. Бөөрний түүдгэнцэрийн үрэвсэл
  5. Сувганцарын эмгэг
- /188./ Бөөрний цочмог дутагдалыг шалтгаан байдлаар нь яаж ангилдаг вэ?
1. Бөөрний урьдал шалтгаант
  2. Бөөрний шалтгаант
  3. Бөөрний гаднах шалтгаант
  4. Бөөрний эдийн шалтгаант
  5. Судасны шалтгаант

/189./ Бөөрний цочмог дутагдалыг шалтгаанаар нь яаж ангилдаг вэ?

1. Шокийн гаралтай
2. Хордлогын гаралтай
3. Халдвар хордлогын гаралтай
4. Бөөрний судасны бөглөрлийн улмаас үүсэх
5. Шээсний замын бөглөрлийн улмаас үүсэх

/190./ Бөөрний цочмог дутагдлын үед Гемодиализ хийх заалт

1. Цусны креатинин 600 мкмоль/л-ээс ихсэх
2. Цусны Кали 6,5 ммоль/л ихсэх
3. Уушиг тархинд хаван үүсч эхлэх
4. 2-3 хоног эмчилгээ хийхэд үр дүнгүй бол
5. Биеийн ерөнхий байдал маш хүнд байх

/191./ Архаг тубулоинтерстициал нефритын үед дараах шинж тэмдэгүүдийг аль нь илрэх вэ?

1. Алколоз
2. Ацидоз
3. Гипокальциемия
4. Гиперкалиеми
5. Гипокалиеми

/192./ Архаг тубулоинтерстициал нефритын үед бөөрний ямар үйл ажиллагаа эхэлж алдагдах вэ?

1. Шүүлтүүрийн үйл ажиллагаа
2. Шээс ялгаруулах үйл ажиллагаа
3. Биологийн идэвхитэй бодис ялгаруулах үйл ажиллагаа
4. Шээс өтгөрүүлэх үйл ажиллагаа
5. Цус бүлэгнэлтийг зохицуулах үйл ажиллагаа

/193./ Шээс өтгөрүүлэх сөрөг тогтолцоонд хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг хэсгийг нэрлэнэ үү

1. Генлийн гогцооны өгсөх хэсэг
2. Ойрын тахир сувганцарын уруудах хэсэг
3. Ойрын тахир сувганцарын муруй хэсэг
4. Генлийн гогцооны уруудах хэсэг
5. Холын тахир сувганцар

/194./ Хүчил шүлтийн тэнцвэрийг зохицуулахад бөөрний үүргийг сонго

1. Ионуудын солилцоог зохицуулах
2. Сувганцарын хучуур эсийн дотор бикарбонат үүсэж цусанд шимэгдэх
3. Аммиак үүсэж ялгарах
4. Сувганцарт ус төрөгчийн ионыг уснаас задална
5. Сувганцарт Ус төрөгчийн ионыг шүүрүүлж ялгаруулна

/195./ Бөөрний цочмог дутагдалын үед зайлшгүй хийх лабораторын шинжилгээ

1. Шээсний нянгийн шинжилгээ
2. Цусан дах креатинины хэмжээ
3. Нүдний уг дурандах
4. Цусны электролит үзэх
5. Цусны ариун чанар үзэх

/196./ Нефроз хам шинжийн үед эмнэл зүйн болон лабораторийн шинжилгээнд дараах өөрчлөлтүүд илэрнэ

1. Бүх бие хавагнана
2. Хоногийн шээсний уургийн хэмжээ 3-3,5 гр /л-ээс их болно
3. Цусны нийт уургийн хэмжээ багасна
4. Уургийн бүлгүүдийн харьцаа алдагдана
5. Цусанд липид, холестерин хэмжээ ихсэнэ

/197./ Түүдгэнцэрийн шүүлтийн үйл ажиллагаанд оролцдог бүтцүүдийг нэрлэнэ үү?

1. Подоцит эс
2. Суурин мембран
3. Эндотель эс
4. Мезангийн эс
5. Боуман-Шумлянскийн капсул

/198./ Шээсний нянгийн шинжилгээд дараах аргууд орно

1. Зимницкийн сорил
2. Бактерлогийн шинжилгээ
3. Бензолын сорил
4. Нитритийн сорил
5. Преднизолоны сэдээх сорил

/199./ Бөөрөнд дараах биологийн идэвхит бодисууд нийлэгждэг

1. Ренин
2. Кининууд
3. Простагландин
4. Эритропоэтин
5. Урокиназ

/200./ Архаг пиелонефрит нь дараах шээсний хам шинжээр илэрнэ

1. гематури
2. Лейкоцидури
3. протеинури
4. Бактериури
5. полиури

/201./ Пиелонефритийн хамгийн түгээмэл тохиолдох үүсгэгч нь аль вэ?

1. Стрептококк
2. Клебсиелл
3. Бактерууд
4. Гэдэсний савханцар
5. Вирусууд

/202./ Дээрх эмүүдээс аль нь альдостероны антогонист вэ ?

1. Фуросемид
2. Маннит
3. Урегит
4. Верошпирон
5. Лазикс

/203./ Бөөрний хамгаалах зорилгоор дээрх эмийн бэлдмэлүүдээс хэрэглэнэ

1. АХФ ингибитор
2. Антиагрегант
3. АР блокатор
4. Димефосфон
5. Канефрон

/204./ Жирэмсэний пиелонефриттэй эмэгтэйчүүдийн жирэмсэний явц төрөлтийн үед доорхи хүндрэл нэгээс бусад нь гарч болно

- A. Хожуу үеийн хордлого
- B. Үр зулбалт
- C. Ургийн халдварт хүндрэлүүд
- D. Ургийн гипертрофи илрэх
- E. Бактеремийн шок

/205./ Соронзон Резонанст Томографи шинжилгээгээр бөөр шээс дамжуулах замын юуг судлах вэ?

1. Бөөрний байрлал болон бүтэц
2. Бөөрний хэмжээ
3. Бөөрний хавдар
4. Бөөрний чулуу
5. Бөөрний уйланхай

/206./ Шээсний шинжилгээнд гарч буй аль өөрчлөлт нь сувганцрийн үйл ажиллагааны байдлыг илтгэх вэ?

1. Уураг 3гр/л их
2. Уураг 1гр/л бага
3. Их хэмжээний ураттай шээх
4. Шээсний хувийн жин 1005 бага

5. Цустай шээх

/207./ Изоморфик улаан эс шээсэнд илрэх шалтгаан

1. Шээсний замын халдвар
2. Давсагны үрэвсэл
3. Шээсний сүвний үрэвсэл
4. Түүдгэнцэрийн цочмог үрэвсэл
5. Түүдгэнцэрийн архаг үрэвсэл

/208./ Бөөрний цочмог дутагдлыг эмнэл зүйн ямар үе шатанд хуваах вэ ?

1. Шалтгаан хүчин зүйл нөлөөлөх үе
2. Олигоанурийн үе
3. Шээс ялгаралт сэргэх үе
4. Эдгэрэх үе
5. Полиурийн үе

/209./ Ходоодны шархлааны идэвхижлийн A-I зэргийн үед уян дуранд илрэх шинжийг хэлнэ үү ?

A. Шархны ёроол гүнзгий, фибринин өнгөртэй, хуниас харагдана. Шархны ирмэгний өнгө нь цайвар

B. Шархны ёроол цайвар фибрин өнгөртэй

C. Шархны идэвхижил нь өндөр, шархны ёроол нь бохир цус болон гематинэн бүрхүүлтэй ирмэг нь өргөгдсөн конвергенц илрээгүй

D. Шархны идэвхижил нь өндөр, шархны ёроол нь гематинэн бүрхүүлтэй, ирмэг нь өргөгдсөн улаан өнгөтэй, конвергенц илэрсэн

E. Шарх хэмжээгээр жижиг, конвергенц үүсч, ёроолын өнгөр нимгэн, грануляц үүссэн байна

/210./ Ходоодны булчирхайн уураг задлагч фермент ялгаруулагч эсийг сонгоно уу?

- A. Гол эс
- B. Нэмэлт эс
- C. Ханын эс
- D. Завсрын эс
- E. Дотоод шүүрлийн эс

/211./ Ходоодны шүүрэл ялгаралтыг ихэсгэх үйлдэлтэй ходоод гэдэсний даавруудыг сонгоно уу.

1. Соматостатин
2. Гистамин
3. Простогландин
4. Гастрин
5. Ацетилхолин

/212./ Ходоодны салстыг гэмтээгч хүчин зүйлийг нэрлэнэ үү?

1. Хүчил
2. Пепсин
3. Ходоод гэдэсний хөдөлгөөний алдагдал
4. Цөсний хүчлийн детергент нөлөө
5. Өөхний хэт исэлдлийн эрчимжилт

/213./ Ходоодны шархлаа өвчний үед рентген шинжилгээнд илрэх шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Симптом Ниша
2. Үрэвслийн хөвөө шинж
3. Заагч хурууны шинж
4. Чаши Клойбера шинж
5. Гэдэсний гогцоо өргөсөх

/214./ Мелена гэдэг ойлголтыг тайлбарлана уу?

- A. Баасанд гемоглобины задралын бүтээгдэхүүн илрэх
- B. Улаан, хар цусаар бөөлжих
- C. Цустай, хөөстэй ханиалгах
- D. Баас хар гарах
- E. Цустай баах

/215./ Өрцний доор хий хуралдах шалтгааныг нэрлэнэ үү?

1. Абортын үед умай цоорсон бол
2. Хэвлийн хөндийн нээлттэй мэс ажилбарын дараа
3. Хэвлийн хөндийн эрхтэн цоорох
4. Гэдэсний түгжрэл
5. Ходоодны шарх зэргэлдээ эрхтэнд нэвчих

/216./ Үйлчлүүлэгч 34 настай эр. Аюулхайд өвдөнө, хүчиллэг зүйлээр хэхэрч цээж хорсдог, баас хар гарна гэсэн зовиуртай эмнэлэгт иржээ. Үзлэгээр: Биеийн байдал хүндэвтэр, ядарч сульдсан, зүрхний авиа тод хэм жигд бага зэргийн түргэссэн, АД-90/60 мм. м.у.б. Менделийн шинж тод илэрсэн. Аюулхайд өнгөц өвдөлтийн мэдрэмж ихэссэн. Нэмэлт асуумжаар – Тамхи татдаг, хоолны дэг барьдаггүй. Сүүлийн үед өтгөн хар өнгөтэй гардаг болсон гэв. Шинжилгээнд: ЦЕШ: HGB-90g/l, MCH-20pg, MCV-70fl, LEU-8\*10<sup>9</sup>, Уян дурангийн шинжилгээнд ходоодны шархлааны идэвхижлийн А-I зэрэг илэрсэн. Дээрх тохиолдолд ходоодны салст хамгаалах ямар бэлдмэл авч болох вэ?

1. Висмутийн давс
2. Сукралфат
3. Мизопростол
4. Солкосерил
5. Актовегин

/217./ С.44 настай, эмэгтэй. Аюулхайд өвдөнө, хоолонд дургүй, махан хоолны шингэц тааруу, хааяа гүйлгэнэ, Улаан хоолой, ходоодны рН метрийн шинжилгээнд улаан хоолойн рН 6,7: ходоодны их бие хэсгийн рН 5,0. Өвчтөнд илэрч буй биж хамшинж үүссэн шалтгааныг нэрлэнэ үү?

1. Экссудат суулгалт
2. Тэжээл дутал
3. Ходоодны хүчил ихэссэн
4. Ходоодны хүчиллэг багассан
5. Архаг панкреатит

/218./ С.44 настай, эмэгтэй. Аюулхайд өвдөнө, хоолонд дургүй, махан хоолны шингэц тааруу, хааяа гүйлгэнэ, Улаан хоолой, ходоодны рН метрийн шинжилгээнд улаан хоолойн рН 6,7: ходоодны их бие хэсгийн рН 5,0. рН метрийн шинжилгээг үнэлнэ үү?

1. Ходоод-улаан хоолойн сөөргөө
2. Дээд гэдэс ходоодны сөөргөө
3. Гиперацидизм
4. Гипоацидизм
5. Нормоацидизм

/219./ Ходоодны хүчил багадах үндсэн шалтгааныг нэрлэнэ үү?

1. Тамхи
2. Helicobacter pylori
3. Цөсний сөөргөө
4. Аутоиммун гастрит
5. Мөхлөгт гастрит

/220./ О. 36 настай, эмэгтэй. Хэвлийн баруун дор лугшиж, явахад доргиж өвдөнө гэсэн зовиуртай. 3 хоногийн өмнөөс аюулхайд өвдөж эхэлсэн, ношпа уугаад намдаагүй. Үзлэгт өвчтөний биеийн халуун 38,0С, хэл хуурай, зузаавтар өнгөртэй, судасны лугшилт минутанд 100 удаа. Ровзинг, Ситковский, Бартомье-Михельсон, Щеткин-Блюмбергийн шинж илэрнэ. Өвчтөнд Бартомье-Михельсоны шинж тэмдэг эмнэл зүйд хэрхэн илрүүлэх вэ?

1. Хэвлийн зүүн доод хэсэгт гүн тэмтрэхэд өвдөнө
2. Өвчтөнг зүүн хажуугаар хэвтүүлж үзнэ
3. Хэвлийд гүн дараад огцом авахад өвдөнө
4. Хэвлийн баруун доод хэсэгт гүн тэмтрэхэд өвдөнө
5. Хэвлийн баруун дээд хэсэгт өвдөнө

/221./ О. 36 настай, эмэгтэй. Хэвлийн баруун дор лугшиж, явахад доргиж өвдөнө гэсэн зовиуртай. 3 хоногийн өмнөөс аюулхайд өвдөж эхэлсэн, ношпа уугаад намдаагүй. Үзлэгт өвчтөний биеийн халуун 38 С, хэл хуурай, зузаавтар өнгөртэй, судасны лугшилт минутанд 100 удаа. Ровзинг, Ситковский, Бартомье-Михельсон, Щеткин-Блюмбергийн шинж

илэрнэ.Өвчтөнд илэрч буй шинж тэмдгийг перитонитийн I үе шат буюу реактив шат гэж үнэлсэн. Энэ үед гарах эмгэг физиологийн гол өөрчлөлтийг дурдана уу?

1. Цусанд экзо, эндо хор цугларч, хордлого үүснэ
2. Халдварын голомтод үзүүлэх хариу урвал
3. Биеийн дархлал суларна
4. Хаван үүсч, хэсэг газрын нэвчилт, фибрин наалдац үүснэ
5. Үжлийн оворго үүснэ

/222./ О. 36 настай, эмэгтэй. Хэвлийн баруун дор лугшиж, явахад доргиж өвдөнө гэсэн зовиуртай.3 хоногийн өмнөөс аюулхайд өвдөж эхэлсэн, ношпа уугаад намдаагүй.Үзлэгт өвчтөний биеийн халуун 38 С, хэл хуурай, зузаавтар өнгөртэй, судасны лугшилт минутанд 100 удаа.Ровзинг, Ситковский, Бартолье-Михельсон, Щеткин-Блюмбергийн шинж илэрнэ.Өвчтөнд илэрч буй шинж тэмдгийг перитонитийн I үе шат буюу реактив шат гэж үнэлсэн. Энэ үед гарах эмгэг физиологийн гол өөрчлөлтийг дурдана уу?

1. Цусанд экзо, эндо хор цугларч, хордлого үүснэ
2. Халдварын голомтод үзүүлэх хариу урвал
3. Биеийн дархлал суларна
4. Хаван үүсч, хэсэг газрын нэвчилт, фибрин наалдац үүснэ
5. Үжлийн оворго үүснэ

/223./ Өвчтөн 40 настай.эмэгтэй, 3 жилийн өмнөөс цээж гашуун оргих болсон, хоол залгих үед өвчүүний ард хорсож өвддөг.Үзлэгт онцын өөрчлөлтгүй.Уян дурангийн шинжилгээгээр: Улаан хоолойн доод 1/3-т, эргэн тойрон эдийг бүрэн хамарсан шалбархай болон шархтай, үрэвсэл, хаван ихтэй, нарийсал үүсээгүй. Z шугам байрлал хэвийн. Ходоодны шүүс тунгалаг, антрум хэсгийн салст өнгөц үрэвсэлтэй, дээд гэдэс хэвийн. Улаан хоолойн салст бүрхэвчийг хамгаалах хүчин зүйлийг сонгоно уу?

1. Салс, бикарбонатын ялгарал
2. Салст бүрхэвчийн бүрэн бүтэн байдал
3. Салстын цусан хангамж
4. Биеийн хэвтээ байрлал
5. Хоол боловсруулах хөндийн дааврын ялгарал

/224./ Өвчтөн 40 настай.эмэгтэй, 3 жилийн өмнөөс цээж гашуун оргих болсон, хоол залгих үед өвчүүний ард хорсож өвддөг.Үзлэгт онцын өөрчлөлтгүй.Уян дурангийн шинжилгээгээр: Улаан хоолойн доод 1/3-т, эргэн тойрон эдийг бүрэн хамарсан шалбархай болон шархтай, үрэвсэл, хаван ихтэй, нарийсал үүсээгүй. Z шугам байрлал хэвийн. Ходоодны шүүс тунгалаг, антрум хэсгийн салст өнгөц үрэвсэлтэй, дээд гэдэс хэвийн. Дээрхи өвчтөнд ямар хүндрэл илэрч болох вэ?

1. Нарийсал
2. Цус алдалт
3. Барретын улаан хоолой
4. Сөргөөт ларингит
5. Улаан хоолойн цүлхэн

/225./ Ходоод - улаан хоолойн эмгэг сөргөөг батлах шалгуурыг сонгоно уу?

1. Ходоодны шүүс улаан хоолойд гулиган орох
2. Улаан хоолойн хүчиллэг 4.0-өөс бага болох
3. Улаан хоолойн хүчиллэг 7.0 – с их болох
4. Сөөргөө нэг удаад 5 минутаас удаан хугацаагаар үргэлжлэх
5. Хоногийн 12%-д хүчиллэг орчинтой болох

/226./ Барретын улаан хоолойг батлах шинжийг нэрлэнэ үү?

1. Олон давхраат хавтгай хучуур эдээр солигдох
2. Дан давхраат бортгон хучуураар солигдоно
3. Хучуур эдийн хөхлөгт үе зузаарах
4. Кардийн булчирхайнууд илэрнэ.
5. Нейтрофил, эозинофил, плазмочит эсийн өтгөн нэвчдэс

/227./ Ходоод - улаан хоолойн сөргөөг эмчлэх “Алтан стандарт” эмчилгээг сонгоно уу?

1. Церукал
2. Ранитидин

3. Мотилиум
4. Омепразол
5. Вентер

/228./ X. 18 настай, эрэгтэй. Цээж хорсоно, хоолсноос 2 цагийн дараа аюулхайд хүчтэй нухаж өвдөнө, ар нуруу руу дамжина. Үзлэгт астеник галбиртай, хэл цэвэр, аюулхайд эмзэглэлтэй, нугалуур эмзэглэлтэй хатуувтар.Рентген шинжилгээнд ходоодонд шингэн ихтэй, барийн шохой саатна, дээд гэдэсний булцуу хэсгийн хэлбэр алдагдсан.

Өвчтөнд ходоодны хүчил ялгаралтыг дарангуйлах зорилгоор хэрэглэдэг сонгомол үйлдэлтэй эмийг сонгоно уу?

1. Ранитидин
2. Фамотидин
3. Омепразол
4. Алмагель
5. Маалокс

/229./ X. 18 настай, эрэгтэй. Цээж хорсоно, хоолсноос 2 цагийн дараа аюулхайд хүчтэй нухаж өвдөнө, ар нуруу руу дамжина. Үзлэгт астеник галбиртай, хэл цэвэр, аюулхайд эмзэглэлтэй, нугалуур эмзэглэлтэй хатуувтар.Рентген шинжилгээнд ходоодонд шингэн ихтэй, барийн шохой саатна, дээд гэдэсний булцуу хэсгийн хэлбэр алдагдсан. Өвчтөнд ходоодны шүүрэл ихэссэн биомеханизм юутай холбоотой вэ?

1. Цусны бүлэг, HLA B5, B15, B35
2. Симпатик мэдрэлжилтийн нөлөө багасах
3. Парасимпатик нөлөө ихсэх
4. Helicobacter pylori халдвар
5. Стресс

/230./ Ходоодны шүүсэн дэх давсны хүчил ямар эсээс ялгарах вэ?

1. Карбоангидраз эсэг агуулсан эс
2. Их бие хэсэгт ганц ганцаараа байрлах том, зөв биш хэлбэртэй эс
3. Хүрээ эс
4. Эсийн оройн хэсэг нь далд, шүүрлийн том мөхлөгтэй, хүрээ эсээс хлорид ялгаралтын идэвхийг зохицуулдаг ходоодны их биед гол төлөв байрлах эс
5. Ёроолын булчирхайн төгсгөл хэсэгт орших салсын мөхлөг ихтэй залуу эс

/231./ 1 хүртэлх насны хүүхдийн гэдэс өвдөлт дараах шинжүүдээр илэрнэ.

1. Хүүхэд тайван биш, унтамхай болно
2. Хоёр хөлөө хооронд нь үрж уйлна
3. Гэдсэнд хуримтлагдсан хий гармагц тайвширна
4. Гэдсээр өвдлөө гэж заана
5. Уруугаа харж хэвтэнэ

/232./ Үйлчлүүлэгч X.25 настай, эмэгтэй.Халуурна, хэвлийн баруун хэсгээр хүчтэй базалж өвдөнө.Баасны дараа өвдөлтийн эрч буурна.Өдөрт 5-6 удаа, зарим үед цусархаг гүйлгэнэ.Өвчин жилд хэд хэдэн удаа сэдэрдэг.Баасны нян судлалын шинжилгээгээр эмгэгтөрөгч нян илрээгүй. Колоноскопийн шинжилгээнд: мухар, өгсөх гэдэсний хана хэсэг газрын улайлттай, олон тооны тууш гүн шархлаа, эрүүл ба эмгэг салст бүрхүүл хосолсон зураглалтай. Лабораторийн шинжилгээнд: Hemoglobin 85г/л, Erythrocyte  $4.0 \times 10^{12}$ , Leucocyte  $11 \times 10^9$ , MCH=25 pg, MCV=110fl, СОЭ-35мм/ц. Таны таамаглаж буй онош

- A. Хоолны хордлого
- B. Кроны өвчин
- C. Архаг энтерит
- D. Өвөрмөц бус шархлаат колит
- E. Цусан суулга

/233./ Бүдүүн гэдэсний рентген шинжилгээний үед хэдэн грамм Барийн Сульфат хэрэглэх вэ?

- A. 200 грамм Барийн сульфатыг 400 мл устай
- B. 400 грамм Барийн сульфатыг 400 мл устай
- C. 400 грамм Барийн сульфатыг 600 мл устай
- D. 200 грамм Барийн сульфатыг 200 мл устай



Е. 200 грамм Барийн сульфатыг 600 мл устай  
/234./ Хялгасан судасны нэвчимхий чанарыг бууруулах, IL-1, IL-2, IL-8 зэрэг үрэвслийн медиатор (цитокин) ялгаралтыг саатуулах, Фосфолипаз А2 ферментийг дарангуйлж харшил-үрэвслийн эсрэг үйлдэл үзүүлэх үйлдэлтэй эмийг сонгоно уу?.

- А. Азатиоприн
- В. Сульфасалазин
- С. Хилак
- Д. Преднизолон
- Е. Метотрексат

/235./ Панкреатитийн үед илэрч буй Кулены шинжийг хэрхэн тодорхойлох вэ?

- А. Тэмтрэхэд хэвлийн дээд хэсэгт нойр булчирхай дагуудаа булчин чангарна
- В. Аюулхай орчим гол судасны цохилт мэдэгдэхгүй
- С. Хүйс ба баруун сугыг холбосон ташуу шугамаар хүйснээс дээш 4-5 см газарт эмзэглэлтэй
- Д. Хүйс орчим арьс хөхөрч, цусархаг нэвчилт үүссэн харагдана
- Е. Хэвлийн хажуу ханаар арьс хөхөрч, цусархаг нэвчилт үүссэн харагдана

/236./ Х. 18 настай, эрэгтэй. Цээж хорсоно, хооллосноос 2 цагийн дараа аюулхайд хүчтэй нухаж өвдөнө, ар нуруу руу дамжина. Үзлэгт астеник галбиртай, хэл цэвэр, аюулхайд эмзэглэлтэй, нугалуур эмзэглэлтэй хатуувтар. Рентген шинжилгээнд ходоодонд шингэн ихтэй, барийн шохой саатна, дээд гэдэсний булцуу хэсгийн хэлбэр алдагдсан. Үйлчлүүлэгчийн ходоодны гистологи шинжилгээнд Helicobacter Pylori илэрчээ. Та Маастрихтийн III удирдамжийн дагуу хэрэглэж болох эмийг сонгоно уу?

1. Ранитидин, кларитромицин, трихопол
2. Висмут, омепразол, тетрациклин, метронидазол
3. Фамотидин, амоксициллин, фурадонин
4. Омепразол, кларитромицин, амоксициллин
5. Омепразол, эритромицин, трихопол

/237./ Аль нь Х хам шинж вэ?

- А. Стенокардийн өвдөлт илэрсэн боловч миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй
- В. Стенокардийн өвдөлт илэрч, сийвэнд ферментийн идэвхжил ихэссэн боловч титэм судасны рентген шинжилгээ хэвийн
- С. Стенокардийн өвдөлт илэрч, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй боловч титэм судасны рентген шинжилгээ эмгэг өөрчлөлттэй
- Д. Стенокардийн өвдөлттэй, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илэрсэн боловч титэм судасны рентген шинжилгээ хэвийн
- Е. Стенокардийн өвдөлтгүй, миокардын ишемийн шинж тэмдэг ЗЦБ-т илрээгүй боловч титэм судасны рентген шинжилгээ эмгэг өөрчлөлттэй

/238./ Зүрхний дутагдлыг эрт илрүүлэх зорилгоор ямар шинжилгээг хийвэл илүү үр дүнтэй вэ?

- А. Зүрхний хэт авиан шинжилгээ
- В. Зүрхний ачаалалтай сорил
- С. Тропонин
- Д. Натри ялгаруулагч пептид
- Е. Зүрхний сцинтиграфи

/239./ Өвчтөн 29 настай, эмэгтэйг чагнахад зүрхний I цэгт диастолын, II цэгт систолын тод шуугиан сонсогдоно. Зүрхний ямар гажиг байх магадлалтай вэ?

- А. Митрал хавхлагын ба аортын хавхлагын дутагдал хавсарсан гажиг
- В. Митрал хавхлагын дутагдал ба аортын хавхлагын нарийсал хавсарсан гажиг
- С. Митрал хавхлагын нарийсал ба аортын хавхлагын дутагдал хавсарсан гажиг
- Д. Митрал хавхлагын ба аортын хавхлагын нарийсал хавсарсан гажиг
- Е. Митрал хавхлагын нарийсал ба уушгины хавхлагын дутагдал хавсарсан гажиг

/240./ Митрал хавхлагын нээлтийн талбайн хэвийн хэмжээг сонгоно уу?

- А. 2.0-2.5 см<sup>2</sup>

- B. 2.5- 3.0 см<sup>2</sup>
- C. 3.5 -4.0 см<sup>2</sup>
- D. 3.0-3.5 см<sup>2</sup>
- E. 4.0-6.0 см<sup>2</sup>

/241./ Халдварт эндокардитын үед ямар эмчилгээ хамгийн чухал вэ?

- A. Дархлаа дэмжих
- B. Үрэвслийн эсрэг
- C. Хордлого тайлах
- D. Антибиотик
- E. Харшлын эсрэг

/242./ Эмнэл зүйн ямар хэлбэрийн перикардит нь зөвхөн цочмог явцтай байдаг вэ?

- A. Хуурай
- B. Наалдаст
- C. Шүүдэст
- D. Шүүдэст ба наалдаст
- E. Хуурай ба шүүдэст

/243./ Синкопийг ямар эмгэгээс хамгийн түрүүнд ялган оношлох шаардлагатай вэ?

- A. Гипогликеми, комын байдал
- B. Эпилепсийн уналт, коллапс
- C. Истерийн уналт, шок
- D. Гипогликеми, эпилепсийн ба истерийн уналт
- E. Эпилепсийн ба истерийн уналт, коллапс

/244./ Зүрхний Дэлхийн Холбоо зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх гол арга замыг юу гэж тодорхойлсон вэ?

- A. Амьдралын зөв хэв маягийг хэвшүүлэх
- B. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх
- C. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах
- D. Зүрх судасны эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэн, тэдгээрийг арилгахад чиглэсэн арга хэмжээ авах
- E. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдах

/245./ Атеросклерозын ямар үе шатанд фиброзон товруу үүсдэг вэ?

- A. I үе шат
- B. II үе шат
- C. III үе шат
- D. IV үе шат
- E. V үе шат

/246./ Аль нь зүрхний хамгийн өвөрмөц фермент вэ?

- A. ГОТ
- B. ЛДГ
- C. КФК
- D. Тропонин
- E. ГПТ

/247./ Зүрхний цочмог шигдээсийн үед ЗЦБ-д илрэх өвөрмөц өөрчлөлтийг нэрлэнэ үү?

1. ST сегмент голч тэнхлэгээс дээш өргөгдөх
2. Эмгэг Q шүд шинээр илрэх
3. T шүд урвуу болох
4. ST сегмент голч тэнхлэгээс доош буух
5. R шүд намсах

/248./ Дараах оношилгооны аргуудаас аль нь миокардын ишемийг эрт оношлох боломжтой вэ?

- A. Зүрхний тайван үеийн цахилгаан бичлэг
- B. Зүрхний хэт авиан шинжилгээ
- C. Анамнез
- D. Зүрхний ачаалалтай бичлэг
- E. Сийвэнд фермент үзэх

/249./ Зүрхний цахилгаан бичлэгийн V1-V6 холболтод ST сегмент бууж, , урвуу T шүд илэрчээ. Энэ нь ямар өөрчлөлт вэ?

- A. Миокардын дистрофийн өөрчлөлт
- B. Урд ханын субэндокардын шигдээс
- C. Урд ханын ишемийн өөрчлөлт
- D. Урд хажуу ханын ишемийн өөрчлөлт
- E. Хажуу ханын ишемийн өөрчлөлт

/250./ Зүрхний шигдээсийн үед анхны яаралтай тусламжийг MONA гэдэг схемээр үзүүлдэг. Энэ нь ямар үгсийн товчлол вэ?

- A. Морфин, хүчилтөрөгч, нитрат, антикоагулянт
- B. Морфин, хүчилтөрөгч, нитрат, антиагрегант
- C. Морфин, хүчилтөрөгч, нитрат, анальгетик
- D. Морфин, хүчилтөрөгч, нитроглицерин, аспирин
- E. Морфин, хүчилтөрөгч, нитроглицерин, антиаритмик

/251./ Гипертензийн кризын үед АД-н түвшинг эхний 2 цагт хэдэн хувиар бууруулвал тохиромжтой вэ?

- A. 20%-р
- B. 35%-р
- C. 10%-р
- D. 15%-р
- E. 25%-р

/252./ Цусны сийвэнд АСЛО эерэг гарвал юуны тухай бодох вэ?

- A. Хэрлэг өвчтэй байна
- B. Архаг тонзиллит өвчтэй байна
- C. Стрептококкийн халдвар авч эсрэг биет үүссэн байна
- D. Стрептококкийн эсрэг төрөгч илэрсэн байна

/253./ Титэм судасны хэдэн хувь нарийсвал цус хөдлөлд мэдэгдэхүйц саад учруулах вэ?

- A. 15хувь
- B. 25хувь
- C. 40 хувь
- D. 50 хувь
- E. 75хувь

/254./ Анхдагч артерийн гипертензийн эрсдлийн зэргийг тодорхойлох нь ямар ач холбогдолтой вэ?

1. Онош тодруулах
2. Тавиланг урьдчилан тодорхойлох
3. Өвчтөнг үнэлэх
4. Эмчилгээний тактикийг зөв сонгох
5. Хүндрэлийг тодорхойлох

/255./ Феохромоцитомын гаралтай АД ихдэлтийг ямар шинжилгээр нотлох вэ

1. Хэвлийн эхографийн шинжилгээ
2. Цусанд катехоламин үзэх
3. Цусанд ренин үзэх
4. Бөөрний дээд булчирхайн КТ
5. . Цусанд кортизол үзэх

/256./ Зүрхний цочмог шигдээсийн үеийн бүлэн уусгах эмчилгээний туйлын эсрэг заалтыг сонгоно уу?

1. 1. Ходоодны шархлаа
2. Тархины цус харвалт
3. Сүүлийн 1 сард болсон хамраас цус гарсан
4. Цус шүүрэх эмгэгүүд
5. Халдварт эндокардит

/257./ Зүрхний цочмог шигдээсийн эмчилгээтэй холбоотой зөв хариултыг сонгоно уу?

1. Амь насанд аюултай хэм алдагдлаас сэргийлэх зорилгоор лидокайн тарих нь үр дүнтэй
2. Эмчилгээнд нифедипин хэрэглэхэд нас барах эрсдэл ихэсдэг
3. Курантил нь шигдээс дахилтыг бууруулдаг

4. Эмчилгээний үр дүн нь оношлосон хугацаанаас шууд хамааралтай
  5. Бүлэн уусгах эмчилгээг эхний 24 цагт хийвэл үр дүнтэй
- /258./ Титэм судасны фиброзон товруу шархлаж задрахад хүргэдэг хүчин зүйлийг сонгоно уу?
1. Товрууны атеромын бүрхүүл нимгэрэх
  2. Товрууны атеромын бүрхүүлийн үрэвсэл
  3. Товрууны атеромын липидын хэмжээ ихсэх
  4. Товрууны атеромын липидын хэмжээ багасах
  5. Товрууны атеромын бүрхүүл зузаарах
- /259./ Зүүн титэм судасны уруудах салаа бүлэнгээр бөглөрөхөд миокардын аль хананд зүрхний шигдээс үүсэх магадлалтай вэ?
1. Зүүн ховдлын хажуу хана
  2. Ховдол хоорондын таславч
  3. Зүүн ховдлын арын доод хана
  4. Зүрхний орой
  5. Зүүн ховдлын арын дээд хана
- /260./ Үндэсний эмнэл зүйн удирдамжид заасны дагуу зүрхний шигдээсийн үеийн бүлэн уусгах эмчилгээний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгоно уу?
1. Бүлэн уусгах эмчилгээний дараа 60 минутанд өргөгдсөн ST сегмент >50%-иар буух
  2. Цээжний өвдөлт намдах
  3. КФК-МВ ферментийн хэмжээ ихсэх
  4. Бүлэн уусгах эмчилгээний дараа 90 минутанд өргөгдсөн ST сегмент >40%-иар буух
  5. Титэм судасны зурагны эерэг өөрчлөлт
- /261./ Зүрхний шигдээсийн үед морфин тарихад ямар гаж нөлөө илэрч болох вэ?
1. АД буурах
  2. Брадикарди
  3. Бөөлжис цутгах, бөөлжих
  4. Амьсгал цөөрөх
  5. Шээс хаагдах
- /262./ ST сегмент өргөгдсөн зүрхний шигдээстэй өвчтөнг эмнэлгээс гарсаны дараа ямар эмийн бэлдмэл хэрэглэхийг үндэсний удирдамжид зөвлөсөн байдаг вэ?
1. Аспирин
  2. Метопролол
  3. Каптоприл
  4. Симвастатин
  5. Томуугийн эсрэг вакцин
- /263./ Зүрхний ишеми өвчний эрсдэл хүчин зүйлсд хамаарах зөв хариултыг сонгоно уу?
1. Тус эмгэг таргалалтай хүмүүст илүү тохиолддог
  2. Архины зохистой хэрэглээ нь эрсдлийг бууруулдаг
  3. Цэвэршилтийн өмнөх насны, чихрийн шижинтэй эмэгтэйн эрсдэл нь ижил насны эрэгтэй хүний эрсдэлтэй адил байна
  4. Тамхинаас гарсны дараа эрсдэл нь хэвийн хэмжээ хүртэл буурдаг
  5. Бясалгал эрсдлийг багасгадаг нь нотлогдсон
- /264./ Ямар эмгэгийн үед ЗЦБ-т урвуу Т шүд илэрдэг вэ?
1. Зүрхний шигдээс
  2. Субарахноид цус харвалт
  3. Миокардит
  4. Митрал хавхлагын пролапс
  5. Гипокалиеми
- /265./ Зүрхний ишеми өвчний үед нитратын бүлгийн эмийн бэлдмэлийг хэрэглэхэд ямар гаж нөлөө илэрдэг вэ?
1. Ханиалгах
  2. Эмэнд тэсвэрлэг шинж чанар үүсэх
  3. Бөөлжис цутгах
  4. Толгой өвдөх
  5. Хоолонд дүргүй болох

/266./ Зүрхний архаг дутагдалд хамаарах зөв хариултыг сонгогч уу?

1. Тархалт нь нас ахих тутам ихэсдэг
2. Систолын дутагдал нь илүү тохиолддог
3. Хөгжиж буй орнуудад зүрхний олдмол гажиг нь гол шалтгаануудын нэг болдог
4. Зүрх судасны гаралтай нас баралтын гол шалтгааны нэг мөн
5. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үндсэн шалтгааны нэг

/267./ Дараах шинж тэмдэгүүдээс аль нь зүрхний дутагдлын илрэл байж болох вэ?

1. Хоёр хүртэлх давхрын шатаар өгсөхөд амьсгаадах
2. Шөнийн цагт ханиалгах
3. Шөнийн цагт амьсгал давчдаж сэрэх
4. Аюулхайн хэсэгт хүнд оргих мэдрэмж төрөх
5. Биеийн хүчний ачаалалын үед шуугиантай амьсгал илрэх

/268./ Аль нь зүрхний диастолын дутагдлын шалтгаан болох вэ?

1. Зүрхний шигдээс
2. Чихрийн шижин
3. Зүрхний гажиг
4. Артерийн гипертензи
5. Зүрхний архаг ишеми өвчин

/269./ Тодорхой шалтгаангүй тэлэгдлийн кардиомиопати нь ишемийн кардиомиопатигаас юугаар ялгаатай вэ?

1. Залуу хүмүүст илүү тохиолддог
2. Зүрхний цахилгаан бичлэг эмгэг өөрчлөлтгүй байдаг
3. Дөрвөн хөндий тэлэгдэж томордог
4. Ховдол хоорондын таславч зузаардаг
5. Уушгины гипертензи үүсдэг

/270./ Мерцательны тахиаритми ямар сөрөг үр дагавартай вэ?

1. Цусны бүлэн үүсгэх эрсдлийг ихэсгэнэ
2. Тархины шигдээс үүсгэх эрсдлийг нэмэгдүүлнэ
3. Цусны эргэлт муудна
4. Шээсний гарц багасна
5. Ховдлын тахикарди үүсэх эрсдлийг ихэсгэнэ

/271./ Митрал хавхлагын дутуу хаагдалд хамаарах зөв хариултыг сонгогч

1. Залуу хүмүүст митрал хавхлагын дутуу хаагдлын гол шалтгаан нь хэрэх өвчин мөн
2. Өөр нэг шалтгаан нь митрал хавхлагын унжилт буюу пролапс юм
3. Митрал хавхлагын харьцангуй дутагдал нь тэлэгдлийн кардиомиопатийн үед илэрдэг
4. Өнгөт ба доплер эхокардиографийн тусламжтай илрүүлдэг
5. Зүүн ховдол илүү томордог

/272./ Ямар гажгийн үед уушгины гипертензи үүсэх магадлал илүү вэ?

1. Митрал хавхлагын нарийсал
2. Ховдол хоорондын таславчийн цоорхой
3. Гурван хавтаст хавхлагын харьцангуй дутагдал
4. Аортын хавхлагын нарийсал
5. Митрал хавхлагын дутагдал

/273./ Миокардитыг яаж ангилдаг вэ?

1. Шалтгаанаар
2. Тархалтаар
3. Эмнэл зүйн хэлбэрээр
4. Эмгэг жамаар
5. Явцаар

/274./ Ямар хүмүүс халдварт эндокардит өвчинд өртөмтхий вэ?

1. Хиймэл хавхлага суулгасан
2. Хар тамхи хэрэглэдэг
3. Гемодиализ хийлгэдэг
4. Митрал хавхлагын унжилттай
5. Гүйлсэн булирхайн үрэвсэлтэй

/275./ Халдварт эндокардитын эмнэл зүйн онцлог нь юу вэ?

1. Олон эрхтэн тогтолцоог гэмтээдэг
2. Хүндрэл элбэг, нас баралт өндөр өвчин
3. Цусаар дамжиж, сепсис хэлбэрээр явагддаг
4. Хавхлага гэмтээдэггүй
5. Архаг явцтай

/276./ Аль тохиолдол нь цусны ариун чанарыг тодорхойлох шинжилгээний хариу эерэг гарах магадлалыг ихэсгэдэг вэ?

1. Антибиотикийн хэрэглээ
2. Шинжилгээг олон давтан хийх
3. Шинжилгээг нэг удаа хийх
4. Халуурч байгаа үе
5. Антибиотик хэрэглэхийн өмнө

/277./ Цочмог перикардитын үед ямар эмийн эмчилгээ хийх вэ?

1. Үрэвслийн эсрэг дааврын бус бэлдмэл
2. Шалтгааны эсрэг эмчилгээ
3. Үрэвслийн эсрэг дааврын бэлдмэл
4. Цитостатик бэлдмэл
5. Харшлын эсрэг бэлдмэл

/278./ Перикардитын үед ЗЦБ-д ямар өөрчлөлт илэрч болох вэ?

1. ST сегмент өргөгдөх
2. R шүдний далайц нэг холболтонд харилцан адилгүй байх
3. R шүдний далайц багасах
4. Q шүд гүнзгийрэх
5. ST сегмент буух

/279./ Зүрх зогсоход илрэх эмнэл зүйн шинж тэмдэгийг сонгоно уу

1. Амьсгаадах
2. Хөхрөх
3. Нүүр улайх
4. Судасны лугшилт тэмтрэгдэхгүй болох
5. Артерийн даралт буурах

/280./ Аль нь цээж шахалтын дараах хүндрэл байж болох вэ?

1. Хавирга хугарах
2. Өвчүү хугарах
3. Пневмоторакс
4. Зүрх урагдах
5. Гемоторакс

/281./ Зүрхний шигдээсийн ямар хүндрэлийг хэт авиан шинжилгээгээр оношлох боломжтой вэ?

1. Ховдол хоорондын цоорхой
2. Ховдлын бүлэн
3. Ховдлын цүлхэн
4. Тампонад
5. Зүрхний дутагдал

/282./ Зүрхний булчингийн далд ишемийг оношлогооны ямар аргаар илрүүлдэг вэ?

1. Зүрхний ачаалалтай бичлэг
2. Ачаалалтай сцинтиграфи
3. Стресс эхокардиографи
4. Холтерийн мониторинг
5. Титэм судасны компьютерын томографи

/283./ Анхдагч артерийн гипертензийн үед илрэх бай эрхтэний гэмтлийг нэрлэх

1. Нүдний угт ретинопати илрэх
2. Нүдний угт ангиопати илрэх
3. Сийвэнд креатинин ихсэх
4. ЗЦБ-д зүүн ховдлын томрол илрэх
5. Зүрхний архаг дутагдлын эмнэл зүйн шинж тэмдэг илрэх

/284./ Хоёрдогч артерийн гипертензийг таамаглах эмнэл зүйн шинж тэмдэг аль нь вэ?

1. Эмийн эмчилгээ үр дүн багатай байх
2. Залуу насанд АД ихсэж эхлэх (<35 нас)
3. Диастолын АД давамгайлж ихсэх
4. Систолын АД давамгайлж ихсэх
5. Удамшлын өгүүлэмжтэй байх

/285./ Зүрхний гликозидын туйлын хориглох заалтуудыг нэрлэнэ үү?

1. Тосгуурын мерцани
2. АВ зангилааны хоригийн II зэргийн үед
3. Ховдлын дээд пароксизмаль тахикарди
4. Зүрхний цохилтын тоо 1 минутанд 50-с бага болсон үед
5. Синусын тахикарди

/286./ Баруун ховдлын дутагдлын үед илрэхгүй шинжийг хэлнэ үү.

1. Элэг томрох
2. Гүрээний судас гүрийх
3. Хөл хавагнах
4. Ханиалгах
5. Амьсгаадах

/287./ Антиангиналь бүлгийн эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү?

1. Симвастатин
2. Нитросорбид
3. Изадрин
4. Пропронолол
5. Клофелин

/288./ Шүүдэст перикардитийн үед гарах эмнэл зүйн шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Амьсгаадалт
2. Хавагнах
3. Зүрх томрох
4. Цусны даралт ихсэх
5. Ханиалгах

/289./ Анхдагч артерийн гипертензийн цочмог хүндрэлийг заах

1. Зүрхний багтраа
2. Уушгины хаван
3. Тархинд цус харвах
4. Бөөрний хурц дутагдал
5. Ретинопати

/290./ Ямар эмгэг зүрхний эзлэхүүний ачаалал үүсгэдэг вэ?

1. Цусны даралт ихдэлт
2. Гол судасны хавхлагын дутагдал
3. Гол судасны хавхлагын нарийсал
4. Митраль хавхлагын дутагдал
5. Митраль хавхлагын нарийсал

/291./ Амь насанд аюултай зүрхний хэмнэл алдагдалд аль нь хамаарах вэ?

1. Тосгуур ховдлын багцын бүтэн хориг
2. Ховдлын тахикарди
3. Ховдлын чичиргээ
4. Гисийн багцын бүтэн хориг
5. Тосгуурын чичиргээ

/292./ Артерийн даралт ихсэх өвчний 3-р үеийг 2-р үеээс ялгах шинжүүдийг сонгоно уу?

1. Нүдний угийн өөрчлөлт (Г. Салюсын шинж)
2. Зүрхний дутагдал илрэх
3. ЗЦБ-т зүүн ховдлын томрол илрэх
4. ЗИӨ хавсран илрэх
5. Аортын цэгт 2-р авиа тод сонсогдох

/293./ Зүүн ховдлын томролын ЭКГ-ийн шинжийг заана уу?

1.  $Rv5 > Rv4$
2.  $Rv6 > Rv5$

3.  $Rv5 + Sv1 > 35$  мм
4. V1-V2 холболтонд R шүдний далайц өндөрсөх
5.  $R3 > R2 > R1$

/294./ Зүрхний шигдээсийн архаг хүндрэлүүд?

1. Митральны регургитаци
2. Зүүн ховдлын бүлэн
3. Уушгины хаван
4. Дресслерийн хам шинж
5. Миокардын урагдал

/295./ Зүрхний шигдээсийн үеийн цээжний өвдөлт нь цээжний бахын өвдөлтөөс юугаар ялгаатай вэ?

1. Өвдөлтийн байршил
2. Өвдөлтийн хүч
3. Өвдөлтийн дамжилт
4. Өвдөлтийн үргэлжлэх хугацаа
5. Өвдөлтийг сэдрээх хүчин зүйл

/296./ Ямар тохиолдолд ST сегмент голч тэнхлэгээс доош буудаг вэ?

1. Миокардын ишеми
2. Гипокалиеми
3. Дигоксины хордлого
4. Ховдлын томрол
5. Тахикарди

/297./ ЗЦБ-ээр ямар эмгэгийг оношлох боломжгүй вэ?

1. Зүрхний хэм алдагдал
2. Эндокардит
3. Зүрхний томрол
4. Зүрхний дутагдал
5. Зүрхний шигдээс

/298./ Сийвэнд натри ялгаруулагч пептидыг тодорхойлох нь ямар ач холбогдолтой вэ?

1. Зүрхний архаг дутагдлын эмчилгээний үр дүнг үнэлэх
2. Зүрхний архаг дутагдлыг уушгин зүрхээс ялган оношлох
3. Зүрхний дутагдлыг эрт илрүүлэх
4. Миокардын цусан хангамжийг тодорхойлох
5. Өвчтөний тавиланг тодорхойлох

/299./ Аль нь зүрхний шигдээсийн цочмог үе шатанд илэрдэг хүндрэл вэ?

1. Зүрхний шок
2. Уушигны зогсонги
3. Уушигны хаван
4. Тосгуурын мерцани
5. Ховдлын экстрасистоли

/300./ Артерийн гипертензитэй өвчтөн зүрхний архаг дутагдалтай тохиолдолд даралт бууруулах эмийн бэлдмэлээс алийг нь сонговол илүү үр дүнтэй вэ?

1. Атенолол
2. Каптоприл
3. Амлодипин
4. Гипотиазид
5. Празоцин

/301./ Дан систолын артерийн даралт ихдэлт нь өндөр настай хүмүүст илүү тохиолддог. Учир нь өндөр настай хүмүүст том артерийн судасны уян чанар буурсан байдаг.

/302./ Атенолол нь зүрхний булчингийн  $\beta_1$  рецепторт хориг тавих үйлдэлтэй антиангиналь бэлдмэл, тэрээр  $\beta_1$  рецепторт нөлөөлснөөр зүрхний минутын эзлэхүүнийг бууруулж, миокардын хүчилтөрөгчийн хэрэгцээг багасгадаг.

/303./ Хоёр хавтаст хавхлагын гажигтай хүнийг харж ажиглахад “Faciesmitralis” илэрдэг. Энэ нь нарийссан нүхээр цус шахагдахдаа хуйларч орсноос болдог.

/304./ Захын цусанд нейтрофил эс ихсэх тохиолдлуудыг нэрлэнэ үү?

1. Нянгийн халдвар



2. Гэмтэл, мэс засал
  3. Үрэвсэл
  4. Хорт хавдар
  5. Стероид эмүүд хэрэглэж байгаа тохиолдолд
- /305./ Архаг лимфолейкозын эмнэлзүйн үе шатуудад илрэх шинж тэмдгүүдийг нэрлэнэ үү ?
1. O үе: туйлын лимфоцитоз  $> 15 \times 10^9$  л
  2. I үе: O+лимфийн зангилаанууд томрох
  3. II үе: I+элэг юмуу дэлүү томрох
  4. III үе: II+ цус багадалт илрэх
  5. IV үе: III + ялтас  $< 100 \times 10^9$  л
- /306./ Миеломийн үндсэн шалгуур үзүүлэлтийг нэрлэнэ үү?
1. Ясны чөмөгний эсийн шинжилгээнд плазмоцит эс  $> 20\%$
  2. Эдийн шинжилгээнд плазмоцит эсийн нэвчдэс илрэх
  3. Ig G  $> 35$  г/ л, Ig A  $> 20$  г/ л илрэх
  4. Хавтгай хэмт яснуудад яс хайлсан голомтууд илрэхгүй
  5. Шээсээд Бенс-Джонсын уураг илрэх
- /307./ Хаул- Жоллын биенцэр агуулсан эс гэж ямар эсийг хэлдэг вэ?
1. Бөөмтэй улаан эсүүд
  2. Улаан эс дотор төмрийн мөхлөгүүд харагдах
  3. Захын цусны түрхцэнд эритробластууд илрэх
  4. Захын цусны түрхцэнд бөөмийн үлдэгдэл агуулсан улаан эс илрэх
  5. Дусал хэлбэрийн улаан эс
- /308./ Хоёрдогч гемостаз явагдах үе шатуудыг нэрлэнэ үү?
1. Протромбиназа идэвхижих үе
  2. Протромбинаас тромбин үүсэх үе
  3. Фибриногенээс фибрин үүсэх үе
  4. Үүссэн фибрин бэхжих үе
  5. Фибрины задралын бүтээгдэхүүн үүсэх үе
- /309./ Мегалобластын цус багадалтанд дараах эмгэгүүд орно.
1. Витамин B12 дутагдлын цус багадалт
  2. Фолийн хүчил дутагдлын цус багадалт
  3. ДНХ-ийн нийлэгжилтийн төрөлхийн дутагдал
  4. Эритролейкеми
  5. Тусмал сидеробластын цус багадалт
- /310./ Архаг миелолейкемийн ид үед шинжилгээнд дараах өөрчлөлтүүд илэрнэ.
1. Захын цусанд ялтас эсийн тоо буурах
  2. Захын цусанд цагаан эсийн тоо  $50.000/л$  –ээс их болох
  3. Цагаан эсийн доторхи ШФ-ийн хэмжээ ихсэх
  4. Захын цусанд нейтрофилийн зүүний хазайлт илэрнэ
  5. Туйлын лимфоцитоз илэрнэ
- /311./ Хурц лейкозын бүрэн намжилтын үед дараах өөрчлөлтүүд гарна.
1. Ясны улаан чөмгөнд бласт эс  $5\%$ -иас ихгүй
  2. Томорсон элэг, дэлүү, тунгалгын булчирхай хэвэндээ орох
  3. Захын цусанд гранулоцит  $1\text{мкл-т } 1000$ - аас доошгүй
  4. Нейролейкемийн шинж байхгүй
  5. Тромбоцит эс  $100.000$ -иас багагүй
- /312./ Судсанд цус түгмэл бүлэгнэх хам шинжийн гипокоагуляцын үед шинжилгээнд гарах өөрчлөлтийг нэрлэнэ үү?
1. Цус бүлэгнэх хугацаа удааширна.
  2. Ялтас эсийн тоо цөөрнө
  3. Фибрин задралын бүтээгдэхүүн ихсэнэ.
  4. Цусны түрхцэнд гиперсегменттэй нейтрофилүүд харагдана.
  5. Цусны түрхцэнд мегакариоцитоос ялтас эс тасарч байгаа зураглал харагдахгүй байх
- /313./ Элэг, дэлүү хавсран томорсон тохиолдолд дараах өвчнүүдийг сэжиглэнэ.
1. Элэгний архаг үрэвсэл
  2. Элэгний цирроз

3. Архаг миелололейкоз
  4. Архаг лимфолейкоз
  5. Цус задралын цус багадалт
- /314./ Гемофилийг эмнэлзүйгээр нь хэрхэн ангилдаг вэ?
1. Хөнгөн (VIII фактор 5-10 %)
  2. Дунд (VIII фактор 1-5 %)
  3. Хүнд (VIII фактор 1% бага)
  4. Ужиг (VIII фактор 20% бага)
  5. Маш хүнд (VIII факторын түвшин тодорхойлогдох боломжгүй)
- /315./ Эритроцитын мембраны гэмтэл ямар уургийн дутагдалтай холбоотой байдаг вэ?
1. Анкирин
  2. Спектрин
  3. Актин
  4. Глобин
  5. Альбумин
- /316./ Удамшлын микросфероцитоз өвчний эмнэлзүйн шинж тэмдгүүдийг нэрлэнэ үү?
1. Шоовон толгой
  2. Хүнхэр тагнай
  3. Олон хуруу
  4. Нахиу хамар
  5. Хөл шилбэ майга
- /317./ Угаасан улаан бөөмийг ямар заалтаар хэрэглэдэг вэ?.
1. Олон удаа цус сэлбүүлж байгаа өвчтөнд цагаан эсийн дархлаа тогтохоос сэргийлэх зорилгоор
  2. Сийвэнгийн уургуудад мэдрэгшсэн өвчтөнүүдэд
  3. Урьд нь улаан эсийн бэлдмэл сэлбүүлэхэд урвал өгч байсан өвчтөнд
  4. Архаг цус багадалт
  5. Гематокрит <21%-иас буурсан тохиолдолд хэрэглэнэ.
- /318./ Ялтас эсийн өтгөрүүлгийг хориглох заалтыг нэрлэнэ үү?
1. Аутоиммуны гаралтай тромбоцитопенийн пурпур
  2. Бүлэн үүссэн тромбоцитопенийн пурпур
  3. Судсанд цус түгмэл бүлэгнэх хам шинж
  4. Тромбоцитопати
  5. Цус гоожих хугацаа богиноссон үед
- /319./ Архаг миелололейкозын ид үед эмчилгээнд аль эмийн бэлдмэлүүдийг хэрэглэх нь зохистой вэ?
1. Цитозар
  2. Гидроксиуреа
  3. Рубомицин
  4. Гливек
  5. Флудара
- /320./ Лейкемийн цонх гэдэг нь:
1. Лейкозын үед захын цусны түрхцэнд эвдэрсэн улаан эсүүд харагдах
  2. Хурц лейкозыг архаг лейкозоос ялгах үзүүлэлтүүдийн нэг
  3. Захын цусанд зөвхөн залуу эсүүд гарна
  4. Лейкограмм-д бласт эсүүд илэрч түүний дараагийн ангийн эсүүд илрэлгүйгээр бие гүйцсэн ангийн эсүүд тоологдоно.
  5. Ясны хэмийн шинжилгээнд Миелойдны эсүүд дангаараа тодорхойлогдоно
- /321./ Фолийн хүчил дутагдлын цус багадалтанд хүргэх шалтгаануудыг дурдана уу?
1. Хоол хүнсээрээ фолийн хүчлийг хангалттай авч чадахгүйгээс
  2. Архаг архидалт, архины хордлого
  3. Уналт таталтын эмүүдийг байнга хэрэглэх
  4. Жирэмснээс хамгаалах эмүүдийг тогтмол хэрэглэх
  5. Хүүхдийг тэжээвэр өсгөх, дутуу төрөлт
- /322./ Аутоиммуны тромбоцитопени өвчин үүсгэх үндсэн шалтгаануудыг нэрлэнэ үү?
1. Ялтсын үүсэл үр дүнгүй явагдах

2. Ясны улаан чөмгөнд мегакариоцитын үүсэл багасах
3. Ялтсын задрал ихсэх
4. Ялтсын мөхлөгүүд цөөрөх
5. Ялтсын үүсэлт удаашрах

/323./ Аутоиммуны тромбоцитопенийн пурпура эмгэг жамыг тайлбарлана уу?

1. Ялтсын эсрэг голдуу Ig G-ийн төрлийн эсрэг бие үүснэ
2. Ялтсын гадаргуу дах GPIIb/IIIa юмуу GPIb/IX бүрдлийн эсрэг эсрэг бие үүснэ.
3. Мононукляр Макрофагийн ялтсыг задлах үйл ажиллагаа идэвхжинэ
4. Ясны чөмгөн дэх мегакариоцитүүд дисплазийн өөрчлөлтөд орно.
5. Гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр ясны улаан чөмөгний үйл ажиллагаа дарангуйлагдана

/324./ Аутоиммуны тромбоцитопенийн пурпура оноштой өвчтний шинжилгээнд гарч болох өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?

1. Цусны түрхцэнд том тромбоцит харагдана
2. Цусны бүлэнгийн агчих чадвар муудна
3. Иммунологийн шинжилгээнд Ig G-ын түвшин өндөр байна.
4. Ясны хэмийн шинжилгээнд мегакариоцитоос тромбоцит эс тасарч байгаа зураглал тод болсон байна.
5. Ясны чөмөгний эдийн шинжилгээнд эсжилт буурсан байна

/325./ Аутоиммуны тромбоцитопенийн пурпура оноштой өвчтөнд хийгдэх эмчилгээг төлөвлөнө үү?

1. Глюкокортикоид эмчилгээ
2. Иммунодепрессант
3. Спленоэктоми
4. Даназол
5. Плазмаферез

/326./ Аутоиммуны тромбоцитопенийн пурпура өвчний үеийн дэлүү авах заалт:

1. Иммунодепрессант эмүүд хэрэглэсэн ч үр дүнгүй байгаа тохиолдолд
2. Гормон эмчилгээнд үр дүнгүй, жилд 2-3 удаа сэдрэл өгч байгаа тохиолдолд
3.  $\alpha 2$ -интерферон эмчилгээнд үр дүнгүй байгаа тохиолдолд
4. Гормон эмчилгээний гаж нөлөө илэрч байгаа, цаашид эмчилгээ хийх боломжгүй болсон тохиолдолд
5. Монохими эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд

/327./ Улаан эс бай хэлбэртэй болох эмгэгүүдийг сонгоно уу?

1. Төмөр дутагдлын цус багадалт
2. Фолийн хүчил дутагдлын цус багадалт
3. Витамин B12 дутагдлын цус багадалт
4. Талассеми
5. Цусны хавдрууд

/328./ Төмөр дутагдлын цус багадалтын эмчилгээ үр дүнгүй байгаа тохиолдолд дараах хүчин зүйлүүд нөлөөлж байна гэж тооцоолж болох уу?

1. Хавсарсан эсвэл хүндрүүлэх өөр эмгэгүүд байх
2. Өвчтөн заасан эмийг зохих тунгаар уухгүй байх
3. Өвчтөнд цус алдалт үргэлжилж байх
4. Витамин B12, фолийн хүчил зэрэг бусад цус төлжилтөнд оролцдог хүчин зүйлсийн дутагдал байх
5. Шимэгдэх үйл ажиллагаа алдагдсан байх

/329./ Витамин B 12 дутагдлын цус багадалтын үед захын цусны түрхэцэнд гарах өөрчлөлт:

1. Сидероцит эсүүд ихээр захын цусанд илэрнэ
2. Захын цусанд бие гүйцээгүй улаан болон цагаан эсүүд илэрнэ
3. Бие гүйцсэн цагаан эсүүд болон ялтсын тоо бас цөөрнө
4. Жоллын биет, Кеботын цагираг агуулсан улаан эсүүд илэрнэ
5. Миелобласт 5%-с их илэрнэ

/330./ Аплазийн цус багадалтын хүнд зэргийн шалгуур үзүүлэлт?

1. Нейтрофил  $<0.5 \cdot 10^9/L$
2. Тромбоцит  $<20 \cdot 10^9/L$

3. Ретикулоцит <1%
4. Лимфоцит <10%
5. Эритроцит  $\leq 3,2$  сая/L

/331./ Цочмог лейкокеийн оношлогоонд цитогенетикийн шинжилгээг хийснээр....

1. Хромсомын тооны болон бүтцийн гажгийг илрүүлнэ
2. Цочмог лейкокеийн тавилангийн талаар мэдээлэл өгнө
3. Цочмог лейкокеийн эмчилгээний үр дүнг тооцно.
4. Цочмог лейкокеийн шалтгааныг илрүүлнэ.
5. Өвчин бүрэн эдгэрнэ.

/332./ Цочмог лимфобластын лейкокеийн тавилангийн хувьд муу үзүүлэлтүүдийг нэрлэнэ үү?

1. Өвчтөний нас  $\geq 50$  нас
2. Лейкоцитын тоо өндөр  $>30 \cdot 10^9$ /л байх
3. Иммунофенотипийн хувьд: Про-В болон про-Т эсийн ЦЛЛ
4. Цитогенетикийн хувьд: Ph хромсом илрэх
5. Бүрэн засралд орох хугацаа удаан байх ( $>4-5$  долоо хоног)

/333./ Жинхэнэ полицитеми-н /ЖП/ оношлогооны А шалгууруудыг заана уу?

1. А1-эргэлдэх эритроцитийн хэмжээ ихсэх (эргэлдэх цусны хэвийн эзэлхүүнээс $>25\%$ )
2. А2- Клонт маркер, хромсомын гажиг илрэх
3. А3- Дэлүү тэмтрэгдэхүйц томрох
4. А4- Лейкоцитоз,  $>12 \cdot 10^9$ /л
5. А5- тромбоцитоз,  $>400 \cdot 10^9$ /л

/334./ Жинхэнэ полицитеми-н оношлогооны В шалгууруудыг заана уу?

1. В1 - тромбоцитоз,  $>400 \cdot 10^9$ /л
2. В2 - нейтрофильный лейкоцитоз,  $>10 \cdot 10^9$ /л, тамхичдад  $>12 \cdot 10^9$ /л байх
3. В3 - изотопийн болон хэт авиан шинжилгээгээр дэлүүний томрол илрэх
4. В4 - Ийлдсийн эритропоэтиний хэмжээ тодорхойлогдохгүй байх
5. В5 – туйлын лимфоцитоз

/335./ Идиопатик тромбоцитопенийн пурпура өвчний үед илэрч буй цус гоожимтгой шинж ямар өөрчлөлттэй холбоотой вэ?

1. Фибринолиз идэвхжих
2. Ялтсын үйл ажиллагаа алдагдах
3. Цус бүлэгнэлтийн 8-р факторын дутагдал
4. Ялтсын тоо цөөрөх
5. Дэлүү хэт идэвхжих

/336./ Аплазын цус багадалтын үед илэрч буй панцитопенийн эмгэг физиологийн үндсийг тайлбарлана уу?

1. Ясны чөмөгний бичил орчин гэмтэх
2. Цус үүсгэгч эсүүд гэмтэх
3. CD8+DR+ эсүүдийн хэт идэвхжил
4. Дэлүүний үйл ажиллагаа эрчимжих
5. Ясны чөмөгний үйл ажиллагаа түр дарангуйлагдах

/337./ Аплазын цус багадалтын эмчилгээний төлөвлөгөөг бичнэ үү?

1. Дархлал дарангуйлах
2. Ясны хэм шилжүүлэн суулгах
3. Шинж тэмдгийн дэмжих эмчилгээ
4. Дэлүү авах
5. Хими эмчилгээ хийлгэх

/338./ Хоол боловсруулах замын архаг цус алдалтыг оношлохын тулд ямар шинжилгээ хийх хэрэгтэй вэ?

1. Ходоодны дуран
2. Бүдүүн гэдэсний дуран
3. Грегерсений сорил
4. Компьютер томографи
5. MRI

/339./ Төмөр дутлын цус багадалтын үед илэрдэг үс унах, хумс хугарах шинжүүд ямар механизмаар илэрч байгаа вэ?

1. Уураг дутагдлаас
2. Төмөр агуулсан ферментүүдийн идэвхи буурснаас
3. Ходоод 12 хуруу гэдэсний шимэгдэлт алдагдсанаас
4. Эпителийн нөхөн төлжилт алдагдснаас
5. Бүх витамин дутагдлаас

/340./ Хүний биед төмөр ямар ямар хэлбэрээр нөөцлөгдөх вэ

1. Миоглобин
2. Гемоглобин
3. Ферритин
4. Апоферритин
5. Дотоод фактор

/341./ Төмрийн бэлдмэлийн гаж нөлөөг ол?

1. Шүд харлах
2. Өтгөн хатах
3. Хэвлийгээр өвдөх
4. Төмрийн хурц хордлого
5. Төмрийн архаг хордлого

/342./ Та өвчтөнд миелофиброз өвчин сэжиглэж байгаа бол ямар шинжилгээ төлөвлөх вэ ?

1. Захын цусны дэлгэрэнгүй шинжилгээ, захын цусны түрхэц
2. Биохимид билирубин, ШФ ба АПАТ, шээсний хүчил.
3. Ясны хэмийн эсийн болон эдийн шинжилгээ
4. Цитогенетик
5. MRI

/343./ Миелофиброз өвчний сэжиглэж байгаа тохиолдолд оношийг батлах шинжилгээ аль нь вэ?

1. Ясны хэмийн эдийн шинжилгээнд цус төлжүүлэх эсүүдийн хэсэг бөөгнөрөл нь холбогч эдэн ретикулины бүдүүн ширхгүүдтэй хамт алаг цоог харагдана. Цитогенетикт хромсомын гажгууд илэрнэ.

2. Ясны хэмийн эсийн шинжилгээнд мегакариоцит ихсэх

3. MRI-д холбогч эд ихтэй ясны хэмийг, ЭХО-д дэлүүнд үүссэн холбогч эдэн голомтыг илрүүлэх

4. Гавлын ясны рентгенд остеолизын голомтыг илрүүлэх

5. Ясны хэмийн эсийн шинжилгээнд миелобластуудыг илрүүлэх

/344./ Бөөрний өвчний үеийн цус багадалтын хувьд дараах зүйлс үнэн болно.

1. Цус багадалтын хүнд хөнгөн нь бөөрний үйл ажиллагааны дутагдлын зэргээс хамаардаг.

2. Цус багадалт үүсч байгаа гол механизм нь эритропоэтины ялгаралт багасах юм.

3. Уремийн үед ялтсын тоо цөөрснөөр цус алдаж, төмөр дутагдалд хүргэх ба диализ хийлгэж байгаа өвчтнүүдэд фолийн хүчлийн дутагдал үүсдэг.

4. Цусанд эритропоэтины түвшин өндөр байна.

5. Биохимид төмөр, төмөр холбох чадал, трансферрины төмрөөр ханалт ихэсдэг.

/345./ Эритропоэтин эмчилгээний гаж нөлөөг заана уу.

1. Артерийн даралт буурах

2. Эритромиальги илрэх

3. Цус гоожимтгой болох

4. Артерийн даралт ихсэх

5. Нүүр улайх

/346./ Витамин В12 дутлын цус багадалтын эмнэлзүйн шинжүүдийг сонгоно уу?

1. Лактсан хэл

2. Хюнтерийн глоссит

3. Фуникулийн миелоз

4. Элэг дэлүү бага зэрэг томрох

5. Хөлний эрээн булчин бадайрах

/347./ Витамин В12 дутлын цус багадалтын үед мэдрэлийн талаас илрэх өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?

1. Хорхой гүйж байгаа юм шиг ирвэгнэх

2. Үнэрлэх, амтлах сонсох чадвар алдагдана
3. Халуун хүйтэн мэдрэх мэдрэхүй алдагдана
4. Хөлний эрээн булчин бадайрах
5. Хөлний ул бамбайсан юм шиг мэдрэгдэх

/348./ Витамин В12 дутлын цус багадалтын захын цусны түрхцийн шинжилгээнд юу харагдах вэ?

1. Жоль Хаулын биет
2. Кеботын цагираг
3. Нейтрофилийн тасархайжилт олшрох
4. Хадуур хэлбэртэй эритроцит
5. Бай хэлбэрийн эс

/349./ Витамин В12 –ын солилцооны талаарх дараах мэдээллүүдийн аль нь зөв бэ?

1. Ходоодны хүчлийн нөлөөгөөр 2 валенттай болж хувирна
2. 12 хуруу гэдсэнд R уургаас салж дотоод фактортой холбогдоно
3. Нарийн гэдэсний дээд хэсэгт шимэгдэнэ
4. Нарийн гэдэсний доод хэсэг цутгалан гэдсэнд шимэгдэнэ
5. Трансферрин уурагтай холбогдон ясны чөмөг рүү зөөгдөнө

/350./ Төмөр дутлын цус багадалтын үед бодит үзлэгээр илэрч болох өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?

1. Үс унаж, хугарамтгай салаалсан
2. Койлонихи
3. Пламмер-Винсоны хам шинж
4. Тохой өвдөгний арьсанд гиперкератоз илэрсэн
5. Хэлний хөхлөг мөлийж, хагарсан.

/351./ Төмөр дутлын цус багадалтын оношийг батлах, шалтгааныг илрүүлэх зорилгоор ямар шинжилгээ хийх вэ?

1. Сийвэн дэх төмрийн агууламж
2. Сийвэн дэх ферритиний хэмжээ
3. Десфералын сорил
4. Грегерсений урвал
5. Цусанд вит В 12-ын хэмжээг үзэх

/352./ Төмөр дутлын ЦБ-г ямар өвчнүүдээс ялган оношлох вэ?

1. Сидеробластын ЦБ
2. Таласеми
3. Архаг өвчний суурь дээр үүсэх цус багадалт
4. Вит В12 дутагдлын анеми
5. Гипоаплазийн цус багадалт

/353./ Төмөр дутлын маш хүнд зэргийн ЦБ-тай өвчтөнд хамгийн түрүүнд хийгдэх эмчилгээг сонгоно уу?

1. Ижил бүлгийн даршилсан улаан бөөмийн цул
2. Төмрийн бэлдмэл 300 мг-р өдөрт 1-2 удаа уулгах
3. Шалтгааны эсрэг эмчилгээ
4. Цианокобаламин 500 мкг-р өдөрт 2 удаа тарих
5. Фолийн хүчил өдөрт 1 млг-р уух

/354./ Төмөр дутлын ЦБ-н эмчилгээний үр дүнг хянах үзүүлэлтүүдийг сонгоно уу?

1. Цусан дах HGB-ний агууламж ихсэх
2. Ретикулоцитын тоо ихсэнэ.
3. Сидеропенийн хам шинж засрах
4. Гранулоцитууд олшрох
5. Цусан дах эритропоэтины хэмжээ ихсэх

/355./ Цусны хурц хавдрыг оношлоход зайлшгүй шаардлагатай шинжилгээнүүдийг эмчлүүлэгчид зааж өгнө үү?

1. Захын цусны дэлгэрэнгүй шинжилгээ
2. Цитохимийн шинжилгээ
3. Цитокинетикийн шинжилгээ
4. Ясны чөмөгний эсийн шинжилгээ

5. Иммунофенотипийн шинжилгээ

/356./ Ясны чөмөгний эсийн болон цитохимийн шинжилгээнд илэрсэн доорх өөрчлөлтүүд нь хурц миелобластын лейкозын оношлогооны шалгуур болно?

1. Бласт 5%-иас их байх
2. Бласт 20%-иас их, Ауэрийн биенцэр байх
3. Миелопероксидазын урвал сөрөг байх
4. Миелопероксидазын урвал тод илрэх
5. Гликогений урвал эерэг байх

/357./ Засралд хүргэх (индукц) эмчилгээний дүнд засралд орсныг нотлох үзүүлэлтүүдийг сонгоно уу?

1. Ясны чөмөгт бласт 5%-иас бага болох
2. Захын цусанд лейкоцитийн тоо 2.5 мянгаас дээш байх
3. Захын цусанд тромбоцитийн тоо 100 мянгаас дээш байх
4. Захын цусанд гемоглобины хэмжээ 120 г/л-ээс их байх
5. Захын цусанд бласт эрс буурах

/358./ Архаг миелолейкозтой өвчтөнд цитогенетикийн шинжилгээгээр илрэх өвөрмөц өөрчлөлтийг нэрлэнэ үү

1. t(15;17)(q22;q21)
2. inv(3)(q21;q26)
3. Del(9q)
4. t(9; 22)(q34;q11)
5. t(6;9)(q23;q34)

/359./ Архаг миелолейкозын морфологийн ямар хэлбэрүүд байдаг вэ?

1. Эозинофилийн хэлбэр
2. Базофилийн хэлбэр
3. Нейтрофилийн хэлбэр
4. Промиелоцитийн хэлбэр
5. Миеломонобластын хэлбэр

/360./ Доорх өөрчлөлтүүдээс аль нь архаг миелолейкозын даамжралын шатанд орсныг илтгэх вэ?

1. Цагаан эсийн тоо ихсэх
2. Хромосомын нэмэлт гаж өөрчлөлтүүд илрэх
3. Ясны улаан чөмөгний эсийн шинжилгээнд бласт эсийн тоо ихсэх ( $\geq 10$ ) шинжилгээнд
4. Трепанобиопси-д өөхний эсүүд ихээр илрэх
5. тромбоцитоз

/361./ Дэлүүний томрол халууралттай хавсран илэрдэг ямар эмгэгүүд байдаг вэ?

1. Үжил
2. Бактерийн эндокардит
3. Цусаар түгсэн сүрьеэ
4. Дэлүүний буглаа
5. Бруцеллез

/362./ Удамшлын микросфероцитоз өвчний үед илрэх шинжилгээнд гарах өөрчлөлтийг сонго

1. Гиперхромын макроцитын ЦБ, гипербилирубинеми, ретикулоцитоз
2. Гипохромын микроцитын ЦБ, гипербилирубинеми
3. Нормохромын нормоцитын ЦБ, гипербилирубинеми
4. Ретикулоцитоз, микросфероцитоз
5. Ретикулоцитопени, гипербилирубинеми

/363./ Гемофили өвчний эмнэлзүйн шинжүүдийг нэрлэнэ үү?

1. Арьсан доорх өөхөн эдэд булчинд цус хурах
2. Үенд цус хурах
3. Гэмтлийн дараа хэсэг хугацаа өнгөрөөд цус гоожиж эхлэх
4. Гэмтлийн дараа шууд цус гоожиж эхлэх
5. Салстын цус алдалтууд хавсрах

/364./ Гемофили өвчний үед доорх хүндрэл илэрнэ.

1. Архаг артропати
2. 8-р хүчин зүйлийн эсрэг бие үүсэх

3. Элэгний В ба С вирусын халдварт өртөх
  4. Тромбоцитын тоо огцом буурах
  5. Дэлүү томрох
- /365./ Гемофили А өвчний үед хийгдэх эмчилгээг сонгоно уу ?
1. Криопериципитат
  2. VIII факторын концентрат
  3. Шинэ хөлдөөсөн сийвэн
  4. Цагаан эсгүйжүүлсэн улаан бөөм
  5. Тромбоцитын масс
- /366./ Гемофилитэй өвчтөнд та ямар зөвлөгөө өгөх вэ?
1. Зөөлөн холгохгүй эдээр өвдөг, тохойн хамгаалалт хийж өмсөх
  2. Ханиад томуу хүрсэн үед аспирын, индометин зэрэг эмүүдийг хэрэглэхгүй байх
  3. Арьсан дор, булчин тариа хийлгэхгүй байх
  4. Цус алдсан үед яаралтай эмнэлэгт ирэх
  5. Гүйж харайх , мотоцикл дугуйгаар явахыг хориглоно.
- /367./ Тромбоцитопенийг хүндрэлийн зэргээр нь хэрхэн ангилах вэ?
1. Тромбоцитын тоо 150,000-100,000 бол хөнгөн
  2. Тромбоцитын тоо 100,000-50,000 бол дунд
  3. Тромбоцитын тоо 50,000-20,000 бол хүнд
  4. Тромбоцитын тоо 20,000-с бага бол маш хүнд
  5. Тромбоцитын тоо 10,000-с бага бол аюултай хүнд зэрэг гэж үзнэ.
- /368./ Аутоиммун тромбоцитопени үед шинжилгээнд гарч болох өөрчлөлтүүдийг нэрлэнэ үү?
1. Цусны түрхцэнд том тромбоцит харагдана, тромбоцитын эзэлхүүн нэмэгдэнэ
  2. Цусны бүлэнгийн агчих чадвар муудна.
  3. Иммунологийн шинжилгээнд Ig G-ын түвшин өндөр байна.
  4. Ясны хэмийн шинжилгээнд мегакариоцит алга болсон байна.
  5. Ясны чөмөгний эдийн шинжилгээнд эсжилт буурсан байна.
- /369./ Тусмал цус гоожимтгой эмгэгүүдэд дараах эмгэгүүд орно.
1. Антикоагулянт эмчилгээ: Гепарин, Варфарин, Тромболитикүүд
  2. Витамин К-ийн дутагдал, Элэгний өвчин
  3. Судсан дахь түгмэл бүлэгнэлтийн хам шинж (СТБХШ)
  4. Цус бүлэгнэлтийн хүчин зүйлүүдийн эсрэг саатуулагч- эсрэгбие үүсэх
  5. Их хэмжээний цус сэлбэлтийн улмаас үүсэх коагулопати
- /370./ Харьцангуй эритроцитозод дараахь эмгэгүүдийн үед тохиолдоно
1. Хуурамч полицитеми
  2. Стресс эритроцитоз
  3. Гейсбахын хам шинж
  4. Хоёрдогч эритроцитоз
  5. Нойрсох үеийн апноэ
- /371./ Цус бүлэгнэлтийн анхдагч гемостазын үе шатыг нэрлэнэ үү?
1. Гэмтсэн судас агших үе
  2. Ялтас наалдах үе
  3. Ялтсын бөөгнөрөл үүсэх үе
  4. Ялтсын бүлэн задрах үе
  5. Ялтсын бүлэн үүсэх үе
- /372./ Шенлойн Генохын өвчний эмнэлзүйн хэлбэрийг заана уу?
1. Арьсны хэлбэр
  2. Үений хэлбэр
  3. Хэвлийн хэлбэр
  4. Тархины хэлбэр
  5. Зүрхний хэлбэр
- /373./ Төмөр дутлын цус багадалт үед дараахь өөрчлөлтийн аль нь илрэх вэ?
1. Сийвэнгийн төмөр багассан байх
  2. Сийвэнгийн төмөр холбох чадвар ихэссэн байх
  3. Трансферриний төмрөөр ханалт буурсан байх
  4. Сийвэнгийн витамин В12 буурсан байх



5. Сийвэнгийн фолийн хүчил буурсан байх
- /374./ Төмөр дутлын цус багадалтын хөнгөн зэргийн эмчилгээний зарчим юу байх вэ?
1. Гидроксикобаламин 500мкг-р өдөр бүр тарих
  2. Төмрөөр баялаг хол хүнс хэрэглэх
  3. Гидроксикобаламин 500мкг-р өнжөөд тарих
  4. Төмрийн бэлдмэл хоногт 150мг-р уулгах
  5. Төмрийн бэлдмэл өдөр бүр тарих
- /375./ Дараах эмгэгүүдийн үед судсанд цус задарна
1. Тохироогүй бүлгийн цус юүлэх
  2. Халдвар
  3. Хүйтний шалтгаант аутоиммуны гемолиз
  4. Ферментопати
  5. Шөнийн шээсэнд гемоглобин гэнэт гарах эмгэг
- /376./ Аутоиммун цус задралын цус багадалтын эмгэг жамын механизмыг тайлбарлана уу?
1. Судсан дотор цус задарна
  2. Эдийн дотор цус задарна
  3. Глобины бүтцийн өөрчлөлт, глобины гинжний нийлэгжилт алдагдснаас
  4. Улаан эсийн гадаргуугийн антигений эсрэг, ауто эсрэг бие үүссэнээр цус задрана
  5. Г-6-ФДГ ферментийн дутагдлын улмаас үүсдэг эмгэг
- /377./ Перинаталь анагаах ухаан гэдэг нь:
- A. Жирэмсний бүх хугацаанд ураг судлал
  - B. Төрсний дараах нярайн судлал
  - C. Жирэмсний 22 долоо хоног дотор ураг судлал
  - D. Жирэмсний 22 долоо хоногоос төрсний дараах 7 хоногт ураг, нярай судлал
  - E. Жирэмсний 22 долоо хоногоос төрсний дараах 21 хоногт ураг нярай судлал
- /378./ Пренатал анагаах ухаан гэдэг нь:
- A. Жирэмсний бүхий л хугацаанд ураг судлах
  - B. Төрсний дараах нярайн судлал
  - C. Жирэмсний 21 долоо хоног дотор ураг судлал
  - D. Жирэмсний 39-40 долоо хоногийн дотор ураг судлал
  - E. Жирэмсний 21-40 долоо хоногийн хугацааны ураг судлал
- /379./ Нярайн дундаж жин хэдэн грамм /гр/ байх вэ?
- A. 2500 гр орчим
  - B. 2500-2600 гр
  - C. 3300-3700 гр
  - D. 4300-4500 гр
  - E. 4500 гр-аас дээш
- /380./ Эрт нярай үе гэдэгт аль нь хамаарах вэ?
- A. Төрсний дараах нярайн 12 цаг
  - B. Төрсний дараах нярайн 24 цаг
  - C. Төрсний дараах нярайн 7 хоног хүртэл
  - D. Төрсний дараах нярайн 21 хоног хүртэл
  - E. Төрсний дараах нярайн 30 хоног хүртэл
- /381./ Төрөлтийн II үе хэзээнээс эхлэх вэ?
- A. Ургийн түрүүлсэн хэсэг сууснаар
  - B. Дүлэлт эхэлнээр
  - C. Ургийн толгой дотор эргэснээр
  - D. Умайн амсар бүрэн нээгдсэнээс
  - E. Ураг орчмын шингэн гарснаар
- /382./ Умайн гаднах жирэмслэлт ихэвчлэн хаана байрлах вэ?
- A. Гуурсан хоолойн нарийн хэсэгт
  - B. Гуурсан хоолойн өргөн хэсэгт
  - C. Өргөн холбоосонд
  - D. Өндгөвчинд
  - E. Хэвлийн хөндийд
- /383./ Умайд ерөндөг тавихад анхаарах зүйл:

- A. Биений юм ирээд дуусах үед умайд тавина
- B. Заавал стационарын нөхцөлд тавина
- C. Зуршсан байдлаар үр зулбадаг эмэгтэйчүүдэд хэрэглэхгүй
- D. Даралт ихтэй эмэгтэйчүүдэд хэрэглэхгүй
- E. Цус багадалттай бол хэрэглэхгүй

/384./ Жирэмсэн үед умдагны үений хоорондох зай хэд см хүртэл өргөсөж болох вэ?

- A. 0,1 – 0,3 см
- B. 0,4 – 0,6 см
- C. 0,7 – 0,9 см
- D. 1,0 – 1,2 см
- E. 1,3 – 1,5 см

/385./ Үр хөврөлийн эхийн биетэй холбогдох тэр үйл явцыг юу гэж нэрлэх вэ?

- A. Гастрюляци
- B. Ихэсжих
- C. Имплантаци
- D. Эмбриогенез
- E. Үр тогтох

/386./ Жирэмсний эхний 3 сарыг ямар үе гэж нэрлэх вэ?

- A. Органогенезийн үе
- B. Үр хөврөлийн үе
- C. Ихэсжих үе
- D. Ургийн үе
- E. Умайд бэхлэгдэх үе

/387./ Аль нь ургийн гадаад орчин болдог вэ?

- A. Хорион
- B. Умай
- C. Шар уутанцар
- D. Аллантаис
- E. Амнион

/388./ 1000 гр жинтэй нярай төрөөд 2 хоногийн дараа нас барсан бол ямар эндэгдэлд хамаарах вэ?

- A. Антенаталь
- B. Пренаталь
- C. Интранаталь
- D. Неонаталь
- E. Перинаталь

/389./ 17. С. 36 настай, 37 долоо хоногтой. Нийт 5 удаа жирэмсэлж 2 удаа төрсөн. Сүүлийн сард 2 удаа цуслаг зүйл үтрээнээс гарч байсан. Базлалт эхлэхэд их хэмжээтэй цус алдсан, умайн хүзүү 1,5 см нээлттэй, ургийн толгой бага аарцгийн орох хэсгийн дээр, УЗЦ тод жигд, 1 хоромд 140 удаа, үтрээний үзлэгээр түрүүлсэн хэсэг тодорхой мэдэгдэхгүй. Ямар эмгэг байж болох вэ?

- A. Дутуу төрөлт
- B. Ихэс ховхролт
- C. Умайн урагдал
- D. Ихэс түрүүлэлт
- E. Умайн хүзүүний дутмагшил

/390./ С. 36 настай, 37 долоо хоногтой. Нийт 5 удаа жирэмсэлж 2 удаа төрсөн. Сүүлийн сард 2 удаа цуслаг зүйл үтрээнээс гарч байсан. Базлалт эхлэхэд их хэмжээтэй цус алдсан, умайн хүзүү 1,5 см нээлттэй, ургийн толгой бага аарцгийн орох хэсгийн дээр, УЗЦ тод жигд, 1 хоромд 140 удаа, үтрээний үзлэгээр түрүүлсэн хэсэг тодорхой мэдэгдэхгүй. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Амниотомии
- B. Кесармэс засал
- C. Окситоцины сэдээлт
- D. Цус тогтоох эмчилгээ
- E. Партограмм хөтлөж хянана

/391./ Ж., 25 настай 3650 гр хүү төрүүлсэн, хойтохийг идэвхитэй аргаар гаргасан. Хойтхыг шалгахад бүтэн. Төсрний дараа умайд иллэг хийхэд 600 мл цус гарсан. Юу тохиолдсон байж болох вэ?

- A. Ихэс үлдсэн
- B. Умайн агшилт суларсан
- C. Умай урагдсан
- D. ДВС
- E. Умайн хүзүү урагдсан

/392./ Ж., 25 настай 3650 гр хүү төрүүлсэн, хойтохийг идэвхитэй аргаар гаргасан. Хойтхыг шалгахад бүтэн. Төсрний дараа умайд иллэг хийхэд 600 мл цус гарсан. Эмэгтэйд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Умайд чихээс хийнэ
- B. Умайн хөндийг багажаар хусна
- C. Умайн хөндийг гараар шалгаж иллэг хийнэ
- D. Цус сэлбэнэ
- E. Ажиглана

/393./ Төрсний дараах үеийн үргэлжлэх хугацаа :

- A. 7 хоног
- B. 2 долоо хоног
- C. 4 долоо хоног
- D. 5 долоо хоног
- E. 6 долоо хоног

/394./ Нярайг эрт амлуулах

- A. Төрсний дараа шууд
- B. Төрснөөс хойш 2 цагийн дотор
- C. 4-5 цагийн дараа
- D. Төрсний дараа эхний 12 цагийн дотор
- E. Хугацаа хамааралгүй

/395./ Дааврын хавсарсан эмийн үйлчлэлийг нэрлэнэ үү

- A. Өндгөн эс боловсролтыг саатуулна
- B. Умайн хүзүүний салиаг өтгөрүүлнэ
- C. Эр бэлгийн эсийн хөдөлгөөнийг хязгаарлана
- D. Умайн салстын шүүрлийн үйл ажиллагааг дарангуйлна
- E. ФСГ болон ЛГ харьцааг хэвийн болгоно

/396./ Эх барихын “хярзан” гэдэгт аль хэсэг хамрах вэ?

- A. Ахар сүүл арын заадасны хоорондох хэсэг
- B. Бэлгийн уруулын арын заадас болон хошногоны амсарын хооронд
- C. Хошног ахар сүүлний хооронд
- D. Умдагны доод ирмэгээс хошногоны амсар хүртэл
- E. Шээсний сүвнээс хошногоны амсар хүртэл

/397./ “Ургийн үе” жирэмсний аль хугацаанаас эхэлдэг вэ?

- A. 12 долоо хоногтойгоос
- B. 16 долоо хоногтойгоос
- C. 18 долоо хоногтойгоос
- D. 20 долоо хоногтойгоос
- E. 22 долоо хоногтойгоос

/398./ Өсөлтгүй жирэмсэн үед дараах өөрчлөлтүүд голчлон илэрнэ

- A. Коагулопати
- B. Тасралтгүй бөөлжилт
- C. Даралт ихсэх
- D. Цус багадалт
- E. Шээсээр уураг алдах

/399./ Умайн доод сегмент жирэмсний хэдий хугацаанаас үүсэж эхэлдэг вэ?

- A. 16 долоо хоног
- B. 18 долоо хоног
- C. 20 долоо хоног

D. 22 долоо хоног

E. 24 долоо хоног

/400./ Биений юм 20 хоног саатасны дараа үтрээнээс цусархаг ялгарал гарч байгаа бол дараах эмгэгийн аль нь байж болох магадлалтай вэ?

A. Умайн хүзүүний шархлаа

B. Умайн гаднах жирэмсэн

C. Зулбахыг завдах

D. Цулцан хураа

E. Умайн хоргүй хавдар

/401./ Н., 26 настай эмэгтэйн БЮМ ирэхгүй 2 сар болсон, хэвлийн доод хэсгээр өвдөнө гэсэн зовиуртай үзүүлэхэд умайн хэмжээ галууны өндөг хэрийн том, умайн хүзүү хаалттай, дайврууд хэвийн, доошоо гарсан зүйлгүй байв. Ямар эмгэг байж болох вэ?

A. Өсөлтгүй жирэмсэн

B. 2 сартай жирэмсэн зулбахыг завдаж буй

C. Умайн гаднах жирэмсэн

D. Умайн хоргүй хавдар

E. Цулцан хураа

/402./ Жирэмсний эрт хугацаанд хамгийн элбэг тохиолддог хүндрэлийг нэрлэнэ үү:

A. Зулбалт

B. Жирэмсний бөөлжилт

C. Цус багадалт

D. Даралт багасах

E. Цистит

/403./ Дутуу төрөхөд нөлөөлөх гол шалтгааныг нэрлэнэ үү:

A. Нас

B. Тамхи татах

C. Ургийн бөгс түрүүлэлт

D. Таргалалт

E. Хожуу хугацаанд 3 түүнээс олон удаа зулбах

/404./ Жирэмсний эртхугацаанд аяндаа зулбахад нөлөөлөх үндсэн шалтгааныг нэрлэнэ үү:

A. Резус үл тохироо

B. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй байх

C. Халдвар

D. Умайн хүзүүний дутмагшил

E. Хромосомын эмгэг

/405./ Эхэлсэн зулбалтын үед ямар арга хэмжээ авах вэ?

A. Умайг багажаар хусаж цэвэрлэнэ;

B. Антибиотик эмчилгээ хийнэ

C. Эмнэлэгт хэвтүүлнэ

D. Гэрээр хяналтанд байлгана.

E. Мизопростол уулгана

/406./ Ц.32 настай, их хэмжээтэй цус алдаж эмнэлэгт ирсэн. Үзлэгээр умайн хүзүү богиносож 1 хуруу орох нээлттэй, умай галууны өндгөн чинээ хэмжээтэй, үтрээнээс цус ихээр гарна. Урьдчилсан оношийг тавина уу?

A. Өндгөвчийн цус алдалт

B. Умайн хоргүй хавдар

C. Умайн гаднах жирэмсэн

D. Цулцан хураа

E. Бүрэн биш зулбалт

/407./ Ургийн нуруулалт гэдэг нь:

A. Ургийн нуруу эхийн хажуу хана руу харьцаж байрласан

B. Ургийн нуруу эхийн урд хана руу харьцаж байрласан

C. Ургийн нуруу ард хана руу харьцаж байрласан

D. Ургийн нуруу эхийн умайн дагуу тэнхлэгт харьцаж байрласан

E. Ургийн нуруу умайтай хурц өнцөг үүсгэж харьцаж байрласан

/408./ Хэвийн явцтай жирэмсэн үед ямар шинжилгээг заавал хийх шаардлагагүй вэ?

- A. Серологийн сорил
  - B. Цусны резус-фактор
  - C. Гемоглобины хэмжээг тогтоох
  - D. Цэлмэнгийн ганодотропин даавар тодорхойлох
  - E. Наалдац болон эсийн шинжилгээ
- /409./ Умайн гуурсан хоолойн битүүрлийг шалгах “алтан стандарт” аргыг нэрлэнэ үү
- A. Гистеросальпингографи
  - B. Пневмопельвиографи
  - C. Кульдоскопи
  - D. Лапароскопи
  - E. Пертубаци
- /410./ 36 настай эмэгтэй, доошоо цус их гарна гэж ирсэн бол ямар шинжилгээг хийх нь чухал вэ?
- A. Бамбайн дааврын шинжилгээ
  - B. Гистеросальпингографи
  - C. Кольпоцитологи
  - D. Бэлгийн даавар тодорхойлох
  - E. Умайн салстыг хусаж цэвэрлэх
- /411./ Жирэмсний 37 долоо хоногтойд зовиургүйгээр үтрээнээс цус гарч байвал эхний ээлжинд ямар арга хэмжээ авах вэ?
- A. Цусны бүлэгнэлтийг тодорхойлно
  - B. Үтрээнд толь тавьж харна
  - C. Яаралтай кесар хагалгаагаар төрөлтийг шийднэ
  - D. Төрөлтийг сэдээнэ
  - E. Ургийн бүрхүүл хальсыг хагална
- /412./ Умайд ерөндөгтэй жирэмсэлсэн үед хамаарал багатайг нэрлэнэ үү
- A. Умайн гаднах жирэмсэн үүснэ
  - B. Өсөлтгүй жирэмсэн илүү тохиолдоно
  - C. Дутуу төрөлт үүснэ
  - D. Ургийн гаж хөгжил үүсэх эрсдэл нэмэгдэнэ
  - E. Аяндаа зулбалт үүснэ
- /413./ Жирэмсэн, төрөлт, төрсний дараа шээсний замын хурц халдвар үүсэж болох эрсдэлт хүчин зүйлд юунаас бусад нь хамаарахыг нэрлэнэ үү
- A. Умай томорч шээлгүүрийг дарснаас
  - B. Шээлгүүрийн хүчдэл нэмэгдэж гүрвэлзэх хөдөлгөөн нэмэгдсэнээс
  - C. Шинж тэмдэггүй бактериури
  - D. Эпидураль мэдээ алдуулалтын дараа давсангы хүчдэл буурснаас
  - E. Төрсний дараа давсанд катетер тавснаас
- /414./ Ямар судлаачийн аргаар ургийн жинг жирэмсэн эмэгтэйн биеийн жингийн 1/20-тэй тэнцүү гэж тодорхойлох вэ?
- A. И.Ф.Жордания
  - B. З.С.Стройков
  - C. Л.И.Бубличенко
  - D. З.П.Якубов
  - E. М.М.Медведев
- /415./ Давтан төрөгчдөд ургийн хөдөлгөөн жирэмсний хэдэн долоо хоногтойд мэдрэгдэх вэ?
- A. 13 долоо хоногтойд
  - B. 18 долоо хоногтойд
  - C. 23 долоо хоногтойд
  - D. 24 долоо хоногтойд
  - E. 26 долоо хоногтойд
- /416./ Ургийн хөдөлгөөнийг хэт авиан шинжилгээгээр хэдэн долоо хоногтойгоос оношлох боломжтой вэ?
- A. 2 долоо хоногтойд
  - B. 7 долоо хоногтойд
  - C. 12 долоо хоногтойд

D. 13 долоо хоногтойд

E. 15 долоо хоногтойд

/417./ Жирэмсний хожуу хугацаанд ургийн зүрхний агшилт/ цохилт нэг хоромд хэдэн удаа байх вэ?

A. 100-110 удаа

B. 120-150 удаа

C. 160-180 удаа

D. 180-190 удаа

E. 190-ээс дээш

/418./ Жирэмсний хэдэн долоо хоногтойгоос ургийн байрлал тогтворжих вэ?

A. 20-25 долоо хоногтойд

B. 26-28 долоо хоногтойд

C. 29-34 долоо хоногтойд

D. 35-36 долоо хоногтойд

E. >37 долоо хоногтойд

/419./ Өмөн умайн хүзүүнээс халиагүй, тулгуур эдрүү 2мм орчим түрсэн, хавдрын голч 1см-ээс ихгүй тохиолдолд хавдрын үе шатыг хэлнэ үү?

A. 0 шат

B. 1а шат

C. 1б шат

D. 2а шат

E. 2б шат

/420./ Ураг хөндлөн байрласан үед ургийн зүрхний цохилт хаана тод сонсогдох вэ?

A. Эхийн хүйнээс доор

B. Эхийн хүйнээс дээр

C. Эхийн хүйн баруун эсвэл зүүн талд

D. Эхийн аюулхай орчим

E. Умдаг ясны орчим

/421./ Ураг бөгсөөр түрүүлсэн үед ургийн зүрхний цохилт хаана тод сонсогдох вэ?

A. Эхийн хүйсний баруун эсвэл зүүн талд

B. Эхийн хүйсний баруун талд

C. Эхийн хүйсний зүүн талд

D. Эхийн хүйснээс дээр

E. Эхийн хүйснээс доор

/422./ Хэт тарган жирэмсэн эхэд ургийн байрлалыг тодорхойлох хамгийн найдвартай арга юу вэ?

A. Асуух арга

B. Леополдын үзлэгийн I арга

C. Леополдын үзлэгийн II арга

D. Леополдын үзлэгийн III арга

E. Хэт авиан шинжилгээ

/423./ Ураг орчмын шингэн жирэмсний 39-40 долоо хоногтойд хэдэн мл байвал хэвийн гэж үзэх вэ?

A. 400-500 мл

B. 500-600мл

C. 700-800 мл

D. 1000-1500 мл

E. >1500л

/424./ 36 долоо хоногтой ихэр ургийг эх барихын тусгайлсан үзлэгээр оношлоход хамгийн магадлалтай шинж аль нь вэ?

A. Үтрээн үзлэг

B. Ургийн түрүүлсэн хэсэг толгой байх

C. Гэдэсний эргэн тойрон 100 см-ээс их

D. Ургийн толгой аарцгийн хөндийд суусан байх

E. Умайн ёроол хүйс аюулхайн хооронд байх

/425./ Ураг орчмын шингэн хэзээ гарвал хэвийн гэж үзэх вэ?

- A. Жирэмсний 39 долоо хоногтойгоос хойш
  - B. Жирэмсний дунших үед
  - C. Төрлөгийн I үеэжлэнгүүт
  - D. Умайн хүзүү 6 см нээгдснээс хойш
  - E. Умайн хүзүү бараг бүрэн нээгдэх үед
- /426./ Ямар шалтгааны улмаас улаан хоолой гэнэт хагарах вэ?
- A. Улаанхоолой дурандахүед
  - B. Амсрын нарийсалтийг тэлэх үед
  - C. Бөөлжих үед
  - D. Ястай мах залгих үед
  - E. Хүчил уухад
- /427./ Улаан хоолойн цүлхэнгийн ангилалд аль нь хамаардаг вэ?
- A. Гэмтлийн
  - B. Үрэвслийн
  - C. Нэвчтэст
  - D. Татагдсан /тракционний/
  - E. Холимог
- /428./ Тиреотоксикоз өвчний оношийг батлахад ямар шинжилгээ хийх нь чухал вэ?
- A. Бамбай булчирхайгаас дээж авах
  - B. Уураг, холбогч йодыг тодорхойлох
  - C. Сцинтиграфи
  - D. Радио идэвхт йодоор шинжлэх
  - E. Тироксин-П4-ийг тодорхойлох
- /429./ Гол судасны хавхлагын дутагдлын үеийн шинж:
- A. Гол судас нь нийтдээ өргөснө
  - B. Гол судасны өгсөх хэсэг нь өргөснө
  - C. Гол судас нь нийтдээ нарийсна
  - D. Гол судас өөрчлөгдөхгүй
  - E. Зүүн ховдлын хэмжээ багасна
- /430./ Хиймэл хавхлагатай өвчтөнд үүсэх хүндрэл
- A. Тромбоз ба тархмал эмболи
  - B. Парапротезын фистул ба протезын үйл ажиллагаа алдагдах
  - C. Халдварын эндокардит
  - D. Цус шүүрэмтгий болох/цусны бүлэгнэлт өөрчлөгдөх
  - E. Бүгд
- /431./ Ховдол хоорондын таславчийн цоорхой өөрөө аяндаа хаагдах нь ихэвчилэн дараах насанд тохиолдоно.
- A. 1 нас хүртэл
  - B. 2 нас хүртэл
  - C. 4 нас хүртэл
  - D. 4 наснаас хойш
  - E. Өөрөө аяндаа хаагдахгүй
- /432./ Гуяны гүн хураагуур судасны тромбозын үед хэрэглэх хамгийн зохимжтой эмчилгээ аль нь вэ?
- A. Гепарин
  - B. Хөндий венд шүүлтүүр суулгах
  - C. Стрептокиназа
  - D. Венийн тромбыг авах
  - E. Антибиотикийн эмчилгээ
- /433./ 48 настай эмэгтэйд эгэм доорх венд катетр тавьсаны дараа амьсгаадсан. Энэ ямар хүндрэлийн шинж вэ?
- A. Хийн эмболи
  - B. Пневмони
  - C. Катетр тавьсан талд пневмоторакс үүссэн
  - D. Эгэм доорх артери гэмтсэн
  - E. Эгэм доорх вен гэмтсэн

- /434./ Хураагуур судасны бүлэнт үрэвслийн дараах хам шинжийн үед ямар шинж илрэх вэ?
- A. Арьсан дээр хөх тууралт үүсэх
  - B. Хөлийн шилбээр хавагнах
  - C. Арьсан доорх хураагуур нарийсах
  - D. Арьсны өнгө өөрчлөгдөхгүй цоорох
  - E. Арьсан дээр шархлаа үүсэхгүй
- /435./ Облитерирующий эндоартеритийн үед илрэхгүй шинж нь аль вэ?
- A. Эрээн булчингаар өвдөх
  - B. Хөл хөхрөх
  - C. Хөл халуун оргих
  - D. Үе үе доголох
  - E. Тараагуур судасны лугшилт сул
- /436./ Уушигны буглаа үүсэх гол шалтгаан нь:
- A. Аспираци
  - B. Бронхи хавдраар дарагдах
  - C. Пневмококкийн хатгаа
  - D. Уушигны завсрын эдийн хатгаа
  - E. Сүрьеэ
- /437./ Уушигны буглаа цоороогүй үеийн шинж тэмдэг
- A. Өндөр халуурч чичрүүлнэ
  - B. Биеийн байдал хөнгөн байна
  - C. Биед хордлогын шинж үгүй
  - D. Их хэмжээний идээтэй цэр гарна
  - E. Цагаан эсийн тоо эрс олширно
- /438./ Цээжний хөндийд дотроосоо хий хурахын хүндэрсэн шинж тэмдэг:
- A. Уушигны гялтангийн шок
  - B. Амьсгал дутагдах шинж тэмдэг
  - C. Хүчилтөрөгч дутагдах, цусны эргэлтийн үйл ажиллагаа алдагдах
  - D. Өвдөлт
  - E. Цээжний хөндийн дунд завсарлагчийн эрхтэнүүд эсрэг тийшээ хазайх үйл ажиллагааны хямрал
- /439./ Цээжний хөндийд дотроосоо хий хуралдсан эмгэгийг эмчлэх арга:
- A. Тайван байлгаж, шимэгдүүлэх эмчилгээ хийх
  - B. Цээжний хөндийд пункц хийж, хийг соруулах
  - C. Цээжний хөндийд гуурс тавих
  - D. Хагалгаа хийх
  - E. Цээжний хөндийг дурандах
- /440./ Цээжний хөндийд дотроосоо хий хурсан эмгэгийн эмчилгээ үр дүн өгөхгүй байгаа шалтгааныг ямар шинжилгээгээр зөв илрүүлж чадах вэ?
- A. Цээжний хөндийн тойм рентген зураг
  - B. Уушигны зураг авах
  - C. Уушиг дурандах
  - D. Цээжний хөндийг дурандах
  - E. Хэт авиан шинжилгээ
- /441./ Голчийн үрэвсэл /медиастенит/ үүсэх гол шалтгаан нь юу вэ?
- A. Эрүү нүүрний идээт өвчин
  - B. Улаан хоолойн хураагуур судас өргөсөх
  - C. Ангиографи хийснээс
  - D. Бамбай булчирхайн үрэвсэл
  - E. Элэг цөсний замын идээт өвчин
- /442./ Паразит хорхой дараах хөнөөлийг бие махбодод үүсгэнэ
1. Архаг хордлого
  2. Ходоод гэдэсний замыг гэмтээх
  3. Биемахбодыг мэдрэмтгий болгож, харшил үүсгэх
  4. Мэдрэлийн тогтолцооны үйлийг хямраах
  5. Олон аминдэмийн дутагдал үүсгэх



- /443./ Гэнэт цээжний хөндийд дотроосоо хий хурах шалтгаан
- A. Уушигны архаг үрэвсэл
  - B. Уушигны буглаа
  - C. Цээжний гялтангийн наалдац салах
  - D. Цагаан мөгөөрсөн хоолойн үрэвсэл, уушигны багтраа
  - E. Уушигны уйланхайнууд
- /444./ Цээжний голчийн идээ үүсэх шалтгаан нь аль вэ?
- A. Улаан хоолойн гэмтэл
  - B. Цээжний бэртэл
  - C. Хүзүүний идээт үрэвсэл
  - D. Цусаар халдвар дамжих
  - E. Тунгалаг зангилаа задрах
- /445./ Залуу эмэгтэйд шингэн зүйл залгахад сааталтай, буцаж гулигуулж байв. Эзофагоманометрийн үед улаан хоолойн доод хуниас ажиллагаагүй байв. Ямар онош тавих вэ?
- A. Улаанхоолойн хорт хавдар
  - B. Пламмер-Винсоны синдром
  - C. Рефлюкс-эзофагит
  - D. Өрцний дээд талын улаан хоолойн дивертикул
  - E. Ахалази карди
- /446./ Ахалази үүсэх эмгэг жам аль нь вэ?
- A. Улаан хоолойн үрэвслээс
  - B. Улаан хоолойн доод сфинктерийн даралт өөрчлөгдсөнөөс
  - C. Юм залгахад анхдагч давалгаа доошоо чиглэлтэй үүсч кардийг нээдэг үйл ажиллагаа алдагдсанаас
  - D. ДХэвлийн доод даралт өөрчлөгдсөнөөс
  - E. Улаан хоолойн ханын анатоми өөрчлөгдсөнөөс
- /447./ Улаан хоолой гэмтэх үед гарах гол шинжийг нэрлэнэ үү?
- A. Юм залгахад сааталтай
  - B. Хоолой хоржигнож дуугарна.
  - C. Халуурна
  - D. Бөөлжинө
  - E. Хүзүүний арьсан дор хий хурна.
- /448./ Өрцний ивэрхийн үүсэх шалтгааныг заана уу?
- A. Өрцний улаан хоолойн нүх өргөн байх
  - B. Ходоодны холбоосын дутуу бэхэлгээ
  - C. Богино улаан хоолой
  - D. Хэвлийн доторх даралт гэнэт ихэссэн
  - E. Үе үе бөөлжих
- /449./ Тиреотоксикоз өвчний оношийг батлахад ямар шинжилгээ хийх нь чухал вэ?
- A. Бамбай булчирхайгаас дээж авах
  - B. Уураг, холбогч йодыг тодорхойлох
  - C. Сцинтиграфи
  - D. Радио идэвхт йодоор шинжлэх
  - E. Тироксин-П4-ийг тодорхойлох
- /450./ 42 настай өвчтөнд "тиреотоксикозын хүнд хэлбэр" гэдэг онош тавигджээ. Эмчилгээний оновчтой тактикийг заана уу.
- A. Яаралтай мэс засал хийх
  - B. Эмийн хавсарсан эмчилгээ
  - C. Эмээр эмчлэх, оршин суугаа газраар нь булчирхайн эмч хяналтандаа авах
  - D. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг авах
  - E. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг тайрах
- /451./ Олонтой тохиолддог бамбай булчирхайн үрэвсэлт өвчнүүдэд дараах өвчнүүдээс аль нь хамаарах вэ?
- A. Хурц тиреоидит буюу струмит
  - B. Гүвгэр тиреоидит де Кервена- Крайл

- C. Лифоматозон тиреоидит буюу Хашимот
- D. Ширхэнцэрт Риделягийн тиреоидит
- E. Гиперпаратиреоидизм

/452./ Зангилаат эутиреоид бахлуурын үед хийх мэс заслыг заана уу.

- A. Зангилааг хуулж авах
- B. Бамбай булчирхайг зангилааны хамт шаантаг хэлбэрээр авах
- C. Бамбай булчирхайн нэг талыг авах
- D. Бамбай булчирхайг тохирох хэмжээгээр үлдээж авах
- E. Бамбай булчирхайг бүгдийг авах

/453./ 40настай эрэгтэй. Бамбай булчирхай авахуулснаас хойш хэдэн цагийн дараа амьсгалахад хүнд байна гэж зовиурласан. Үзэхэд: Шуугисан амьсгалтай, хүзүүний шарх оройж чинэрсэн. Анхны ямар тусламж үзүүлэх вэ?

- A. Трахей-д гуурс тавих
- B. Трахеостоми хийх
- C. Хагалгааны нөхцөлд цустогтоох
- D. Шархыг нээж, гематомыг авах
- E. Гемотомоос пункцхийж соруулна

/454./ 30настай эмэгтэйд субтотал тиройдэктоми хийснээс 12 цагийн дараа өвчтөн цочролын байдалд орж амьсгал нь боогдсон. Үзэхэд тахикарди илэрсэн, хүзүүний урд хэсэгт овойсон, хагалгааны шархны боолт хуурай байв. Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Амаар нь цагаан мөгөөрсөн хоолойд гуурс тавих
- B. Хагалгааны шархыг нээх
- C. Цусан дахь кальцийг тодорхойлох
- D. Морфин тарих
- E. Хүчилтөрөгчөөр амьсгалуулах

/455./ Мэс заслын өмнө ходоод, арван хоёр хуруу гэдэсний цоорсон шархыг эвдрэлтэй цочмог мухар олгойн үрэвсэлээс ялгаж чадсангүй. Ямар мэс заслын ямар хүрдэц сонгох вэ?

- A. Хэвлийн дээд голын зүслэг
- B. Хэвлийн дээд голын зүслэгийг аймхай мөгөөрс хүртэл уртасган өргөтгөх
- C. Хэвлийн хажуугийн зүслэгийг хавирганы нум хүртэл өргөтгөх
- D. Мак-Бурнен, Дьяконов-Волковчийн аргаар хэвлийг нээж, цооролттой шархлааг олж илрүүлэхийн тулд хэвлийн дээд голын зүслэг нэмж хийх
- E. Хэвлийн голын өргөтгөсөн урт зүслэг

/456./ 12 хуруу гэдэсний шархлаатай өвчтөнд хэдийд мэс засал хийж болох вэ?

- A. Тухайн бүрдмэл эмийн эмчилгээ үр дүнгээ өгөөгүй бол
- B. Олон дахин дахилт өгөх
- C. Каллээ шархлаа, зэргэлдээх эрхтэнд нэвчсэн үед
- D. Ходоодны шүүсний хүчиллэг ихэссэн олон тооны шархлаануудтай
- E. Өвчний мэдүүлгээс олон дахин цус алдсан

/457./ 35-40 настай өвчтөний 12 хуруу гэдэсний шарх цоороод 6 цаг болжээ. Ямар төрлийн мэс засал хийх вэ?

- A. Цоорсон нүхийг оёж, тэнэмэл мэдрэлийг 2 ба 3-р салааг таслах
- B. Опель-Поликарповын аргаар цоорсон нүхийг оёх
- C. Цоорсон нүхийг оёх
- D. Ходоодыг анхдагчаар тайрах
- E. Тэнэмэл мэдрэлийн багана хэсгийг тайрч, нугалуурыг нөхөн сэргээх

/458./ 40-60 насны өвчтөнд ходоодны шарх цоороод 6 цаг болоогүй байвал ямар төрлийн мэс засал хийх нь тохиромжтой вэ?

- A. Ходоод тайрах
- B. Цоорсон шархыг оёх
- C. Шархны ирмэгээс эсийн шинжилгээ авч цоорхойг оёх
- D. Цоорхойг шаантаг хэлбэрээр өөлөн авч оёх
- E. Цоорхойг шаантаг хэлбэрээр өөлөн авч оёод тэнэмэл мэдрэлийг таслах

/459./ 12 хуруу гэдэсний шарх цоороход өвдөлт нь хүчтэй биш байдгийг аль хүчин зүйлээр тайлбарлах вэ?

- A. Цооролтын хэмжээ нь бага байдаг
  - B. Ходоодтой харьцуулахад 12 хуруу гэдэсний агуулагдахуун нь үзүүлэх хөнөөлөөрөө бага
  - C. 12 хуруу гэдсэнд агуулагдах зүйл нь бага
  - D. Цооролт нь далд хэлбэрээр тохиолдох нь олон
  - E. Цоорсон нүхээр гэдэсний агуулагдахуун бага гарна
- /460./ 12 хуруу гэдэсний шархлаа зонхилон цоорох байрлал нь аль вэ?
- A. Урд хана
  - B. Урд-дээд хана
  - C. Арын хана
  - D. Арын доод хана
  - E. Арын дээд хана
- /461./ Ходоод, 12 хуруу гэдсэнд шархлаа нь ихэвчлэн хаана байрладаг вэ?
- A. 12 хуруу гэдэсний эхний хэсэгт
  - B. Ходоодны орох хэсэгт
  - C. Ходоодны гарах хэсэгт
  - D. Ходоодны их махианы хэсэгт
  - E. Ходоодны бага махианы хэсэгт
- /462./ Нарийн гэдсэнд хаван үүсэх, лимфийн фолликулууд нь хөөх, гэдэсний хананд буглаа үүсэх өвчнийг заана уу?
- A. Уинлийн өвчин
  - B. Сүрьеэ
  - C. Амебиаз
  - D. ДОХ
  - E. Кроны өвчин
- /463./ Гэдэсний хавчуулагдсан гогцоо үхжсэн болох магадлал ихтэй шинж тэмдэгийг сонгоно уу?
- A. Хавчигдсан гогцоо, түүний сероз бүрхүүл нь бараан өнгөтэй
  - B. Хавчигдсан гогцоо гүрвэлзэх хөдөлгөөнгүй болох
  - C. Хавчигдсан гогцооны чацархайн судас ажиллагаагүй болох
  - D. Ивэрхий уутан доторх ус нь булингартах
  - E. Гэдэсний орох гогцоо нь ихээр тэлэгдсэн байна
- /464./ Бүрэн хавчигдсан гэдэсний орох гогцоог тайрах зохистой уртын хэмжээг заана уу?
- A. Урт нь 45-50 см
  - B. Урт нь 35-40 см
  - C. Дарагдсан ховилын хэмжээнд
  - D. Урт нь 15-20 см
  - E. Урт нь 10 см хүртэлх
- /465./ Хэвлийн гэдэс хоорондын наалдаст өвчнийг оношлох шинжилгээний үндсэн арга нь аль вэ?
- A. Хэвлийг гэрэлд тойм харах
  - B. Гэдэс ходоодны замаар пассаж үзэх
  - C. Эзофагогастродуоденоскопи
  - D. Прозерины сорил хийх
  - E. Хэвлий дурандах / лапароскопи /
- /466./ Наалдац нь ямар эдээр үүсдэг вэ?
- A. Сийрэг холбогч эдээр үүссэн
  - B. Булчинлаг эдээр үүссэн
  - C. Судасны холбогч эдээр үүссэн
  - D. Судасгүй холбогч эдээр үүссэн
  - E. Холбогч эдгүй үүссэн
- /467./ Наалдаст түгжрэлийн эхэн үед ямар шинж илрэхгүй вэ?
- A. Хэвлийгээр байнга өвдөх
  - B. Хэвлийгээр базалж өвдөх
  - C. Бөөлжих
  - D. Гэдэс дүүрэх
  - E. Хий, өтгөн гарахгүй болох

- /468./ Дарагдсан хэлбэрийн гэдэсний түгжрэл аль нь вэ?  
А. Узлообразование /зангирах/  
В. Гэдэс нь наалдаж түгжрэх  
С. Гэдэсний саажилт  
D. Гэдэс агших  
E. Гэдэсний хөндий хавдраар бөглөрөх
- /469./ Хэвлийн гялтангийн цочмог үрэвслийн хожуу шатанд аль шинж нь илрэх вэ?  
А. Гэдэс дүүрэх  
В. Хэвлий тэлэгдэх  
С. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн ихсэх  
D. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн арилах  
E. Олон удаа бөөлжих
- /470./ Гэдэсний цочмог түгжрэлийн төгс оношлох арга нь аль вэ?  
А. Хэвлийн тойм харалт  
В. Бүдүүн гэдсийг дурандах  
С. Тодотгогч бодисын тусламжтай гэдэсний хөндий замуудыг тодорхойлох  
D. Ходоод,нарийн гэдэсний дээд хэсгийг дурандах  
E. Хэвлийг нээж шалгах
- /471./ Аль нь гэдэсний түгжрэлийг үүсгэх вэ?  
А. Хэвлийн хөндийн наалдац  
В. Гэдэс чихэлдэх  
С. Цэсний чулуу  
D. Хавдар  
E. Бүгд
- /472./ Дээр байрлалтай түгжрэлийг шинж нь:  
А. Тасралтгүй бөөлжих  
В. Бие усгүйжих  
С. Хэвлий эрс томорч хэнгэргэн чимээтэй болох  
D. Өвчин эхлэнгүүт хий ба өтгөн хаагдах  
E. Хэвлийд чөлөөт шингэн тодорхойлогдох
- /473./ Гэдэсний механик цочмог түгжрэлийн үеийн гол шинж нь аль нь вэ?  
А. Хүйсний орчмоор овойх  
В. Хэвлийд хүчтэй базалж өвдөх  
С. Өтгөн ба хий хагас хаагдах  
D. Бөөлжихгүй байх  
E. Биеийн халуун 37.5-38.5°C
- /474./ Наалдаст түгжрэлийн үед гэдэс хаймсуурдах хамгийн оновчтой аргыг тэмдэглэнэ үү?  
А. Ю.М.Дедерерийн гастромоор  
В. Н.Д.Житнюковоор илеостомоор  
С. С.М.Долецкоор шулуун гэдсээр  
D. Цекостомоор  
E. Хамраар, ходоод,12 хуруу нугалаа гэдсээр
- /475./ Хэвлийн урд хананд харьцуулсан хэмжилтүүд хийж цочмог түгжрэлийг оношлох арга нь хэнийх вэ?  
А. Обуховский  
В. Кивуля  
С. Баасанжав  
D. Валя  
E. Ичинхорлоо
- /476./ Ходоодонд тодруулагч бодис ямар хугацаагаар саатвал түгжрэл гэж үзэж болох вэ?  
А. 1-2цаг  
В. 3-4 цаг  
С. 5-6 цаг  
D. 8-10 цаг  
E. 10 цагаас дээш
- /477./ Бүдүүн гэдэснээс цус хамгийн их алддаг шалтгаан нь аль вэ?

- A. Дивертикулит
  - B. Бүдүүн гэдэсний цусан хангамж багассан үрэвсэл
  - C. Дивертикулёз
  - D. Сиплодисплази
  - E. Бүдүүн гэдэсний хавдар
- /478./ Бүдүүн гэдэсний элбэг тохиолдох төрөлхийн гажиг нь:
- A. Гиршпрунгийн өвчин
  - B. Долихоколи
  - C. Долихсигма
  - D. Нарийсалт
  - E. Дистони
- /479./ Бүдүүн гэдэсний баруун хэсгийг цусаар хангах судас нь аль вэ?
- A. Дээд чацархайн тараагуур судас
  - B. Доод чацархайг тараагуур судас
  - C. Ташааны дотуур баруун тараагуур судас
  - D. Ташааны дотуур зүүн тараагуур судас
  - E. Гэдэсний гол судас
- /480./ Бүдүүн гэдэсний зүүн хэсгийг цусаар хангах чухал үүсвэрийг заана уу?
- A. Дээд чацархайн тараагуур судас
  - B. Гэдэсний гол судас
  - C. Дэлүүний тараагуур судас
  - D. Доод чацархайн тараагуур судас
  - E. Ташааны дотуур зүүн тараагуур судас
163-А, 164-Д, 165-А, 166-В, 167-В, 168-В, 169-С, 170-А, 171-А, 172-А, 173-В, 174-А,  
175-А, 176-В, 177-В, 178-Д, 179-А, 180-С, 181-С, 182-А, 183-Д, 184-Д, 185-В, 186-А,  
187-С, 188-А, 189-В, 190-А, 191-В, 192-В, 193-В, 194-С, 195-С, 196-А, 197-С, 198-А,  
199-С, 200-Д, 201-В, 202-В, 203-В, 204-В, 205-А, 206-В, 207-А, 208-С, 209-В, 210-С,  
211-А, 212-А, 213-В, 214-А, 215-Д, 216-Е, 217-В, 218-С, 219-В, 220-С, 221-А, 222-С,  
223-Д, 224-Д, 225-А, 226-В, 227-В, 228-В, 229-А, 230-В, 231-В, 232-А, 233-А, 234-А,  
235-Е, 236-А, 237-Е, 238-А, 239-Е, 240-А, 241-Д, 242-А, 243-В, 244-А, 245-С, 246-А,  
247-Е, 248-С, 249-С, 250-А, 251-С, 252-А, 253-А, 254-А, 255-А, 256-С, 257-Е, 258-А,  
259-С, 260-С, 261-С, 262-С, 263-А, 264-А, 265-А, 266-А, 267-А, 268-А, 269-С, 270-С,  
271-А, 272-А, 273-А, 274-А, 275-А, 276-А, 277-А, 278-А, 279-Е, 280-С, 281-А, 282-Е,  
283-С, 284-А, 285-С, 286-А, 287-С, 288-Е, 289-А, 290-Е, 291-А, 292-А, 293-С, 294-С,  
295-А, 296-С, 297-А, 298-А, 299-Е, 300-А, 301-А, 302-А, 303-С, 304-А, 305-А, 306-С,  
307-С, 308-С, 309-Е, 310-С, 311-С, 312-А, 313-С, 314-С, 315-А, 316-А, 317-А, 318-А,  
319-С, 320-Д, 321-А, 322-Д, 323-Д, 324-В, 325-С, 326-А, 327-С, 328-С, 329-Д, 330-Е,  
331-Е, 332-Е, 333-А, 334-С, 335-С, 336-Д, 337-Д, 338-С, 339-С, 340-С, 341-Д, 342-Д,  
343-Е, 344-А, 345-В, 346-Е, 347-С, 348-С, 349-С, 350-В, 351-В, 352-С, 353-Е, 354-С,  
355-В, 356-Е, 357-А, 358-С, 359-Д, 360-Д, 361-Е, 362-Е, 363-В, 364-А, 365-Д, 366-В,  
367-С, 368-В, 369-С, 370-А, 371-Е, 372-С, 373-А, 374-С, 375-С, 376-А, 377-В, 378-Е,  
379-А, 380-В, 381-Д, 382-Е, 383-А, 384-Е, 385-С, 386-Е, 387-Д, 388-С, 389-Д, 390-С,  
391-А, 392-С, 393-Е, 394-А, 395-А, 396-В, 397-Е, 398-В, 399-В, 400-Е, 401-Д, 402-Д,  
403-Е, 404-В, 405-В, 406-В, 407-Д, 408-В, 409-А, 410-Д, 411-С, 412-С, 413-Д, 414-В,  
415-А, 416-Д, 417-С, 418-Д, 419-А, 420-А, 421-Д, 422-Д, 423-Д, 424-Д, 425-Д, 426-А,

427-B, 428-C, 429-E, 430-B, 431-C, 432-D, 433-B, 434-E, 435-C, 436-B, 437-D, 438-B,  
439-D, 440-D, 441-D, 442-E, 443-E, 444-C, 445-C, 446-E, 447-B, 448-D, 449-D, 450-B,  
451-A, 452-A, 453-D, 454-E, 455-B, 456-B, 457-D, 458-B, 459-B, 460-E, 461-E, 462-B,  
463-C, 464-E, 465-C, 466-E, 467-D, 468-E, 469-B, 470-D, 471-D, 472-B, 473-A, 474-B,  
475-C, 476-C, 477-C, 478-B, 479-D, 480-B, 481-A, 482-C, 483-D, 484-A, 485-D, 486-C,  
487-D, 488-C, 489-D, 490-D, 491-D, 492-D, 493-B, 494-D, 495-C, 496-D, 497-E, 498-B,  
499-C, 500-D, 501-C, 502-E, 503-E, 504-C, 505-C, 506-A, 507-A, 508-C, 509-C, 510-E,  
511-C, 512-A, 513-A, 514-A, 515-A, 516-E, 517-A, 518-A, 519-E, 520-A, 521-B, 522-D,  
523-C, 524-B, 525-C, 526-D, 527-A, 528-A, 529-E, 530-A, 531-E, 532-E, 533-E, 534-A,  
535-E, 536-C, 537-D, 538-D, 539-A, 540-E, 541-E, 542-A, 543-D, 544-E, 545-E, 546-A,  
547-E, 548-E, 549-E, 550-A, 551-E, 552-A, 553-A, 554-E, 555-E, 556-A, 557-E, 558-E,  
559-E, 560-A, 561-A, 562-E, 563-A, 564-A, 565-C, 566-C, 567-D, 568-A, 569-A, 570-E,  
571-E, 572-A, 573-E, 574-E, 575-E, 576-E, 577-C, 578-E, 579-E, 580-E, 581-E, 582-A,  
583-E, 584-D, 585-E, 586-A, 587-A, 588-A, 589-E, 590-E, 591-A, 592-E, 593-A, 594-D,  
595-D, 596-E, 597-E, 598-E, 599-E, 600-E, 601-E, 602-E, 603-E, 604-A, 605-A, 606-A,  
607-A, 608-A, 609-E, 610-A, 611-E, 612-A, 613-E, 614-A, 615-E, 616-A, 617-A, 618-A,  
619-E, 620-E, 621-E, 622-A, 623-E, 624-E, 625-E, 626-E, 627-E, 628-E, 629-E, 630-A,  
631-A, 632-A, 633-A, 634-A, 635-E, 636-E, 637-E, 638-E, 639-E, 640-E, 641-A, 642-E,  
643-A, 644-E, 645-E, 646-E, 647-E, 648-E, 649-E, 650-C, 651-A, 652-C, 653-E, 654-E,  
655-A, 656-A, 657-C, 658-E, 659-E, 660-E, 661-E, 662-A, 663-E, 664-E, 665-A, 666-E,  
667-E, 668-E, 669-E, 670-A, 671-C, 672-D, 673-D, 674-A, 675-A, 676-D, 677-D, 678-E,  
679-D, 680-C, 681-D, 682-E, 683-A, 684-C, 685-B, 686-C, 687-A, 688-B, 689-D, 690-B,  
691-E, 692-A

### Сорил хариулах заавар

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
  - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (А.)
  - Зөв, Зөв, Буруу (В.)
  - Зөв, Буруу, Буруу (С.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (E.)

### Сонгогдсон сорил

/1./ Шарханд мэс заслын анхдагч цэгцлэгээ хийхэд гол хийх үйлдэл юу вэ?

- A. Шархыг ариутгах
- B. Цус, цусны үлдэгдэл, гадны биетийг авах
- C. Амьдрах чадваргүй бүх эдийг зүсч авах
- D. Арьсны зах ойролцоох эдийг тэнцүүхэн боломжоор авах
- E. Цусны нөжийг авч, дахин цус алдахаас урьдчилан сэргийлж цус алдаж буй судасыг боох

/2./ Нүүрний хүнд гэмтлийн үед цус тогтоолтыг зогсоох зорилгоор аль артерийн судсыг боох вэ?

- A. Гүрээний гадна артери
- B. Гүрээний дотор артери
- C. Атагал чөмөгний толгойн хэсэгт
- D. Гүрээний ерөнхий артери

Е. Чамархайн артери, түүний салаанууд

/3./ Чангалуур боолт тавих хугацаа

- А. Зун 2 цаг, өвөл 1 цаг
- В. Зун 1 цаг, өвөлд 2 цаг
- С. Өвөл зунд адилхан 2 цаг
- Д. Зун 1,5 цаг өвөл 30 мин
- Е. Жилийн аль ч улиралд 30 мин

/4./ Анхдагч-хойшлогдсон оёдлын хугацааг заана уу?

- А. Гэмтсэнээс хойш 1 долоо хоногийн дараа шарханд цэгцэлгээ хийж оёдол тавих
- В. Гэмтсэнээс хойш нэг сарын турш шархыг цэвэрлэж дараа нь оёдол тавих
- С. Шарханд урьдчилан цэгцэлгээ хийгээд мөхлөг үүсэхийн өмнө 5-6 хоногийн дараа оёдол тавих
- Д. Шарханд мөхлөг /грануляция/ үүсгээд зах, ирмэг нь хөдөлгөөнтэй, бэхжээгүй үед сорвигүй нөхцөлд оёдол тавих
- Е. Мөхлөг зах, ирмэг бэхжиж сорвижсон үед өөлж аваад оёдол тавина

/5./ Үений ил гэмтлийн итгэлтэй шинж тэмдгийг нэрлэнэ үү?

- А. Үений түвшинд гүнзгий шархдах
- В. Шархнаас үений шингэн гарах
- С. Тэмтрэхэд үений шархны хэсэгт шаржигнах чимээтэй
- Д. Үений хэсгийн шархнаас цус урсаж гарна
- Е. Шархтай үений хөдөлгөөн эрс хязгаарлагдах

/6./ Том үений ил гэмтлийн аюултай хүндрэл

- А. Үений идээт үрэвсэл
- В. Хийн эмболи
- С. Цусан халдвар
- Д. Үе хөдөлгөөнгүй болох /анкилоза/
- Е. Нугалах, тэнийх байрлалд үений хөдөлгөөний хомсдол болох

/7./ Тархины хөнгөн зэргийн бяцралын үед компьютер томограммд гарах өөрчлөлтийг заана уу?

- А. Гавлын дотор уйланхай үүсэх
- В. Өөрчлөлт илрэхгүй
- С. Гавлын дотор цус хурах
- Д. Тархины хаваншилт
- Е. Гавлын ясны хугарал

/8./ Тархины дунд зэргийн няцралын үед ухаан алдалтын хугацааг заана уу?

- А. Ухаан алдалт 0-5 минут үргэлжилнэ
- В. Ухаан алдалт 1 цаг хүртэл үргэлжилнэ
- С. Хэдэн секунд үргэлжилнэ
- Д. Ухаан алдалт 45 мин үргэлжилнэ
- Е. Ухаан алдалт 25-30 мин үргэлжилнэ

/9./ Хатуу хальсны дээрхи цусан хураа гэж юу вэ?

- А. Гавлын ясны цөмөрсөн хугарал, тархины бяцралын голомт хатуу бүрхэвчийн доорхи шингэн хуралт нөхцөлдөн үүсдэг
- В. Тархины хатуу бүрхэвчийн дунд артерийн гэмтэл, гавлын ясны венийн судасны гэмтэлээс үүдэн гавлын ясны дотор хана хатуу бүрхэвч хоёрын завсарт цус хурахын хэлнэ.
- С. Тархины бүрхэвчийн венийн судас, вений синус гэмтсэнтэй холбоотойгоор хатуу ба зөөлөн бүрхэвч тархины эдийн завсар цус хурахыг хэлнэ.
- Д. Механик болон гадны хүчин зүйлийн нөлөөгөөр тархины бүтцийн голомтод болон голомтод бус өөрчлөлт гарахыг хэлнэ.
- Е. Гэмтлийн улмаас үүссэн уураг тархины тусгалын ба амьсгал зүрх судасны төвийн үйл ажиллагааны түр зуурын саатлын шинжүүд илрэхийг хэлнэ

/10./ Гавал тархины хүнд гэмтэлтэй өвчтөн өндөр халуурах нь аль шалтгаантай холбоотой вэ?

- А. Архаг идээт үрэвсэл хурцдах
- В. Төвийн гаралтай
- С. Гавлын доторхи гэмтэл, идээт үрэвсэлтэй хавсрах



- D. Организмын хариу урвал  
E. Эмийн бодисын хариу урвал
- /11./ Шууны доод гуравны нэг хэсэгт дундын мэдрэл хаана байрлах вэ?  
A. Хуруунуудын өнгөц ба гүн нугалагч булчингуудын завсар  
B. Алагны урт булчин болон сарвууны шууны нугалагч булчингийн хооронд  
C. Хуруунуудын гүнзгий нугалагч булчин болон эрхий хурууны нугалагч булчин хооронд  
D. Гүн нугалагч булчингийн завсар  
E. Хуруунуудын өнгөц нугалагч булчин болон богтны нугалагч булчин хооронд
- /12./ Мөрний мултралын үед илрэх шинж тэмдгийг дурьдана уу.  
A. Эмгэг хөдөлгөөн  
B. Пүрштэй юм шиг эсэргүүцэлтэй  
C. Ясны хавиралдах чимээ мэдрэгдэнэ  
D. Булчин хатингаршина.  
E. Ясны хугарлын үзүүр ил гарна
- /13./ Атгаал ясны чөмөгт гандан хэсгийн хугарлын гол эмчилгээ аль нь вэ?  
A. Шахаж сунгах аппарат  
B. Ясны чөмөгний голоор хадах мэс засал  
C. Хугарлыг эвлүүлж гаднаас нь металл ялтасаар бэхлэх  
D. Бариа засал, гөлтгөнөн боолт  
E. Эвийн эмчилгээ
- /14./ Эгэмний яс голдуу аль тевшиндөө хугардаг вэ?  
A. Дунд 1/3-ээр  
B. Гадна 1/3-ээр  
C. Дотор 1/3-ээр  
D. Гадна дунд 1/3-ын уулзвараар  
E. Дунд дотор 1/3-ын уулзвараар
- /15./ Төрөх үед хүүхдийн эгэм хугарахад ямар шинж илрэх вэ?  
A. Мөрний үенд цус хурна  
B. Хугархайд шаржигнах чимээ гарна  
C. Цусан хангамжийн өөрчлөлт  
D. Мөчинд саа  
E. Өлгийдөхөд өвдөлт мэдэрч шалтгаангүйгээр уйлна
- /16./ Густило-Андерсоны ангилал II-т тохируулан хэрэглэх эмчилгээний арга барил аль нь зөв бэ?  
A. Битүү хугарлын эмчилгээ.  
B. Шархыг өргөсгөж угааж цэвэрлэж гуурс тавина  
C. Булчин хэсгийн тэжээлтэй шилжүүлнэ.  
D. Цусан хангамжийг сэргээх хэрэгтэй  
E. Аль ч үйлдлийг хийж болно
- /17./ Настангуудийн түлэгдлийн онцлог юу вэ?  
1. Зүрхний инфаркт хүчтэй өвдөлт өгнө.  
2. Суурь өвчин нь хүндрэнэ  
3. Өндөр халуурна  
4. Уушгины хатгалгаа, үжлээр илүү хүндрэнэ  
5. Судасны бөгрөрөл ховор тохиолддог
- /18./ Гүйдлийн утас нь газардсан, гүйдэлд цохиулсан хүнд, хамгаалалтын гуталгүйгээр яаж дөхөж очих вэ?  
A. Гүйж очно  
B. Түргэн алхана  
C. Гутлаа газраас салгахгүй явж очно  
D. Харайж хүрнэ  
E. Дээрхи бүгд
- /19./ Битүү гөлтгөнөн боолтыг тавьсны дараа ямар хүндрэл илүүтэй вэ?  
A. Холголт үүсгэнэ  
B. Арьсны идэвхигүй бичил биет үхэж, цаашид мөөгөнцөрөөр солигдоно  
C. Мөч тэжээгч гол судсыг дарж цусгүйжилт үүсэх

D. Мэдрэлийн судлыг дарж неврит үүсгэнэ

E. Байнгын өвдөлт өгнө

/20./ Бүсэлхий мэдрэлийн сүлжээ ямар мэдрэлээс хэлбэржих вэ?

A. Th12-L4

B. Th12-L5

C. L1-L4

D. L1-L5

E. Th9-10

/21./ Тохойн үе хэдэн үелэмжээс бүтэх вэ?

A. Хоёр үелэмж

B. Гурван үелэмж

C. Дөрвөн үелэмж

D. Таван үелэмж

E. Нэг үелэмж

/22./ Цахилгаан гүйдлийн хэсгийн шинж тэмдэг

A. Арьсанд модлог хэлбэрийн салаалалсан улаан судал арьсанд илэрнэ, дарахад алга болно

B. Дээрхи шинж тэмдэг дарахад алга болохгүй

C. Гүйдлийн тэмдэг үүснэ

D. Эд хатуурч /металлизация болно/

E. Цахилгаан гүйдлийн үйлчлэсэн хэсэгт нүүрсжилт болно

/23./ Майга тавхайд хэдэн сартайгаас эвийн эмчилгээ хийж эхлэх вэ?

A. Төрснөөс

B. 1 сарын дараа /төрснөөс/

C. 3 сарын дараа /төрснөөс/

D. Хагас жилийн дараа /төрснөөс/

E. 1 нас

/24./ Майга тавхайд хэдэн настайгаас мэс заслын эмчилгээ эхлэх вэ?

A. 6 сар

B. 12 сар

C. 1 нас

D. 5 нас

E. 7-10 нас

/25./ Түнхний үений гаж хөгжил /дисплазия/ хэдийгээс эмчлэх вэ?

A. Төрснөөс эхлэн

B. 1 сар

C. 1-2 сар

D. 3 сар түүнээс дээш

E. 6 сартайга

/26./ Ердийн рентген судалгаанд нурууны ясны хугарлын үед зайлшгүй тохиолдох шинж тэмдэг юу вэ?

1. Нурууны тэнхлэг өөрчлөгдөнө. Хэвийн лордоз, кифоз алга болох

2. Нурууны бие хэсгийн ялтаслаг хатуу хэсэг өөрчлөлтөнд орох

3. Нуруу хоорондын диска ямар нэг хэмжээгээр зөрүү өгөх

4. Нурууны нугалам хэсгийн өндөр багасдаг

5. Нурууны бие зөөлөн эдэд цус хуралт хий болох

/27./ Амьтанд хазагдсан шархыг галзуугаас урьдчилан сэргийлэхийн тулд

1. Шархны зах ирмэгийг өнгөн цэгцэлгээ хийгээд оёдол тавина

2. Антирабический вакцин хийнэ

3. Шарханд цэгцэлгээ хийгээд урсгуур тавина

4. Шархыг савантай ус болон устөрөгчийн хэт исэл /H<sub>2</sub>O<sub>2</sub>/-ын 3%-ын уусмалаар сайтар

угааж цэвэрлэнэ

5. Өндөр тунгаар антибиотик хийнэ

/28./ Агааргүйтэн халдварын шинж тэмдгийг нэрлэнэ үү.

1. Шархны ирмэг дээр дарахад хөөс гарна

2. Өвөрмөц шинж криптация гарна

3. Өвчтөн хордлого ихтэй хүнд
  4. Яаралтай эмчлэх шаардлагагүй
  5. Мэс засал хийхгүй
- /29./ Эрэгтэй хүний шээсний сүв тасрахад ямар шинж илрэх вэ?
1. Шээс хаагдах
  2. Давсаг тэмтрэгдэх боловч шээс гарахгүй цус гарна
  3. Шээсний сүвээр цус гарна
  4. Давсаг тэмтрэгдэхгүй, шээс гарахгүй
  5. Гематурия
- /30./ Ясны татлага хийх цэгүүдийг нэрлэнэ үү?
1. Дунд чөмөгний доод булууны товгорын дээд талаас
  2. Дунд чөмөгний их эргүүлгээс
  3. Шаант чөмөгний урд бурзангаас
  4. Өсгий яснаас
  5. Залаа яснаас
- /31./ Ясны битүү хугарлын шинж тэмдгийг нэрлэ
1. Арьсан дор хий хурах
  2. Эмгэг хөдөлгөөн
  3. Хэсэг газарт улайлт үүсэх
  4. Хэлбэр дүрсээ алдах
  5. Ойролцоох үенд пүрштэй мэт эсэргүүцэлтэй
- /32./ Ваго-симпатик хоригийг аль түвшинд хатгаж хийх вэ?
1. m.Sterno-Cleido-mastoideus булчингийн дээд/3, дунд/3 заагт
  2. m.Sternocloido-mastoideus булчингийн ар зах, гүрээний гадна венийг огтлолцсон цэгт
  3. m.Sternocleido-mastoideus булчингийн ар захаар хэлэн доорхи ясны түвшинд
  4. Sternocleido-mastoideus булчингийн эгэмэнд бэхлэгдсэн хэсэг
  5. Дунд хэсэгт
- /33./ Ясны ил болон битүү хугарлын үндсэн хүндрэлүүд
1. зөв биш бороололт
  2. бороолоогүй
  3. хуурамч үе
  4. Гэмтлийн шалтгаант остеомиелит
  5. Бороололт удаашрах
- /34./ Үений бохирдсон ил хугарлыг эмчлэх зарчим
1. Өргөн хүрээний антибиотик хагалгааны дараа хэрэглэнэ
  2. Дотуур, гадуурх бэхэлгээг найдвартай хийнэ.
  3. Эмчилгээний 3 дахь хоногоос дархлаа сайжруулах эмчилгээ хийнэ
  4. Шархны анхдагч цэгцлэлтийг хагалгааны журмаар хийнэ
  5. Зөөлөн эдийн дутмагшилд тосон боолт хийнэ.
- /35./ Ясны хугарлын эвийн эмчилгээний аргыг нэрлэнэ үү.
1. Ясны татлага
  2. Бариа засал
  3. Гөлтгөнөн боолт
  4. Чөмөгний голоор бэхэлж хадах
  5. Шахах сунгах аппарат эмчилгээ
- /36./ Голомтоос зайдуу ясыг хадах нь бусад мэс заслын эмчилгээнээс давуу тал
1. Хөнөөл багатай
  2. Хугарлын найдвартай тогтвортой барина
  3. Хүнд өвчтөнг эрт идэвхитэй байрлалд оруулах
  4. Хийх арга нь бусад мэс заслын ажилбаруудтай хослон хийхэд хугацаа бага орно.
  5. Цус алдалт бага зэрэг болон цус алдалт гарахгүй
- /37./ Тархины доргилтын үед бага насны хүүхдэд илрэх шинж тэмдэгийг заана уу?
1. Ухаан алдах хөөрлийн шинж тэмдэг илрэх
  2. Царай цонхийж хөхөх захилах үйлдэл хийж чадахгүй
  3. Хэдэн минутын турш ухаан алдах хүүхэн хараа нарийсах
  4. Суулгах огиулж бөөлжих

5. Таталт өгөх, бөөлжих

/38./ Тархины дунд зэргийн бяцралын эмнэл зүйн шинжүүдийг дурьдана уу?

1. Ухаан сэргэх явцад толгой өвдөх, эргэх дотор муухайрах, олон дахин бөөлжих
2. Сэтгэц хөдөлгөөний хөөрлийн шинж ажиглагдана
3. Гэмтлийн дараах 3-5 хоногт гэмтэлд өртөх үеийн үйл явцыг санах ой алдагдана
4. Амьсгалын хэм түргэсэх, судасны цохилт удаашрах буюу хурдасч артерийн даралт ихсэнэ

5. Ухаан алдалт 1 цаг түүнээс дээш хугацаагаар үргэлжлэх

/39./ Гавал тархины хүнд хэлбэрийн гэмтлийн үед онош тодруулах ямар ямар шинжилгээг яаралтай хийх вэ?

1. Нугасны ус авах шинжилгээ
2. Компьютерт томографи
3. Хүзүүний нурууны рентген зураг
4. Гавлын ясны рентген зураг хоёр чиглэлээр авах
5. Хэт авианы М-Эхо

/40./ Тархины хөнгөн бэртлийн үед илрэх шинж

1. ЭЭГ-ийн шинжилгээнд М долгионы хазайлт илрэх
2. Голомт шинж үл илрэх
3. Нугасны ус шингэн цустай гарах
4. Тархины ерөнхий шинж
5. Мэдрэлийн голомтот шинж илрэх

/41./ Нугас дарагдсан гол шинжүүд юу вэ?

1. Хөлөө өргөж чадахгүй байх
2. Тодорхой түвшингээс доош мэдээгүйжих
3. Нуруугаар хүчтэй өвдөж хэлбэр дүрс алдагдах
4. Аарцгийн эрхтэнүүдийн үйл ажиллагаа алдагдах
5. Хоёр хөл рүү хүчтэй өвдөх

/42./ Цээжний зөөлөн эд няцарсан үед илрэх шинж тэмдгийг дурьдана уу.

1. Амьсгал суларна
2. Өвдөлт
3. Ясны хавиралдах чимээ мэдрэгдэнэ
4. Арьсан доор цус хурна
5. Арьсан доор хий хуралдана

/43./ Элэгний гэмтлийг ямар хэлбэрт хувааж болох вэ?

1. Элэгний бүрхүүлийн доогуур цус хурах
2. Элэгний эдэд цус хурах
3. Олон хэсэгт язарч урагдах
4. Няцарч тасрах
5. Цөсний хүүдий, цорго гэмтэх

/44./ Бөөрний гэмтлийг яаж ангилдаг вэ?

1. Бөөрний эд бэртэж, няцрах
2. Урагдаж, хагарах
3. Урагдаж, цус хурах
4. Шээсний хураагуур хагарах
5. Судасны багц гэмтэх

/45./ Давсаг урагдах үндсэн шалтгаан юу вэ?

1. хэвлийн доод хэсэгт гэмтэл авах
2. давсаг шээсээр дүүрэн хэвлийд цохилт авах
3. аарцагаар хавчуулах үед
4. аарцаг ясны урд хэлхээсийн хугарал
5. давсганд резинэн катетр тавих

/46./ Гавлын доторхи цусан бүлэн хуралтыг яаж ангилах вэ?

1. Хавсарсан хэлбэр
2. Хатуу хальсны гаднах
3. Ховдлын доторх
4. Хатуу хальсны доорх

5. Тархины эдийн дотор
- /47./ Шуу ясны хугарамтгай хэсгийн хугарлын үед ямар хэлбэрийн хугарал үүсэх вэ?
1. Монтеджийн хугарал
  2. Коллесийн хугарал
  3. Мальгены хугарал
  4. Смитийн хугарал
  5. Галлецын хугарал
- /48./ Мөрний мултралыг ямар аргаар оруулах вэ?
1. Кохерын арга
  2. Джанелидзегийн арга
  3. Гиппократын арга
  4. Илизаровын арга
  5. Монгол арга
- /49./ 1 нас хүртэлх хүүхдэд эгэм дунд  $1/3$  түвшинд хугарсан бол ямар бэхэлгээ боолт тохиромжтой вэ?
1. Суга өргөсөн цээжтэй боолт /торакобрахиаль/
  2. 8-ын тоо хэлбэрийн боолт
  3. Кузьмин чиг гөлтгөнөн боолт
  4. Дезо боолт
  5. Бэхэлгээ боолт хэрэггүй
- /50./ Мөрний мултрал олонтой тохиолдох шалтгаан
1. Мөрний үеэр олон хавтгайд хөдөлгөөн хийдэг
  2. Далны тогоо жижиг атгаалын толгой том
  3. Булчин холбоосны хөгжил муу
  4. Далны тогоо атгаалын толгой тохироо муутай
  5. Үений шингэнтэй
- /51./ Хүүхдэд атгаал чөмөгний эхлэх /дээд/ хэсгийн хугарал аль нь илүү тохиолдох вэ?
1. Гүүвгэрүүдийн дээгүүр
  2. Мэс заслын хүзүүгээр
  3. Түвгэрүүдийн доогуур
  4. Түвгэрүүд дайрсан
  5. Остеоэпифизолиз/Өсөлтийн бүс дайрсан хугарал/
- /52./ Түлэгдлийн зэргийг зөв тогтооно уу
1. I-р зэрэг өвдөлт ихтэй
  2. IIIA цэврүүний ёроол ягаан
  3. IIIB цэврүүний ёроол цайвар
  4. II Цэврүү нь том, шар үс өвдөлтгүй авагдана.
  5. IV Өвдөлт ихтэй.
- /53./ Түлэнхийн өвчний хурц хордлогын гол шинжүүд юу вэ?
1. Өвчтөн гэнэт халуурна
  2. Цусанд антиген их хуралдана
  3. Биеэс уургийн алдагдал ихэснэ
  4. Бичил цусан хангамжийн алдагдал ихэснэ
  5. Цусанд натри их кали бага байна
- /54./ Бага насны хүүхдийн түлэгдэлийн онцлог юу вэ?
1. Ацидоз гипокси бага илэрнэ
  2. Нейротоксикоз илүүтэй
  3. Цусны даралт илүү буурдаг
  4. Арьс нь нимгэн тул гүн түлэгддэг
  5. Бөөрний хүндрэл багатай
- /55./ Амьсгалын замын түлэгдлийн онцлог шинж юу вэ?
1. Зонхилон амьсгалын замын доод хэсэг түлэгддэг
  2. Бронхийн цэр ялгаруулалт идэвхижинэ
  3. Эхний 7 хоногт хатгалга тусна
  4. Амьсгалын зам хавагнаж нарийсна.
  5. Амьсгалын дээд зам ховор түлэгддэг

/56./ Хэт авиан шинжилгээний давуу тал нь юу вэ?

1. Шинжилгээний арга нь энгийн
2. Нэгэн зэрэг хэд хэдэн бүтцийг харьцуулан үзэх боломжтой
3. Өвчтөнийг олон дахин харахад аюулгүй
4. Шинжилгээ явуулж байгаа эмчид олон дахин хийхэд аюулгүй
5. Хямд үнэтэй

/57./ Түлэнхийн шархыг боолтоор эмчлэх давуу талуудыг заа

1. Гадны халдвар орохоос хамгаална
2. Эрдэс шингэний алдагдал багасна
3. Эмийн бодисын үйлчилгээ сайн
4. Асарч сувилахад хүндрэлтэй
5. Боолтын материал хэрэглэнэ

/58./ Ясны эдэд хамгийн баялаг байдаг коллагенгүй уураг

1. Ясны удамзүйн уураг /ВМП-2/
2. Остеоантин
3. Вета-өсөлтийн хүчийн зүйлийн үүсвэр
4. Остеокальци
5. Остеонектин

/59./ Гавал тархины хүнд гэмтлийн дараа хожуу үүсэх хүндрэлийг нэрлэ.

1. Өгзөг өсгийг холголт үүсэх
2. Эпилепсийн уналт
3. Шархны идээт үрэвсэл
4. Церебральный арахноидит
5. Менингит

/60./ Тохойн үений үйл ажиллагааны онцлогийг нэрлэнэ үү.

1. Залаа яс ба атгаал чөмөгний булууны төвгөрүүдийн хоорондын холбоос тохойг нугалсан байдалд нэг түвшинд очно

2. Алга тосох, хөмрөх хөдөлгөөн нь олон үеийг хөдөлгөөнд оруулдаг
3. Тохойн үений хөдөлгөөн нь зөвхөн нугалах, тэнийлгэх
4. Алга тосох, хөмрөх хөдөлгөөн нь тохойг нугалсан тохиолдолд хэрэгжинэ
5. Үенд цус, шингэн хурсныг тохойн эгц авсан зурагнаас л мэднэ

/61./ Түнхний эмгэг мултралын рентген шинж тэмдэгүүд

1. Сүүжний тогоо болон дунд чөмөгний толгой бүтцийн өөрчлөлт
2. Үе үүсгэгч яснуудын харилцаа өөрчлөгдөнө
3. Үе үүсгэгч ясны бүтэц өөрчлөгдөнө
4. Үе үүсгэгч яснууд бүтэц, харилцаа өөрчлөгдөнө
5. Чөмөгний толгой хайлах

/62./ Нэг нас хүрснээс хойш хүүхдийн түнхний төрөлхийн мултралд эмнэл зүйн ямар шинж тэмдэг илрэх вэ?

1. Мөч богиносоно
2. Трендленбургийн шинж
3. Их эргүүлэг Roser Nelatoni шугамаас дээш тодорхойлогдоно
4. Доголж явна
5. 2 талын түнхний мултралд сажилж явна

/63./ Цэрний өсгөвөрлөх шинжилгээ нь мэдрэг ба өвөрмөц чанарын хувьд ямар вэ?

- A. Мэдрэг чанар ба өвөрмөц чанар өндөртэй
- B. Мэдрэг чанар сул ч өвөрмөц чанар өндөртэй
- C. Мэдрэг ба өвөрмөц чанар султай
- D. Мэдрэг чанар болон өвөрмөц чанар сул
- E. Мэдрэгчанар дунд ба өвөрмөц чанар султай

/64./ Рифампицины гол гаж нөлөөг нэрлэнэ үү?

- A. Элэгний үрэвсэл
- B. Анемия
- C. Захын мэдрэлийн үрэвсэл
- D. Харааны мэдрэлийн үрэвсэл
- E. Үе өвдөх

/65./ Хүүхдийг сүрьеэгээс сэргийлэх өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн аргуудыг нэрлэнэ үү?

1. Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ
2. БЦЖ вакцинжуулалт
3. Дархлал дэмжих эмчилгээ
4. Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ
5. Урьдчилан сэргийлэх үзлэг

/66./ БЦЖ вакцин нь хүүхдийг ямар хэлбэрийн сүрьеэгээр өвчлөхөөс найдвартай хамгаалах вэ ?

1. Уушигны бус эрхтэний сүрьеэ
2. Хурц тархмал сүрьеэ
3. Уушигны сүрьеэ
4. Сүрьеэгийн менингит
5. Анхдагч сүрьеэ

/67./ БЦЖ вакцин хийх заалтыг нэрлэнэ үү?

1. Туберкулины сорилд эерэг хүүхэд
2. Бага насны хүүхдэд
3. Бүх насны хүүхдэд
4. Гүйцэд, эрүүл нярай хүүхдэд
5. Сүрьеэгээр өвчлөөгүй хүүхэд

/68./ Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээний заалтыг нэрлэнэ үү?

1. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал
2. Туберкулины сорил 10 мм-ээс дээш эерэг урвалтай
3. Бусад шинжилгээ болон эмнэл зүйд сүрьеэ үгүйсгэгдсэн
4. Туберкулины сорилд эерэг гарсан бүх тохиолдол
5. Гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн бага зэргийн өөрчлөлттэй

/69./ Мантугийн сорилын хариу урвалыг хэдэн цагийн дараа хэмжиж тодорхойлох вэ ?

1. 24 цаг
2. 72 цаг
3. 12 цаг
4. 48 цаг
5. 2 цаг

/70./ Туберкулины сорилыг ямар зорилгоор хийх вэ?

1. Нөхөн вакцинжуулалтанд хамрагдах хүүхдийг сонгох
2. Хүүхдэд сүрьеэгийн халдварыг эрт илрүүлэх
3. Сүрьеэгийн халдварын жилийн эгзэгийг тодорхойлох
4. Уушигны бус эрхтэний сүрьеэтэй тохиолдлыг оношлох
5. Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг хийх

/71./ Уушигны халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 настай хүүхдэд Мантугийн сорил тавьж, 72 цагийн дараа хариуг шалгахад 6 мм хэмжээтэй гүвдрүү жижиг цэврүүний хамт үүссэн бол энэ урвалыг юу гэж дүгнэх вэ? Цаашид авах арга хэмжээг тодорхойлоно уу?

1. Эерэг урвал
2. Эмнэл зүйн шинжүүд болон бодит үзлэгийн өөрчлөлтийг шалгана
3. Цээжний гэрлийн шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно
4. Цусны ерөнхий шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно.
5. Эмнэл зүй болон бусад шинжилгээнд сүрьеэгүй нь батлагдсан бол химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ.

/72./ БЦЖ вакцинаар үүсгэгдсэн дархлалтай хүүхдэд илрэх туберкулины сорилын хариу урвалын онцлогийг тоочно уу?

1. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр ихэснэ
2. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр буурна
3. Хэт эерэг урвалтай буюу 10 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү үүснэ
4. Эерэг урвалтай буюу 10 мм-ээс доош хэмжээтэй гүвдрүү үүснэ
5. Улайлт гүвдрүүнээс том хэмжээтэй байна

- /73./ Уушгины гэрлийн шинжилгээнд тархмал сүүдрийн хам шинж ямар өвчнүүдийн үед илэрч болох вэ?
1. Уушигны милиар сүрьеэ
  2. Хорт хавдарын метастаз
  3. Уушиг тоосжих өвчин
  4. Зогсонгишлын уушиг
  5. Уушгины жижиг голомтот хатгалгаа
- /74./ Уушгины гэрлийн шинжилгээнд уушигны ямар эмгэгийн үед цагираг сүүдрийн хам шинж илрэх вэ?
1. Гуурсан хоолойн гаралтай уулинхай
  2. Хавдарын задрал
  3. Хөндийт сүрьеэ
  4. Уушгины голомтот сүрьеэ
  5. Туберкулема
- /75./ Анхдагч сүрьеэгийн эмнэл зүйн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
1. Сүрьеэгийн хордлого
  2. Сүрьеэгийн бронхаденит буюу цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
  3. Сүрьеэгийн анхдагч бүрдэл
  4. Нэвчдэст сүрьеэ
  5. Хөндийт сүрьеэ
- /76./ Хүүхдийн сүрьеэгийн оношлогоонд хэрэглэх гол шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?
1. Цэрний шинжилгээ
  2. Гэрлийн шинжилгээ
  3. Томографийн шинжилгээ
  4. Туберкулины сорил
  5. Эдийн шинжилгээ
- /77./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн клиник-рентгены хэлбэрүүдийг нэрлэнэ үү?
1. Бага хэлбэр
  2. Нэвчдэст хэлбэр
  3. “Хавдар” төст хэлбэр
  4. Шинж тэмдэггүй хэлбэр
  5. Хүндрэлтэй хэлбэр
- /78./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн нэвчдэст хэлбэрийн үед эмнэл зүйд илрэх шинжүүдийг тоочно уу?
1. Хордлогын хам шинж
  2. Уушиг-гуурсан хоолой, гялтангийн хам шинж
  3. Захын тунгалгийн булчирхайн өөрчлөлт
  4. Хоол боловсруулах замын хямрал
  5. Толгойн хүчтэй өвдөлт
- /79./ Сүрьеэгийн бронхаденитыг ялган оношлох өвчнийг нэрлэнэ үү ?
1. Лимфийн хавдрууд (лимфогрануломатоз, лимфосаркома, лимфолейкоз)
  2. Төвийн гаралтай хорт хавдар
  3. Өвөрмөц бус лимфаденопати (корь, коклюш, вирусын халдварт өвчин г.м)
  4. Уушигны голомтот хатгалгаа
  5. Улаан хоолойн хавдар
- /80./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн хүндэрлийг тоочно уу?
1. Анхдагч хөндий
  2. Гуурсан хоолойн сүрьеэ
  3. Сорвит хөндийт сүрьеэ
  4. Ателектаз
  5. Нурууны ясны сүрьеэ
- /81./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн үед бодит үзлэгээр илрэх өөрчлөлтийг бичнэ үү?
1. Эгэмний дээд хэсэгт тогшилтын чимээ бүдгэрнэ
  2. Далны хооронд тогшилтын чимээ бүдгэрнэ



3. Эгэмний дээд хэсэгт жижиг нойтон хэржигнүүртэй
  4. Чагнахад онцын өөрчлөлтгүй
  5. Тогшилтоор өөрчлөлтгүй
- /82./ Уушгины хурц милиар сүрьеэгийн үед гэрлийн шинжилгээнд илрэх өөрчлөлтийг тодорхойлно уу?
1. Зөвхөн нэг талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд бус тархсан
  2. Хоёр талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд тархсан
  3. Жижиг болон дунд зэргийн хэмжээтэй голомтууд тодорхойлогдоно
  4. Олон тооны шар будаа шиг жижиг голомтууд тодорхойлогдоно
  5. Уушгинд “тамгалсан” хөндий үүссэн байна
- /83./ Уушгины хоёрдогч сүрьеэгийн ерөнхий шинжийг тоочно уу?
1. Голдуу насанд хүрэгсэд өвчилнө.
  2. Цусаар тархахгүй, голдуу уушгийг голомтлог байдлаар гэмтэнэ
  3. Задрах хандлагатай, эмчилгээ заавал шаардлагатай
  4. Тунгалгийг хамарч гэмтээнэ.
  5. Цусаар тархах хандлага өндөртэй
- /84./ Уушгины голомтот сүрьеэгийн төгсгөлүүдийг нэрлэнэ үү?
1. Бүрэн шимэгдэнэ
  2. Хатуурч шохойжсон голомт үүснэ
  3. Задарч хөндийт сүрьеэ үүснэ
  4. Уушгины бус эрхтэний сүрьеэ үүснэ
  5. Гуурсан хоолойн сүрьеэ үүснэ
- /85./ Уушгины голомтот сүрьеэгийн хүндрэлүүдийг нэрлэнэ үү ?
1. Плеврит
  2. Нэвчдэст сүрье
  3. Туберкулем
  4. Хөндийт сүрьеэ
  5. Сорвит голомтот сүрьеэ
- /86./ Уушгины бүтэц эвдрэлт сүрьеэгийн үндсэн шинжийг тоочно уу?
1. Гуурсан хоолойн тэлэлт
  2. Нянгийн ялгаруулалт
  3. Амьсгалын дутагдал
  4. Уушгины эдийн бүтэц эвдрэл
  5. Уушгины эдийн сорвижилт
- /87./ Эмэнд дасалтай сүрьеэ үүсэхээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйл бол:
1. Сүрьеэг эрт илрүүлж, оношлох
  2. Сүрьеэгийн эмчилгээг шууд хяналттай хийх
  3. Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг үр дүнтэй явуулах
  4. Эмийн гаж нөлөөг хянаж, сэргийлэх
  5. Сүрьеэгийн эмчилгээг ганцхан эмээр дагнаж хийхгүй, зөв хослуулах
- /88./ Сүрьеэгийн эмчилгээний зарчмыг сонгоно уу?
1. Эмчилгээг завсарлагаатай хийх
  2. Шууд хяналттай эмчлэх
  3. Нэг юмуу хоёр эмийг хосолж хэрэглэх
  4. Богино хугацаагаар эмчлэх
  5. Урт хугацааны эмчилгээний горимыг сонгох
- /89./ Сүрьеэгийн нянгийн эсрэг үйлчлэлтэй нэгдүгээр эгнээний эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү?
1. Изониазид
  2. Рифампицин
  3. Пиразинамид
  4. Этамбутол
  5. Стрептомицин
- /90./ Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг явуулах чиглэлүүдийг нэрлэнэ үү?
1. Шууд хяналттай эмчлэх
  2. Үр дүнгийн хяналт хийх

3. Гаж урвалын хяналт хийх
  4. Биеийн жингийн хяналт
  5. Цусны ерөнхий шинжилгээ хийх
- /91./ Уушгины сүрьеэгийн сэжигтэй шинжүүдийг тоочно уу?
1. 14 хоногоос дээш хугацаагаар ханиах
  2. Цэртэй, цустай ханиах
  3. Цээжээр өвдөх
  4. Халуурч, хөлрөх
  5. Турах
- /92./ Сүрьеэгийн сэжигтэй тохиолдолд зайлшгүй хийх оношлогооны шинжилгээг тоочно уу?
1. Цусны биохимийн шинжилгээ
  2. Цэрний түрхэцийн шинжилгээ
  3. Туберкулины сорил
  4. Уушгины рентгенограмм
  5. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ
- /93./ Хүүхдийн анхдагч сүрьеэгийн оношлогоонд өргөн хэрэглэх шинжилгээний аргуудыг тоочно уу?
1. Цусанд уургийн хэмжээг тодорхойлох
  2. Туберкулины сорил
  3. Цэрний түрхэцийн шинжилгээ
  4. Уушгины гэрлийн шинжилгээ
  5. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ
- /94./ Сүрьеэгийн хагас идэвхитэй илрүүлэлтэнд хамрагдах хүрээг тодорхойлно уу?
1. Сүрьеэтэй өвчтөний хавьтал
  2. Гэр оронгүй хүмүүс
  3. Хоригдол
  4. Оюутнууд
  5. Залуус
- /95./ Элгэнд хортой гаж урвал үүсгэх боломжтой сүрьеэгийн эмийн бэлдэмлүүдийг нэрлэнэ үү?
1. Изониазид
  2. Рифамицин
  3. Пиразинамид
  4. Этамбутол
  5. Стрептомицин
- /96./ Сүрьеэгийн эмчилгээний 2-р бүлгээр ямар тохиолдлуудыг эмчлэх вэ?
1. Дахилт
  2. Тасалсан тохиолдол
  3. Үр дүнгүй эмчлэгдсэн тохиолдол
  4. Шинэ тохиолдол
  5. Архаг тохиолдол
- /97./ Сүрьеэгийн анхдагч бүрдэлийн бүрэлдхүүн хэсгүүдийг нэрлэнэ үү?
1. уушгины анхдагч голомт
  2. уушгины тунгалгийн судасны үрэвсэл
  3. уушгины угийн тунгалгийн булчирхайн үрэвсэл
  4. уушгины олширсон зураглал
  5. захын тунгалгийн булчирхайн үрэвсэл
- /98./ Эмч нийтийн тээврийн үйлчилгээнд ажилладаг ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж сүрьеэгийн тохиолдлыг оношилсон бол илрүүлэлтийн ямар аргыг хэрэглэсэн бэ?
- A. Идэвхитэй илрүүлэлт
  - B. Идэвхигүй илрүүлэлт
  - C. Хагас идэвхитэй илрүүлэлт
  - D. Идэвхигүй болон идэвхтэй илрүүлэлт
  - E. Хагас идэвхитэй болон идэвхгүй илрүүлэлт
- /99./ Сүрьеэгийн халдварын гол эх уурхайг нэрлэнэ үү?
- A. Түрхэц сөрөг уушгины сүрьеэтэй тохиолдол

- B. Захын тунгалгийн булчирхайн сүрьеэтэй тохиолдол
- C. Түрхэц эерэг уушгины сүрьеэтэй тохиолдол
- D. Түрхэц эерэг болон сөрөг тохиолдлууд
- E. Түрхэц сөрөг болон захын тунгалагийн булчирхайн сүрьеэтэй тохиолдол

/100./ Эмэнд дасалтай сүрьеэгийн эмчилгээнд хэрэглэх сүрьеэгийн 2-р эгнээний эмийн бэлдэмлүүдийг нэрлэнэ үү?

- A. Канамицин
- B. Циклосерин
- C. Этионамид
- D. Офлоксацин
- E. Дээрхи бүгд

/101./ Чихрийн шижин өвчинтэй 50 настай эмэгтэйд халуурах шинж гэнэт илэрсэн байна. Гэрлийн шинжилгээнд зүүн уушгины дээд дэлбэнд нэвчдэст өөрчлөлт тодорхойлогдсон бол цаашид оношийг тодруулахад ямар шинжилгээг заавал хийх ёстой вэ?

- A. Гуурсан хоолой дурандах
- B. Сүрьеэгийн нян цэрэнд хайх
- C. Амьсгалын багтаамж шалгах шинжилгээ
- D. Цусны шинжилгээ
- E. Туберкулины сорил

/102./ Сүрьеэгийн халдвар дамжих гол замыг нэрлэнэ үү?

- A. Хоол, тэжээлийн зам
- B. Амьсгалын зам
- C. Гэмтсэн арьс, салст
- D. Ихэс
- E. Дээрхи бүгд

/103./ Изониазидыг хэрэглэх үед элбэг тохиолдох гаж урвалыг бичнэ үү?

- A. Элэгний үрэвсэл
- B. Захын мэдэрлийн үрэвсэл
- C. Хараа муудах
- D. Үе өвдөх
- E. Бөөрний үрэвсэл

/104./ Сүрьеэгийн эмчилгээний 1-р бүлэгт эмчлэгдэх тохиолдлуудыг нэрлэнэ үү?

- A. Уушгины сүрьеэтэй болон бусад эрхтэний сүрьеэтэй шинэ тохиолдол
- B. Дахилттай тохиолдол
- C. Тасалсан тохиолдол
- D. Үр дүнгүй тохиолдол
- E. Дээрхи бүгд

/105./ Сүрьеэгийн эмчилгээ хийлгээд эдгэрсэн тохиолдол гэж хэн бэ?

A. Уушгины түрхэц эерэг сүрьеэтэй өвчтөн эмчилгээг бүрэн хийлгэж, хяналтын сүүлийн 2 удаагийн цэрний шинжилгээнд сөрөг болж, эмнэл зүйн шинжүүд арилж, гэрлийн шинжилгээнд өөрчлөлт шимэгдсэн.

B. Шинэ уушгины түрхэц сөрөг өвчтөн эмчилгээг бүрэн хийлгэж, хяналтын 3 удаагийн цэрний шинжилгээнд сөрөг болж, биеийн байдал сайжран, гэрлийн шинжилгээнд өөрчлөлт шимэгдсэн

C. Шинэ уушгины бус эрхтэний сүрьеэтэй өвчтөн биеийн байдал сайжирч, эмчилгээг бүрэн дууссан

- D. Сүрьеэгийн эмчилгээний хяналтын 5 дахь сарын түрхцийн шинжилгээнд эерэг болсон
- E. Дээрхи бүгд

/106./ “Б” дүүрэгт 2015 онд шинээр 40 түрхэц эерэг, 20 түрхэц сөрөг, 10 уушгины бус эрхтэний сүрьеэтэй тохиолдлууд бүртгэгдэн эмчлэгдээд 38 тохиолдол эдгэрсэн, 2 тасалсан, 1 үр дүнгүй эмчлэгдсэн ба бусад нь эмчилгээ дууссан гэсэн бол уг дүүргийн эдгэрэлтийн түвшинг бодож сонгоно уу?

- A. 0.85
- B. 1
- C. 0.95
- D. 0.5

Е. 0.75

/107./ Доорхоос ямар тохиолдолд олон эмэнд дасалтай сүрьеэ гэж үзэх вэ?

- А. Изониазидад дасалтай
- В. Изониазид+ рифампицинд дасалтай
- С. Пиразинамид+ этамбутолд дасалтай
- D. Изониазид болон стрептомицинд дасалтай
- Е. Дээрхи бүгд

/108./ Пиразинамидыг хэрэглэх үед гарч болох гаж нөлөөг нэрлэнэ үү?

- А. Хараа муудах
- В. Том үеэр өвдөх
- С. Сонсгол муудах
- D. Захын мэдрэлийн үрэвсэл
- Е. Дээрхи бүгд

/109./ Пиразинамидыг ямар өвчтэй хүнд болгоомжтой өгөх вэ?

- А. Тулай
- В. Чихрийн шижин
- С. Бамбайн хордлого
- D. Ходоодны шархлаа
- Е. Дээрхи бүгд

/110./ Хэвийн үед нугасны усанд сахарын хэмжээ ямар байх вэ?

- А. Цусан дахь сахарын хэмжээтэй адил байна.
- В. Цусан дахь сахарын хэмжээнээс 2 дахин их байна.
- С. Цусан дахь сахарын хэмжээнээс 2 дахин бага байна.
- D. Цусны сахарын гуравны нэгтэй тэнцүү хэмжээтэй байна
- Е. Дээрхи бүгд

/111./ Эсийн гадна болон дотор байрлах идэвхитэй ба унтаа сүрьеэгийн нянгуудыг хамгийн хүчтэй устгах үйлчилгээтэй эмийн бэлдэмлийг нэрлэнэ үү?

- А. Стрептомицин
- В. Пиразинамид
- С. Этамбутол
- D. Рифамицин
- Е. Изониазид

/112./ Сүрьеэтэй өвчтөнд эмийн гаж урвалын улмаас үүссэн захын мэдрэлийн үрэвсэлтэй тохиолдолд ямар витаминьг хэрэглэх вэ ?

- А. Тиамин
- В. Рибофлавин
- С. Никотинамид
- D. Пиродоксин
- Е. Токоферол

/113./ Сүрьеэгийн эмчилгээний 1-р бүлгийн хяналтын түрхэцийн шинжилгээг хэд хэдэн сард хийх ёстой вэ ?

- А. 2, 5, 6 сард
- В. 3, 5, 8 сард
- С. 2, 5, 7 сард
- D. 5, 6 сард
- Е. Дээрхи бүгд

/114./ Этамбутолын эсрэг заалтыг нэрлэнэ үү?

- А. Харааны мэдрэлийн үрэвсэлтэй тохиолдол
- В. Элэгний үрэвсэлтэй тохиолдол
- С. Захын мэдрэлийн үрэвсэлтэй тохиолдол
- D. Бөөрний үрэвсэлтэй тохиолдол
- Е. Дээрхи бүгд

/115./ Уушгины сүрьеэтэй тохиолдлын эрчимт шатны эмчилгээг сунгах заалтыг нэрлэнэ үү?

- А. Хяналтын 2 дахь сарын шинжилгээ эерэг бол
- В. Гэрлийн шинжилгээнд өөрчлөлт шимэгдээгүй бол
- С. Биеийн жин нэмэгдэхгүй бол

D. Эмнэл зүйн сайжралгүй бол

E. Дээрхи бүгд

/116./ Сүрьеэгийн менингитын үед нугасны усанд нэвчиж өндөр тунгаар тодорхойлогдох эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү?

A. Изониазид

B. Рифампицин

C. Пиразинамид

D. Этамбутол

E. Стрептомицин

/117./ Эмчилгээний 2-р бүлгээр эмчлэгдэх 60 настай 48 кг жинтэй тохиолдолд стрептомицины тунг сонгоно уу?

A. 1гр

B. 750 мг

C. 500 мг

D. 900 мг

E. 300 мг

/118./ Сүрьеэтэй өвчтөнд дархлал дэмжих эмчилгээг хэзээ хийвэл тохиромжтой вэ ?

A. Сүрьеэгийн эмчилгээ эхлэх өдрөөс хамт хийх

B. Сүрьеэгийн эмчилгээ хийж эхлээд 2 сарын дараа

C. Сүрьеэгийн эмчилгээ хийж дууссаны дараа

D. Сүрьеэгийн эмчилгээ эхлэхээс өмнө

E. Дээрхи бүгд

/119./ Витамин "B"-ийн солилцоог алдагдуулдаг сүрьеэгийн эмийн бэлдэмлийг нэрлэнэ үү?

A. Изониазид

B. Рифампицин

C. Пиразинамид

D. Этамбутол

E. Стрептомицин

/120./ Сүрьеэгийн нянгийн үржлийг дарангуйлдаг эмийн бэлдэмлийг нэрлэнэ үү?

A. Изониазид

B. Рифамицин

C. Этамбутол

D. Пиразинамид

E. Стрептомицин

/121./ Сүрьеэгийн эмчилгээний үр дүнгийн хяналтыг ямар шинжилгээгээр хийдэг вэ?

A. Гэрлийн шинжилгээ

B. Цэрний түрхэцийн шинжилгээ

C. Цусны шинжилгээ

D. Туберкулины сорил

E. Дээрхи бүгд

/122./ Сүрьеэтэй жирэмсэн тохиолдлын эмчилгээнд эсрэг заалттай сүрьеэгийн эмийн бэлдэмлийг нэрлэнэ үү ?

A. Этамбутол

B. Стрептомицин

C. Пиразинамид

D. Изониазид

E. Рифампицин

/123./ Изониазидыг насанд хүрэгсдэд өдөр бүр хэрэглэх дундаж тунг бичнэ үү?

A. 15мг/кг

B. 5 мг/кг

C. 10 мг/кг

D. 20 мг/кг

E. 25 мг/кг

/124./ Этамбутолыг хэрэглэх үед элбэг тохиолдож болох гаж урвалыг нэрлэнэ үү ?

A. Харааны мэдрэлийн үрэвсэл

B. Захын мэдрэлийн үрэвсэл

- C. Бөөрний үрэвсэл
- D. Элэгний үрэвсэл
- E. Сонсгол муудах

/125./ Эмчилгээ тасалсан тохиолдол гэж хэзээ тооцох вэ?

- A. Сүрьеэгийн эмчилгээний явцад 2 сар түүнээс дээш хугацаагаар эмчилгээг орхих
- B. Сүрьеэгийн эмчилгээний явцад шалтгаангүйгээр 14 хоног завсарлаад үргэлжлүүлэх
- C. Сүрьеэгийн эмчилгээг 1 сарын хугацаагаар таслах
- D. Сүрьеэгийн эмчилгээг 14 хоног таслаад эргэж ирэх
- E. Дээрхи бүгд

/126./ Захын тунгалгийн булчирхайн сүрьеэгийн оношлогоонд чухал ач холбогдолтой шинжилгээний аргыг нэрлэнэ үү?

- A. Цусны ерөнхий шинжилгээ
- B. Цэрний түрхэцийн шинжилгээ
- C. Биопсия
- D. Туберкулины сорил
- E. Дээрхи бүгд

/127./ Уушигны хорт хавдарын задрал болон уушигны архаг буглаанаас сорвит хөндийт сүрьеэг ялган оношлох гол үзүүлэлтийг нэрлэнэ үү?

- A. Өвчний эмнэл зүйн явц
- B. Цээжний гэрлийн шинжилгээнд илрэх өөрчлөлт
- C. Цэрний түрхэцийн шинжилгээнд сүрьеэгийн нян илрэх
- D. Цусны ерөнхий шинжилгээнд илрэх өөрчлөлт
- E. Дээрхи бүгд

/128./ Бага насны хүүхэд сүрьеэгийн менингитээр өвчлөхөд нөлөөлөх шууд шалтгааныг нэрлэнэ үү?

- A. Бие махбодын хэт мэдрэмтгий байдал
- B. Судасны хананы нэвчимхий чанар ихсэх
- C. Мэдрэлийн системийн хөгжил сул, дорой байх
- D. Биеийн ерөнхий эсэргүүцэл сул байх болон БЦЖ вакцины дараа дархлал үүсээгүй юмуу эсвэл сул үүссэн байх
- E. Дээрхи бүгд

/129./ Сүрьеэгийн менингитийн үед нугасны усны шинжилгээнд илрэх өөрчлөлтийг тоочно уу?

- A. Уургийн хэмжээ ихсэх
- B. Эсийн тоо олшрох
- C. Сахарын хэмжээ буурах
- D. Хлоридын хэмжээ буурах
- E. Бүгд зөв

/130./ Төв мэдрэлийн системийн бусад эмгэг өвчнүүдээс сүрьеэгийн менингитийг ялган оношлоход хэрэглэдэг гол оношлогооны шинжилгээний аргыг нэрлэнэ үү?

- A. Тархи нугасны шингэнд уураг, сахар, хлорид тодорхойлох шинжилгээ
- B. Аденизин деаминаза идэвхжил тодорхойлох шинжилгээ
- C. Тархи нугасны шингэнд молекул биологийн шинжилгээ
- D. Цээжний гэрлийн шинжилгээ
- E. Дээрхи бүгд

/131./ Сүрьеэгийн плевритийн оношлогоонд ач холбогдолтой шууд бус шинжүүдийг тоочно уу?

- A. Уушгины гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн хуучин, үлдэц өөрчлөлт илрэх
- B. Өвчний түүхэнд урьд нь сүрьеэгээр өвчилж байсан юмуу сүрьеэтэй өвчтөний хавьтал байх
- C. Эмнэл зүйн шинжүүд болон бусад клиник шинжилгээнд өвөрмөц үрэвслийн шинж илрэх
- D. Өргөн хүрээний антибиотик эмчилгээнд үр дүнгүй байх
- E. Дээрхи бүгд

/132./ Сүрьеэгийн савханцар яс үений системд дамжин орох гол замыг нэрлэнэ үү?

- A. Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн гэмтлээс тунгалгийн шингэнээр дамжих
- B. Уушгины голомтлог өөрчлөлтөөс тунгалгийн шингэнээр дамжих

C. Анхдагч голомтоос цусаар дамжин тархах

D. Цусаар болон тунгалгаар дамжих

E. Дээрхи бүгд

/133./ Яс-үений сүрьеэг оношлоход ач холбогдолтой гол шинжилгээг нэрлэнэ үү?

A. Туберкулины сорил

B. Гэрлийн шинжилгээ

C. Бактериологийн шинжилгээ

D. Цусны шинжилгээ

E. Дээрхи бүгд

/134./ Идэвхитэй сүрьеэ, уушгины хорт хавдартай хавсарсан тохиолдолд туяа эмчилгээ, гормон эмчилгээ, цитостатик бэлдэмлээр эмчлэх үү?

A. Сүрьеэ даамжирч болох тул хэрэглэхгүй

B. Ховор тохиолдолд хэрэглэнэ

C. Сүрьеэгийн эмчилгээтэй хавсарч хэрэглэнэ

D. Хордлого тайлах эмчилгээтэй хавсарч хэрэглэнэ

E. Дээрхи бүгд

/135./ Холбогч эдийн түгээмэл өвчнүүдийн үед сүрьеэгээр өвчлөх магадлалыг нэмэгдүүлдэг гол шалтгааныг нэрлэнэ үү?

A. Глюкокортикоид гормон удаан хэрэглэх

B. Уг өвчний явц архаг байх

C. Уургийн солилцоо алдагдсанаас

D. Биеийн эсэргүүцэл суларсанаас

E. Дээрхи бүгд

/136./ Сорвит хөндийт сүрьеэ үүсэх шалтгааныг нэрлэнэ үү?

A. Сүрьеэгийн нян хоруу чанар өндөртэй байх

B. Архаг суурь өвчтэй байх

C. Сүрьеэгийн эмчилгээ дутуу, буруу хийгдэх

D. Үрэвсэл уушгины талбайг их хэмжээгээр хамрах

E. Дээрхи бүгд

/137./ Сорвит хөндийт сүрьеэтэй өвчтөний уушгийг тогшиход илрэх өөрчлөлтийг тоочно уу?

A. Нэг болон 2 талын уушгины дээд дэлбэнд тогшилтын чимээ бүдгэрч, доод хэсгүүдэд хайрцагны чимээтэй

B. Уушгины бүх талбайд тод авиатай

C. Уушгины бүх талбайд хайрцагны чимээтэй

D. Гэмтсэн хэсэгт тимпаник чимээтэй ба бусад хэсэгт өөрчлөлтгүй

E. Дээрхи бүгд

/138./ Сорвит хөндийт сүрьеэтэй өвчтөний нас баралтын гол шалтгааныг нэрлэнэ үү?

A. Сүрьеэгийн хордлого

B. Уушгины цус алдалт

C. Дотор эрхтэний амилоидоз

D. Бусад эрхтэний сүрьеэ хавсрах

E. Архаг уушгин- зүрх

/139./ Сорвит хөндийт сүрьеэгийн намжмал байдлын үед халдвар тараахгүй гэдгийг батлах гол шалгуур үзүүлэлтийг нэрлэнэ үү?

A. Хордлогын хам шинж намжих

B. Гэрлийн шинжилгээнд эерэг өөрчлөлт илрэх

C. Цэрний түрхэцийн шинжилгээнд сөрөг буюу сүрьеэгийн нян илрэхгүй байх

D. Уушиг-гуурсан хоолой гялтангийн хам шинж бүдэгрэх

E. Дээрхи бүгд

/140./ Сорвит хөндийт сүрьеэгийн үед гэмтсэн хэсэгт юу сонсогдохгүй вэ?

A. Цөөн тооны жижиг нойтон хэржигнүүр

B. Хуурай хэржигнүүр, гуурсан хоолойн амьсгал

C. Янз бүрийн олон тооны хэржигнүүр

D. Суларсан цулцангийн амьсгал

E. Цулцангийн амьсгал

/141./ Хөндийг бүрэн эдгэрсэн гэж хэзээ тооцох вэ ?

- A. Хоёрдогч киста үүсэх
- B. Псевдотуберкулем үүсэх
- C. Сорвижих
- D. Ариутгагдсан хөндий үүсэх
- E. Дээрхи бүгд

/142./ Нэвчдэст сүрьеэгийн хүндэрлийг нэрлэнэ үү?

- A. Сорвит голомт үүсэх
- B. Туберкулем үүсэх
- C. Хөндийт сүрьеэ үүсэх
- D. Тархмал сүрьеэ үүсэх
- E. Дээрхи бүгд

/143./ Уушгины туберкулемыг ялган оношлох өвчнийг нэрлэнэ үү?

- A. Захын хорт хавдар
- B. Дүүрэн киста
- C. Дугуй нэвчдэст сүрьеэ
- D. Хоргүй хавдар
- E. Дээрхи бүгд

/144./ Туберкулемагийн эмчилгээний үед гэмтэлийн голомтонд сүрьеэгийн эм нэвтрэхэд саад болдог зүйл юу вэ ?

- A. Орчны эдийн үрэвсэл
- B. Холбогч эдэн бүрхүүл
- C. Өвөрмөц грануляц эс
- D. Ээдэмцэрт үхжил
- E. Дээрхи бүгд

/145./ Хөндийт сүрьеэ үүсэх шалтгааныг тоочно уу?

- A. Дутуу, буруу эмчилгээ
- B. Эмийн дасалтай нянгаар сүрьеэ үүсэх
- C. Оношийн хожимдол
- D. Эмийн гаж нөлөө
- E. Дээрхи бүгд

/146./ Хөндийт сүрьеэгийн үед үүссэн хөндийн хэмжээ юунаас хамаарах вэ ?

- A. Гэмтсэн эдийн хэмжээ, холбогч бронхийн байдал
- B. Нянгийн хоруу чанар, хөндий үүсгэсэн сүрьеэгийн хэлбэр
- C. Хөндийн хананы үхжил
- D. Уушигны эдийн цусны эргэлтийн алдагдал
- E. Бие махбодын эсэргүүцэл, нянгийн үржил

/147./ Туберкулемын тогтвортой явцын үед цусны шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх вэ ?

- A. СОЭ хурдсах, лейкоцитоз, лейкоцитын цөм зүүн тийш хазайсан
- B. СОЭ хэвийн, лейкоцитоз, лейкоцитын цөм зүүн тийш хазайсан
- C. Онцын өөрчлөлт илрэхгүй
- D. Лейкоцитоз, лимфоцитопения, СОЭ хурдсах
- E. Дээрхи бүгд

/148./ Туберкулем гэж юу вэ ?

A. 12 мм-ээс дээш хэмжээтэй казеоз үхжилтэй өвөрмөц үрэвсэл үүсэхийг туберкулема гэнэ

B. 12 мм-ээс дээш хэмжээтэй гадуураа холбогч эдэн бүрхүүлтэй ээдэмцэрт үхжилт өөрчлөлтийг туберкулема гэнэ.

- C. Казеоз үхжилт үрэвслийг туберкулема гэнэ
- D. Уушигны хоёрдогч сүрьеэгийн нэг хэлбэрийг туберкулема гэнэ
- E. Дээрхи бүгд

/149./ Туберкулем голдуу хаанаас задардаг вэ ?

- A. Төвөөс
- B. Захаас
- C. Ирмэгээс
- D. Зах ирмэгдүү, гадагшлуулагч бронх байгаа хэсгээс
- E. Дээрхи бүгд



/150./ Нэвчдэст сүрьеэгийн бусад хэлбэрүүдээс казеоз хатгалгааны ялгагдах гол шинжийг бичнэ үү?

- A. Бүтэн дэлбэн юмуу уушгийг хамарсан
- B. Казеоз үхжил давамгайлсан үрэвсэлтэй
- C. Задрах хандлага өндөртэй
- D. Гуурсан хоолойгоор дамжин цацагдсан голомтуудтай
- E. Дээрхи бүгд

/151./ Анхдагч сүрьеэгээс элбэг тохиолдох эмнэл зүйн хэлбэрийг нэрлэнэ үү?

- A. Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
- B. Сүрьеэгийн анхдагч бүрдэл
- C. Сүрьеэгийн хордлого
- D. Уушигны голомтот сүрьеэ
- E. Дээрхи бүгд

/152./ Уушигны хоёрдогч сүрьеэгээс элбэг тохиолдох хэлбэрийг нэрлэнэ үү?

- A. Уушигны голомтот сүрьеэ
- B. Уушигны нэвчдэст сүрьеэ
- C. Уушигны туберкулема
- D. Уушигны хөндийт сүрьеэ
- E. Сорвит хөндийт сүрьеэ

/153./ Дугуй нэвчдэст сүрьеэгийн эмнэл зүйн явц ямар байдаг вэ?

- A. Шинж тэмдэггүй
- B. Шинж тэмдэг бүдэг илэрсэн аажим явцтай
- C. Шинж тэмдэг тод илэрсэн, хурц явцтай
- D. Хурц тод шинж тэмдэгтэй
- E. Дээрхи бүгд

/154./ Дугуй нэвчдэст сүрьеэгээс зайлшгүй ялган оношлох шаардлагатай өвчнийг нэрлэнэ үү?

- A. Уушгины хатгалгаа
- B. Уушгины бэтэг
- C. Уушгины хорт хавдар
- D. Эозинофилийн нэвчдэс
- E. Уушигны буглаа

/155./ Уушгины гэрлийн шинжилгээнд сорвижсон, шохойжсон голомтын тодрол ямар байдаг вэ?

- A. Сул тодролтой
- B. Дунд зэргийн тодролтой
- C. Өндөр тодролтой
- D. Бага тодролтой
- E. Дээрхи бүгд

/156./ Анхдагч сүрьеэгийн оношлогоонд ач холбогдолтой туберкулины сорилын хариу урвалыг нэрлэнэ үү?

- A. Хэт эерэг урвал
- B. Сөрөг урвал
- C. Анх удаа эерэг урвал илрэх
- D. Эргэлзээтэй урвал
- E. Дээрхи бүгд

/157./ Анхдагч сүрьеэгээр голдуу ямар насныхан өвчилдөг вэ?

- A. Өндөр настангууд
- B. Бага насны болон өсвөр насны хүүхэд
- C. Залуу насныхан
- D. Идэр насныхан
- E. Дээрхи бүгд

/158./ Анхдагч сүрьеэгийн үед илэрч болох салст цочрох урвалын шалтгааныг тайлбарлана уу?

- A. Салстанд сүрьеэгийн өвөрмөц үрэвсэл үүснэ
- B. Сүрьеэгийн нянгийн хооронд салст цочирч харшилын урвал үүснэ

- C. Сүрьеэгийн нян цусаар тархаж эргэлдэнэ
- D. Сүрьеэгийн нян тунгалгаар тархаж эргэлдэнэ
- E. Дээрхи бүгд

/159./ Сүрьеэгийн анхдагч бүрдэл гэж юу вэ?

- A. Уушгинд сүрьеэгийн гэмтэл үүсдэг анхдагч сүрьеэгийн хэлбэр юм
- B. Уушгины эд үрэвсэж гэмтэхийн хамт угийн тунгалгийн булчирхай гэмтдэг хэлбэр.
- C. Уушгинд анхдагч голомтот өөрчлөлттэй, тунгалгийн судасны болон угийн булчирхайн үрэвсэлтэй анхдагч сүрьеэгийн нэг хэлбэр юм.
- D. Анхдагч сүрьеэгийн байршлаа олсон хэлбэр юм.
- E. Дээрхи бүгд

/160./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн “хавдар ”төст хэлбэрийн онцлогийг тоочно уу?

- A. Олон бүлэг тунгалгийн булчирхайг гэмтээсэн
- B. “Казеоз үхжил ” ихтэй
- C. Хүндрэх хандлага өндөртэй
- D. Туберкулинд хэт өндөр мэдрэг урвал илэрсэн
- E. Дээрхи бүгд

/161./ Цусны АсАТ-гийн идэвхи хэт ихсэх эмгэгүүдийг заана

1. Зүрхний булчингийн шигдээс
2. Халдварт гепатит
3. Элэгний хордлогот үрэвсэл
4. Шок, гипоксит-тэй цусны эргэлтийн дутагдал
5. Халдварт менингит

/162./ Хурц милиар сүрьеэгийн үед голомтууд уушгинд хэрхэн тархсан байдаг вэ?

- A. Жигд
- B. Жигд бус
- C. Бүлэглэсэн
- D. Жигд бүлэглэсэн
- E. Дээрхи бүгд

/163./ Төвийн гаралтай хорт хавдарыг ямар хэлбэрийн сүрьеэгээс ялган оношлох шаардлагатай вэ?

- A. Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
- B. Туберкулема
- C. Дугуй нэвчдэст сүрьеэ
- D. Хөндийт сүрьеэ
- E. Тархмал сүрьеэ

/164./ Уушигны голомтот сүрьеэгийн тодорхойлолтыг бичнэ үү?

- A. Уушигны сүрьеэгийн хязгаарлагдсан өөрчлөлт юм
- B. Эмнэл зүйн шинж тэмдэггүй явцтай уушигны сүрьеэгийн хэлбэр юм
- C. Уушигны хоёрдогч сүрьеэгийн хэлбэр
- D. Нэг юмуу хоёр талын уушигны нэгээс хоёр сегментийг хамарсан 12 мм хүртэл хэмжээтэй сүрьеэгийн голомтот өөрчлөлт үүснэ
- E. Дээрхи бүгд

/165./ Уушгины голомтот өөрчлөлт идэвхитэй байгаа тохиолдолд тодрол нь ямар байх вэ?

- A. Бага буюу сул
- B. Янз бүрийн
- C. Өндөр
- D. Дунд зэрэг
- E. Дээрхи бүгд

/166./ Уушигны голомтот сүрьеэгийн эмнэл зүйн явц голдуу ямар байдаг вэ?

- A. Шинж тэмдэг хурц тод илэрнэ
- B. Шинж тэмдэггүй буюу шинж тэмдэг бүдэг
- C. Ужиг явцтай
- D. Хүндрэлтэй
- E. Дээрхи бүгд

/167./ Уушгины нэвчдэст сүрьеэгийн тодорхойлолтыг бичнэ үү?

- A. Эдийн үрэвсэл давамгайлсан задрах хандлага багатай уушигны сүрьеэгийн хэлбэр юм.  
B. Шүүдэст үрэвсэл давамгайлсан, задрах хандлага өндөртэй уушигны хоёрдогч сүрьеэгийн хэлбэр юм  
C. Хурц тод эмнэл зүйн явцтай уушигны хоёрдогч сүрьеэ юм  
D. Уушигны голомтот сүрьеэ даамжирсан тохиолдолд үүсдэг уушигны сүрьеэгийн хэлбэр юм  
E. Дээрхи бүгд
- /168./ Нэвчдэст сүрьеэгийн оношлогоонд чухал үүрэг гүйцэтгэх шинжилгээний аргыг нэрлэнэ үү?  
A. Гэрлийн шинжилгээ  
B. Цэрний түрхэцийн шинжилгээ  
C. Цусны шинжилгээ  
D. Гуурсан хоолой дурандах шинжилгээ  
E. Томографийн шинжилгээ
- /169./ Аварга” хэмжээтэй цагираг сүүдэр гэж хэзээ тооцох вэ?  
A. 2 см  
B. 2-4 см  
C. 7 см түүнээс дээш  
D. 7 см хүртэл  
E. Дээрхи бүгд
- /170./ Уушгины хоёрдогч сүрьеэгийн үед цээжний гэрлийн шинжилгээнд үрэвслийн өөрчлөлт голдуу хаана байрладаг вэ?  
A. I, II.VI сегмент  
B. VIII, IX, X сегмент  
C. IV, V сегмент  
D. III сегмент  
E. Дээрхи бүгд
- /171./ Уушгины уг өөрчлөгдөх хам шинж сүрьеэгийн ямар хэлбэрийн үед илрэх вэ?  
A. Сүрьеэгийн бронхаденит  
B. Захын тунгалгийн булчирхайн сүрьеэ  
C. Голомтот сүрьеэ  
D. Хөндийт сүрьеэ  
E. Нэвчдэст сүрьеэ
- /172./ Милиар голомтын хэмжээг хэлнэ үү?  
A. 1-2 мм  
B. 3-4 мм  
C. 5-8 мм  
D. 9-12 мм  
E. Дээрхи бүгд
- /173./ Нэвчдэст сүрьеэтэй тохиолдлын оношийг батлах шинжилгээний аргыг сонгоно уу ?  
A. Гэрлийн шинжилгээ  
B. Цэрний түрхэцийн шинжилгээ  
C. Цусны шинжилгээ  
D. Гуурсан хоолой дурандах шинжилгээ  
E. Туберкулины сорил
- /174./ Гипокальцеми илрэх эмгэгүүдийг заах  
1. Сульдаа /рахит/  
2. Гиперкальциури-тай архаг пиелонефрит  
3. Нефротик хам шинж  
4. Гиперпаратиреоидизм  
5. Амьсгалын гүнзгий дутагдал
- /175./ Уушгины гэрлийн шинжилгээнд илрэх тархмал сүүдрийн хам шинж гэж юу вэ?  
A. Уушигны хоёроос дээш сегментийг хамарсан, олон тооны голомтот сүүдэр тодорхойлогдоно.  
B. Уушигны нэг бүтэн дэлбэнг хамарсан нэвчдэст сүүдэр тодорхойлогдоно.

С. Уушигны 1-2 сегмент хамарсан 12 мм хүртэл хэмжээтэй ганц нэг юмуу олон тооны сүүдэр илэрнэ.

D. Уушигны дээд дэлбэнгүүдэд агаартай хөндий үүснэ

E. Дээрхи бүгд

/176./ Сүрьеэгийн нян илрүүлэх цэрний түрхэцийг Циль-Нильсены аргаар будах үед сүрьеэгийн савханцарын ямар шинжийг ашиглаж байна вэ?

A. Гадаад орчинд тэсвэртэй шинж

B. Хүчилд тэсвэртэй шинж

C. Сөрөг хэмд тэсвэртэй шинж

D. Хувирамтгай шинж

E. Дээрхи бүгд

/177./ Сүрьеэгийн микобактерийг өсгөвөрлөхөд тохиромжтой хэмийг тэмдэглэнэ үү?

A. 35 хэм

B. 37 хэм

C. 42 хэм

D. -28 хэм

E. 75 хэм

/178./ Цэрний түрхэцийн шинжилгээний хариунд эерэг ба /++/ гэсэн тэмдэглэл байвал харах талбайд хэдэн ширхэг хүчилд тэсвэртэй нян (ХТН) илэрсэн бэ?

A. ХТН олдоогүй /100 ХТ

B. 1-9 ХТН/ 100 ХТ

C. 10-99 ХТН/ 100 ХТ

D. 1-10 ХТН/ 50 ХТ

E. 10 дээш ХТН/ 20 ХТ бүрт

/179./ Ийлдэсний төмөр багасах эмгэгүүдийг заах

1. Төмөр дутлын анеми

2. Гипотиреоз /микседема/

3. Нефротик хам шинж

4. Гемохроматоз, порфири

5. атрансферринемии

/180./ Сүрьеэгийн нян илрүүлэх цэрний түрхэцийг ямар аргаар будах вэ?

A. Граммын арга

B. Романовский- гимзийн арга

C. Циль- Нильсены арга

4. Бэлгийн харьцаанд орохгүй байхыг зөвлөнө.
5. Давсганд байнгын катетер тавина.

/570./ Ханиах, найтаах, цочих, чанга инээх болгонд доошоо шээс нь дусагнаад байгаа настай эмэгтэйд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Хоногт уух шингэний хэмжээг багасгах
2. 2 цаг тутам шээж, давсгаа сулалж байх.
3. Хярзангийн булчин чангалах дасгалыг байнга хийж байх
4. Хоол, нойрны дэглэмийг сахиж, турж эцэхгүй байх
5. А, Е, В аминдэмийн комплекс курсээр уух

/571./ Хүзүүний остеохондроз өвчин настанд ямар шинжүүдээр илэрдэг вэ?

1. Хүзүү чилж, хөдлөхөд хатгуулах, цахилгаан гүйх мэт өвдөнө
2. Гар, мөрний хөдөлгөөн хөшнө
3. Чих шуугих, толгой эргэх шинжүүд илэрнэ
4. Ханиах, найтаах үед хүзүүний өвдөлт ихэснэ
5. Хүзүүний рентген зурагт хүзүүний нугаламууд хоорондоо ойртох, нийлэх шинж харагдана.

/572./ Хүзүүний остеохондроз өвчин байж болзошгүйг оношлох хялбар, хямд аргуудыг дурьд:

1. Толгойгоо урагшаа тонгойлгон эгмэндээ хүргээд, дараа нь арагшаа болгоомжтой гэдийхэд өвдөх шинжийг шалгах.
2. Толгойгоо баруун, зүүн тийш хазайлган, чихээ мөрөндөө хүргэхийг хичээхэд өвдөх шинжийг шалгах.
3. Толгойгоо аажим эргүүлж, арагшаа харахыг хичээхэд өвдөх шинжийг шалгах.
4. Хүзүүний рентген шинжилгээ
5. Компьютерийн томограм хийх.

/573./ Хүзүүний остеохондроз өвчинг эмчлэхгүй бол ямар уршигтайг хэрхэн тайлбарлах вэ?

1. Хүзүүний остеохондроз нь тархины цусан хангамжийг муутгадаг тул тархины судас хатуурах, ой тогтоолт муудах, уймраа, зөнөг болоход нөлөөлдөг.
2. Толгой байнга өвддөг болно.
3. Хүзүүгээр хөдлөх болгонд цахилгаан гүүх мэт өвддөг болно.
4. Зүрхээр өвддөг болно
5. Хүзүү богиносож, хүзүүний арьс үрчийхээс гадна сарьс мэт унжих болно.

/574./ Хүзүүний остеохондрозтой настанд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Хүзүүний рентген зураг авах, хүнд хөнгөнийг тогтоох
2. Хүзүүний татлага эмчилгээнд явахыг зөвлөнө
3. Яс сийрэгжилтээс сэргийлэх зорилгоор Д аминдэм, кальц, фосфор, магни агуулсан эмийн бүрдэл тогтмол ууж байхыг зөвлөнө.
4. Эмчилгээний дасгалуудыг хийж байхыг зөвлөнө
5. Хүзүү амархан үрчидэг тул хүзүүний арьсыг арчилж байхыг зөвлөнө.

/575./ Хүзүүний остеохондрозтой настанд өрхийн эмч ямар дасгалуудыг зааж өгөх вэ?

1. Гарынхаа алгыг духан дээрээ тавиад, амьсгалаа гүн авч, урагшаа тонгойх үед гараараа эсэргүүцэл үзүүлэх. Гараа дагзанд байрлуулан, толгойгоо арагшаа гэдийх үед эсэргүүцэл үзүүлэх.
2. Амьсгалаа авсны дараа толгойгоо баруун, дараа нь зүүн тийш хазайх үед гарын алгаар шанаандаа тулж, эсэргүүцэл үзүүлэх.
3. Толгойгоо болгоомжтойгоор цагийн зүүний дагуу, дараа нь эсрэг чиглэлээр эргүүлэх.

4. Толгойгоо унжуулаад, хүзүүнийхээ булчинг сулласны дараа эрүүгээрээ цээжээ арчих мэт хөдөлгөөнийг 10 удаа давтан хийх.

5. Толгойгоо гэдийлгээд, булчингаа сулласны дараа дагзаараа хүзүүний доод хэсгийг 10 удаа үрэх мэт хөдөлгөөн хийх.

/576./ Өтлөх насанд тохиолдох чихрийн шижин өвчний үед ямар шинжүүд илэрдэг вэ?

1. Ам цангах
2. Арьс хуурайших, загатнах, гуйжих
3. Шээсний хэмжээ ихсэх
4. Арьсан дээр идээт үрэвслүүд үүсэх
5. Хараа муудах.

/577./ Настанд тохиолдох чихрийн шижин хүүхэд, залуучуудын чихрийн шижингээс юугаар ялгаатай вэ?

1. Нойр булчирхайны Лангергансын аралд инсулин ялгаралт багассанаас үүсдэг.
2. Глюкозыг эд эс тэсвэрлэх чанар буурснаас үүсдэг
3. Насан турш инсулин тарих шаардлагатай
4. Хоолны дэглэм сахих эсвэл эм уухад үр дүнтэ
5. Дэглэм алдвал оврого үүсэх нь элбэг.

/578./ Өтлөх насанд тохиолдох чихрийн шижин өвчнийг сэжиглэж буй настанд өрхийн эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Цус, шээсэнд чихэр үзэх шинжилгээ хийлгэнэ
2. Дотоод шүүрэл, нүд, зүрх судасны эмчид үзүүлнэ
3. Хоолны зөвлөгөө өгнө
4. Архи, тамхи хэрэглэхгүй байхыг зөвлөнө.
5. Хөл, гарны үзүүр, хумс харлах шинж илрэх эсэхийг өвчтөн өөрөө тогтмол шалгаж байхыг зөвлөнө

/579./ Чихрийн шижинг эмчлэхгүй бол настанд ямар хор уршигтай вэ?

1. Их ууж, шээсээр их чихэр алдаж буй тул настан турж эцэх магадлалтай.
2. Цусны сахар байнга их байх нь нүдний судасны эмгэгийг үүсгэж, тэрээр хараа муудах, сохрох аюултай
3. Цусны сахар байнга их байх нь хөлний судасны эмгэг үүсгэж хөлний хумс, арьс харлан үхжих аюултай тул хөлөө тайруулахад хүргэдэг
4. Зүрхний шигдээс үүсэх магадлал ихэсдэг
5. Арьс хуурайшиж, гэмтэх, хатиг, батга зэрэг идээт үрэвсэл үүсэх магадлал ихэсдэг.

/580./ Нүдний даралт ихсэх өвчин настанд ямар шинжүүдээр илэрдэг вэ?

1. Нүдний угаар хүчтэй өвдөх
2. Толгой өвдөх
3. Хараа эрс муудах
4. Гэрэлрүү харахад солонгон бүрхүүл үзэгдэх
5. Дотор муухайрах, бөөлжих

/581./ Нүдний даралт нь ихэссэн настанд өрхийн эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Нүдний эмчид яаралтай үзүүлэх
2. 2%-ын пилокарпины уусмал 2 нүдэнд ойр ойрхон дусаах
3. Сэтгэл санааны хувьд тайван байх, хэт халуун усаар толгой угаах, хэт халуун сэнсээр үс хатаахгүй байхыг зөвлөнө
4. Давс хязгаарлах, өтгөн цай, кофе, спиртын төрлийн ундаа хэрэглэхгүй байхыг зөвлөнө
5. Тамхи татахгүй байхыг зөвлөнө

/582./ Тархины цусан хангамжийн архаг дутагдалтай настанд ямар шинжүүд илрэх вэ?

1. Ой тогтоолт муудна, уймраа болно
2. Толгой өвдөх хандлагатай байна
3. Нүдний хараа муудна
4. Нугасны усаны шинжилгээнд цус илэрнэ.
5. Ухаан алдаж, татна

/583./ Тархины цусан хангамжийн архаг дутагдалтай настанд ямар эмчилгээ зөвлөх вэ?

1. Тархины цусан хангамж сайжруулах зорилгоор Кавинтоныг өдөрт 1-2 шахмалаар 3 удаа уух

2. Атеросклерозын эсрэг Ундевит аминдэмийн бүрдлээс хоногт 1 үрлээр 2 удаа байнга ууж байх

3. Артерийн даралт тогтвортой байлгах зорилгоор тухайн өвчтөнд зохидог даралт бууруулах эмийг хэрэглэж байх

4. Архи, тамхинаас хол байхыг зөвлөнө

5. Хоол хүнсэнд 3 цагаан хорыг хязгаарлах ба сармис байнга хэрэглэж байхыг зөвлөнө  
/584./ Хүзүүний остеохондрозын үед ямар өвдөлт үүсдэг вэ?

1. Толгой өвдөнө, хүзүү чилнэ, АД ихсэнэ

2. Зүүн мөр, гар, цээж нилэнхүйдээ өвдөнө.

3. Баруун хавирганы нумаар өвдөнө, баруун гар, мөр унжиж өвдөнө

4. Хүзүүг хөдөлгөх, ханиаж, найтаах үед хүзүү, мөрлүү хатгуулж, цахилгаан шиг жирвэгнэж өвдөнө.

5. Нүдний угаар хүчтэй өвдөнө

/585./ Нүдний даралт ихсэх өвчнийг ямар өвчнүүдтэй ялган оношлох вэ?

1. АД ихсэх

2. Гавлын дотоод даралт ихсэх

3. Тархины хавдар

4. Томуу

5. Нүдний гэмтэл, үрэвсэл

/586./ Настанд нүдний даралт ихсэх нь АД ихсэх, тархины хавдар өвчнүүдтэй ямар шинжээрээ ижил төстэй вэ?

1. Толгой өвдөх

2. Нүдний угаар өвдөх

3. Дотор муухайрах

4. Зүрхээр хатгуулах

5. Анальгин уухад өвдөлт намдах

/587./ Настанд тархины цусан хангамжийн архаг дутагдал буюу атеросклероз ямар шинжүүдээр илэрдэг вэ?

1. Мартамхай уймраа болох

2. Тэнэгрэл зөнөгрөл үүснэ

3. Үе үе гар, хөл бадайрна

4. Гэнэт ам, нүүр мурийж нүүрний мэдрэл саажна

5. Гэнэт хөл гар мэдээгүй болж саажна

/588./ Настанд тархины цусан хангамжийн хурц дутагдал буюу ишемийн инсульт ямар шинжүүдээр илрэх вэ?

1. Гэнэт гар хөл мэдээгүй болж бадайрна

2. Гэнэт ам, нүүр мурийж, саажна

3. Гэнэт юм ярихад хэл орооцолдож эхлэнэ

4. Толгой эргэх, орчны юм дайвах

5. Чих шуугих, тэнцвэр алдах.

/589./ Настанг атеросклерозоос сэргийлэхийн тулд өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?

1. Хоолонд гурван цагаан хорыг буюу өөх тос, давс, сахарыг хязгаарлах ба сармис, улаан чавга, долоогоны ханд хэрэглэж байхыг зөвлөнө.

2. Настангийн артерийн даралтыг тогтмол хянаж, даралт ихэсгэхгүй байхад анхаарах

3. Настангийн цусанд холестерол, липид, сахарын хэмжээг хянаж байх

4. Атеросклерозын эсрэг Ундавит, Гериавит зэрэг аминдэмийг ууж байхыг зөвлөх.

5. Цэвэр агаарт хөдөлгөөн дасгал хийхийг зөвлөх

/590./ Тархины цусан хангамжийн дутагдлаас нүүр нь мурийж, хэл ярианд өөрчлөлт орсон настанд өрхийн эмч ямар нөхөн сэргээх дасгалууд зааж өгөх вэ?

1. 2 нүдээ чанга аних. Бүлтийж харах. Ээлжлэн ирмэх.

2. Хөмсгөө зангидах, духаа үрчийлгэх

3. Шүдээ зуух, уруулаа цорвойлгох, исгэрэх, үлээх, архирах мэт шүдээ ярзайлгах хөдөлгөөнүүдийг хийх.

4. Амандаа хий дүүргэн, хацраа бөмбийлгөх

5. А, э, и, о, ө, у, ү, е авиаг аажим удаан дуудах. Дасгал тус бүрийг 5-8 удаа хийх.

/591./ Тархины цусан хангамжийн дутагдлаас нүүр нь мурийж, саажсан настанд өрхийн эмч ямар амин дэмийн эмчилгээг зөвлөх вэ?

1. Нейробекс
2. Ундавит
3. Гериавит
4. Гендавит
5. Кальцинова

/592./ Настангийн цусны даралт ихсэхэд ямар хүчин зүйлүүд нөлөөлдөг вэ?

1. Наслалттай холбоотой явагдаж буй өөрчлөлтүүд
2. Тараглалт.
3. Давс, өөхийг хоол хүнсэнд ихээр хэрэглэх
4. Архи, тамхи хэрэглэх
5. Биеийн хөдөлгөөний хомсдол

/593./ Настанд цусны даралт ихсэх өвчний 0 шатанд ямар эмийн эмчилгээ хийх вэ?

1. Люминал 50 мг
2. Эуноктин 2,5-5 мг
3. Седуксен 10 мг
4. Фуросемид 20-40 мг
5. Гипотиазид 75-100 мг

/594./ Настанд цусны даралт ихсэх өвчний 1-р шатанд ямар эмийн эмчилгээ хийх вэ?

1. Ангиотензин хувиргагч
2. Төвийн гаралтай даралт буулгах эмүүд
3. Судас тэлэгч эмүүд
4. Шээс хөөх эм, адреноблокатор, кальцийн блокатор эмүүдээс аль нэгийг хэрэглэнэ.
5. Шээс хөөх эм, адреноблокатор, кальцийн блокатор эмүүдийг хавсарч хэрэглэнэ.

/595./ Настанд цусны даралт ихсэх өвчний 2-р шатанд ямар эмийн эмчилгээ хийх вэ?

1. Ангиотензин хувиргагч
2. Төвийн гаралтай даралт буулгах эмүүд
3. Судас тэлэгч эмүүд
4. Шээс хөөх эмийг адреноблокатор, кальцийн блокатор эмүүдийн аль нэгтэй нь хавсарч хэрэглэнэ
5. Шээс хөөх эм, адреноблокатор, кальцийн блокатор эмүүдээс аль нэгийг хэрэглэнэ.

/596./ Настанд цусны даралт ихсэх өвчний 2-р шатанд хэрэглэж болох эмүүдийг сонго?

1. Фуросемид 20-40 мг
2. Гипотиазид 75-100 мг
3. Атенолол 50 мг
4. Нифедипин 20-50 мг
5. Верапамил 240- 480 мг

/597./ Настанд зүрхний стенокардийн үед илрэх шинжүүд:

1. Зүрх орчим өвдөх
2. Өвдөлт зүүн гар, дал, мөрлүү дамжих
3. Өвдөлт биеийн хүчний ажил, сэтгэл таатай биш үед, бухимдах үед, хүйтэн салхи сөрөх үед, хоол идэх, тамхи татсаны дараа илэрдэг.
4. Өвдөлт 1-15 мин орчим үргэлжилдэг
5. Өвдөлт нитроглицеринд намддаг

/598./ Зүрхний шигдээс стенокарди өвчнөөс юугаар ялгаатай вэ?

1. Зүрх орчим хүчтэй өвдөх
2. Нитроглицерин 3 шахмалаар хэлэн дор тавихад ч зүрхний өвдөлт намдахгүй
3. Хүйтэн хөлс гарна
4. ЗЦБ-т гүнзгий Q шүд, ST сегмент өргөгдөнө, Т шүдний өөрчлөлт илэрнэ
5. Зүрхний хүчтэй өвдөлт 30 минутаас илүү удаан үргэлжлэх

/599./ Зүрхний шигдээсийн үед өрхийн эмчийн менежмент

1. Титэм судсыг өргөсгөх эмчилгээ хийнэ: Нитроглицериныг 15 минутын зайтай хэлэн дор тавина.
2. Өвдөлт намдаах эмийг тарина: Морфин эсвэл Трамадол.

3. Гараа эмчилгээг хийсний дараа эмнэлэгт яаралтай биечлэн түргэний машинаар хүргэж өгнө.

4. Эмнэлэг хүрэх замд АД, пульсийг байнга шалгаж байна

5. Хэрэв дарал буурах хандлагатай байвал шокийн индексийг тогтоогоод эмнэлэг хүрэх замын турш калитай глюкозыг судсаар дуслаар хийнэ.

/600./ Стенокардитэй настанд өрхийн эмчийн зөвлөх эмчилгээ:

1. Титэм судсыг өргөсгөх эм /нитроглицерин, сустак, нитросорбит

2. Цус бүлэгнэлтээс сэргийлэх эм /курантил, аспирын 100

3. Кальцийн блокаторууд /нифедипин, верапамил

4. Долоогоны ханд уух

5. Давс, өөх тосыг хоолонд хязгаарлах

/601./ Зүрхний шигдээсээр өвчилсөн настанд өрхийн эмчийн зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээ буюу менежмент:

1. 1 жилийн турш идэвхитэй хяналтанд авч, сар тутам үзнэ.

2. 3 сар тутамд ЗЦБ хийнэ

3. Жилд 1-ээс доошгүй удаа цусан дахь сахар, холестерин, липопротеид, ферментийн идэвхийг шинжлэнэ.

4. Аспирин 100мг-аар ууж байхыг зөвлөнө

5. Зүрх судасны эмчид үзүүлнэ, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт хэвтүүлнэ.

/602./ Настанд аспирин 100 мг-аар уулгах нь ямар ач холбогдолтой вэ?

1. Тромбоцитын агрегацийг бууруулдаг тул цус өтгөрөхөөс сэргийлдэг

2. Зүрх судасны өвчний үхлийг 15% бууруулдаг

3. Зүрхний шигдээсээр өвчлөх явдлыг 33%-иар бууруулдаг

4. Цус харвалтыг 33%-иар бууруулдаг

5. Давтан зүрхний шигдээсээр өвчлөхийг бууруулдаг.

/603./ 72 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүнээс юу асуух вэ?

1. Их ууж, их шээж байгаа юу?

2. Ам цангах шинж байна уу?

3. Шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байна уу?

4. Шээсэн хэрнээ давсганд шээс үлдэх мэт шинж илэрдэг үү?

5. Орой хөл хавантай байдаг уу?

/604./ 74 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байгаа, шээсэн хэрнээ давсганд шээс үлдэх мэт шинж илэрдэг ба заримдаа тэвчихэд хэцүү болдог гэж өгүүлсэн байв. Түүний цус, шээсний шинжилгээ хэвийн гарсан, ЗЦБ өөрчлөлтгүй, зөвхөн хэт авиан шинжилгээгээр түрүү булчирхай томорсон байв. Түүнд түрүү булчирхайн ямар эмгэг байх магадлалтай вэ?

1. Түрүү булчирхайн томролт

2. Түрүү булчирхайн хоргүй хавдар

3. Түрүү булчирхайн хортой хавдар

4. Түрүү булчирхайн сүрьеэ

5. Түрүү булчирхайн усжилт

/605./ 74 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Түүний шээсний урсгал сул, бага багаар дүлж шээж байгаа, шээсэн хэрнээ давсганд шээс үлдэх мэт шинж илэрдэг ба заримдаа тэвчихэд хэцүү болдог гэж өгүүлсэн байв. Түүний цус, шээсний шинжилгээ хэвийн гарсан, ЗЦБ өөрчлөлтгүй, зөвхөн хэт авиан шинжилгээгээр түрүү булчирхай томорсон байсныг нас дагаж томордог өөрчлөлт гэж үзсэн байна. Түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Простамол эсвэл Простерид уух

2. Шөнө унтахын өмнө уух шингэний хэмжээг багасгах

3. Шээс гэнэт хаагдах тохиолдолд эмчид яаралтай хандах

4. Фуросемид өглөө бүр уух

5. Верошпирон өглөө бүр 100 мг-аар уух

/606./ 78 настай өвгөн халуурсан ба түүний шээс их үнэртэй, хүрэн өтгөн цай шиг өнгөтэй болсон ба ойр ойрхон шээс нь хүрч, шөнө босч шээх болсон зовиуртай. Анхан шатны эмч түүнд ямар шинжилгээ хийх вэ?

1. Цусны ерөнхий шинжилгээ
2. Шээсний ерөнхий шинжилгээ
3. Биохимийн шинжилгээнд креатинин, мочевин, бөөрний үйл ажиллагаа үзэх
4. Бөөрийг рентгенд харах
5. Түрүү булчирхайг хэт авиагаар харах

/607./ 62 настай эмэгтэй ханиах, найтаах үед шээс доошоо бага зэрэг алдаад, шээсээ барьж чадахгүй байгаа зовиуртай өрхийн эмчид хандсан. Өрхийн эмч түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Нас ахих тусам эмэгтэй хүний шээс задгайрах хандлагатай болдог тул ЭХЭМҮТ-ийн шээс задгайрлын кабинетэд очиж үзүүлэх ба эртхэн хагалгаанд орох нь дээр болохыг зөвлөнө

2. Шингэн бага ууж байх
3. 2 цаг тутам шээж байх
4. Шээс задгайрах нь настай эмэгтэй хүний онцлог тул юу ч хийгээд нэмэргүй
5. Цистит болсон тул антибиотик, уросептик уухыг зөвлөнө.

/608./ 62 настай эмэгтэй хаврын үед харшил хүрч, хаиах, найтаах нь ихэсдэг ба ханиах, найтаах үед шээс доошоо бага зэрэг алдаад, шээсээ барьж чадахгүй байгаа зовиуртай өрхийн эмчид хандсан. Өрхийн эмч түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Харшлын эсрэг эм уулгах
2. Паракоденк эсвэл кодеин 6 -8 цагаар 1-3 хоног уухыг зөвлөнө
3. Давсагны хуниас булчинг чангалах дасгал зааж өгнө
4. Шээс задгайрах нь настай эмэгтэй хүний онцлог тул юу ч хийгээд нэмэргүй гэж зөвлөнө
5. Цистит болсон тул антибиотик, уросептик уухыг зөвлөнө.

/609./ 72 настай эмэгтэй ханиад туссан ба ханиах, найтаах үед шээс доошоо бага зэрэг алдаад, шээсээ барьж чадахгүй байгаа зовиуртай өрхийн эмчид хандсан. Тэр шээс задгайрлыг эмчлэх хагалгаанд орохыг зөвшөөрөөгүй. Өрхийн эмч түүний амьдралын чанарыг хэрхэн дээшлүүлэх вэ?

1. Ханиадыг боломжийн хэрээр хурдан эмчлэх

2. Паракоденк эсвэл кодеин 6 -8 цагаар 1-5 хоног уухыг зөвлөнө

3. Уух шингэний хэмжээг багасгах ба шаардлагатай үедээ нэг удаагийн живх хэрэглэж байхыг зөвлөнө.

4. 2 цаг тутам шээж, давсгаа суллахыг зөвлөнө
5. Орой унтахын өмнө Амитриптиллин ууж байхыг зөвлөнө

/610./ 90 настай эмэгтэй шээхээ мартдаг ба гэнэт шээс нь хүрч, бие засах газар очиж амжилгүй өмдөндөө шээдэг болсон зовиуртай. Тэр заримдаа орондоо шээдэг. Түүний амьдралын чанарыг хэрхэн дээшлүүлэх вэ?

1. Нэг удаагийн живх өдөр бүр хэрэглэж байхыг асран халамжлагчид зөвлөнө.

2. Уух шингэний хэмжээг багасгахыг зөвлөнө

3. 2 цаг тутам шээж байхыг сануулж, шээлгэж байхыг асран халамжлагчид зөвлөнө

4. Шээс задгайрах нь настай эмэгтэй хүний онцлог тул юу ч хийгээд нэмэргүй болохыг ойлгуулна

5. Нас ахих тусам эмэгтэй хүний шээс задгайрах хандлагатай болдог тул ЭХЭМҮТ-ийн шээс задгайрлын кабинетэд очиж үзүүлэх ба эртхэн хагалгаанд орох нь дээр болохыг зөвлөнө.

/611./ 63 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 20% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Кальц, Д аминдэмийн бэлдмэл уух.

2. Сүү цагаан идээнд суулгалт үүсдэггүй бол кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэх.

3. Тохирсон гутал, гувцас өмсөөд явган алхах мэтийн хөнгөн хэлбэрийн дасгалыг аюулгүй, хальтаргаагүй орчинд өдөр бүр тогтмол хийдэг байх эсвэл чийрэгжүүлэлтийн кабинетэд очиж үзүүлээд нөхөн сэргээх эмчийн зөвлөсний дагуу дасгалуудыг хийх

4. Яс сийрэгжилтийг зогсоох зорилгоор Осталон Кальцтай, Даминдэмтэй хамт уух эсвэл бифосфонатын эмийн бүлгээс хэрэглэх.

5. Эмэгтэй хүнд зориулсан аминдэм, эрдэс давсны бүрдмэлээс, жишээ нь, “One daily for women” хоногийн хэрэгцээ хангах тунгаар тогтмол уудаг байх.

/612./ Ясны сийрэгжилтээс сэргийлэх зорилгоор настай хүнд ямар хоол хүнс илүүтэй зөвлөх вэ?

1. Лактозгүй сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэх
2. Жимс, ногоо илүүтэй хэрэглэх
3. Загасны тос, оливын тос, чацарганы тос бага багаар хэрэглэх
4. Өөх тостой мах, махан бүтээгдэхүүн хэрэглэх
5. Кола, Пепси, Спрайт зэргийн хийтэй ундаа уух

/613./ 66 настай эмэгтэй нилээд махлаг ба шатаар дээш өгсөх үед амьсгааддаг ба өвдөгний нүдрүү хатгуулж өвддөг болсон байв. Түүний өвдөгний өвдөлтийн шалтгааныг ялган оношлохын тулд ямар шинжилгээ хийх ёстой вэ?

1. Өвдөгний рентген шинжилгээ
2. АСЛО, СРБ, RF, АНА
3. Ясны сийрэгжилтийг тогтоох шинжилгээ
4. Цусны ерөнхий шинжилгээ, бүлэгнэлт ба тромбоцитын хэмжээ
5. Сүрьеэн сорил

/614./ 66 настай эмэгтэй нилээд махлаг ба шатаар дээш өгсөх үед амьсгааддаг ба өвдөгний нүдрүү хатгуулж өвддөг болсон байв. Түүний өвдөг яагаад өвддөг болсон байх магадлал илүү ихтэй вэ?

1. Өвдөг биеийн жингээ даахгүй болсон тул
2. Өвдөгний үений жийргэвч элэгдэж, нимгэрсэн тул
3. Өвдөгний үенд остеоартрит буюу үрэвсэл үүссэн тул.
4. Тулай өвчний улмаас
5. Өвдөгний сүрьеэ өвчтэй тул

/615./ Настанд ууц, нурууны остеоартрит ямар шалтгаанаар үүсдэг ба, ямар шинжээр илэрдэг вэ?

1. Хүнд жин, ачаа удаан хугацаагаар өргөх, биеийн жин их байх.
2. Бөхийж, өндийх, хүнд ачаа өргөх ажил хийдэг байх.
3. Нурууны нуглам завсрын жийргэвч мөгөөрс нь элэгдэх ба нимгэрэх.
4. Нурууны нуглам завсрын жийргэвч нимгэрсэнтэй холбоотой хөдөлгөөний явцад нугаснаас гарч буй мэдэрлийн ёзоор дарагдах, хавчигдах эрсдэл үүсэх.
5. Нурууны хөдөлгөөнтэй холбоотой хатгуулах өвдөлт үүсэх.

/616./ Ямар настан тулайгаар өвчлөх эрсдэл өндөр байдаг вэ?

1. Мах, ялангуяа дотор мах (элэг, бөөр, тархи), өндөг их иддэг
2. Шингэн бага уудаг ба шээсээр урат, оксалат байнга гардаг
3. Арьсан дээр цагаан батга ба тулайн борогцоонууд ургах хандлагатай.
4. Стрептококкийн архаг халдвартай
5. Гүйлсэн булчирхайн архаг үрэвсэлтэй

/617./ Өвчтөн Ц. 68 настай, цөсний хагалгаа хийлгэснээс хойш тосон суулгалттай болсон. Түүнд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Өөх тос багатай хоол идэх
2. Шингэн илүүтэй уух
3. Нойр булчирхайн бэлдмэлүүд, панзинорм, панкипсин, Креон зэргээс хоол идэх болгонд уух
4. Ванкомицин уух
5. Фталазол уулгах

/618./ Асцитыг шээс хөөх эмээр туухдаа эмч харгалзах ёстой зүйл:

1. Спиринолактон 72 цагийн дараа үйлчилдэг болохыг санах.
2. Асцитын эмчилгээнд Спиринолактоныг бага тунгаар хэрэглэх нь үр дүнгүй болохыг санах.
3. Фуросемид нь хүний биенээс калийг туудаг тул зүрх, булчингийн сулрал, гэдэсний саа үүсэх эрсдэлтэй тул калийн бэлдмэлийг хавсарч хэрэглэх
4. Хавдартай өвчтөнд кальц ихэссэн байдаг тул калийг фуросемидтэй хамт хавсаргах шаардлагагүй.
5. Спиринолактон кали туудаг тул калийн бэлдмэлийг хавсарч хэрэглэх.



/619./ Кали дутагдал нь эмнэлзүйн ямар шинжээр илэрдэг вэ?

1. Зүрхний авиа бүдэг болох
2. Зүрхний булчин суларсанаас агшилт нь суларч, тоо нь олшрох
3. Мөчдийн булчин сулрах, тамир тэнхээгүй болох, толгойгоо даах чадваргүй болох
4. Гэдэс гүрвэлзүүлэх булчин суларснаас гэдэс дүүрэх, хэвлий цардайж өвдөх, асцит томорч буй юм шиг шинж илрэх
5. ЗЦБ-т гипокалиемийн шинж илрэх

/620./ Шээс нь задгайрсан настан ба асарч буй хүнд ямар зөвөлгөө өгөх вэ? шингэний хэмжээг багасгах

1. Уух шингэний хэмжээг багасгах
2. Шээс хөөх эм хэрэглэж байгаа бол багасгах эсвэл хасах
3. 1-2 цаг тутам шээлгэж, давсгаа хоосолж байх
4. Хөтөвч нь тохирмжтой ба ойрхон, хэзээд бэлэн байх
5. Асарч буй хүн нь хүссэн үед нь бэлэн, уриалгахан, түвэгшээдэггүй байх

/621./ Шээс задгайрсан настанд давсганд байнгын катетер тавихын тул ямар тайлбарыг хэлж зөвшөөрөл авах вэ?

1. Шээс нь задгайрсан тул ямагт шээсэн дээрээ хэвтэх нь арьс нурах, түлэгдэх эрсдлийг бий болгодог
2. Шээсэн дээрээ удаан хэвтэх нь хэвтрийн цооролт үүсэх эрсдлийг үүсгэдэг
3. Танаас болон гэрээс нь шивтэн үнэртэх болно
4. Нэг удаагийн живх үнэтэй байдаг тул санхүүгийн бэрхшээл үүсгэнэ
5. Давсганд байнгын гуурс тавих нь дээрх бүх бэрхшээлүүдийг арилгах болно

/622./ Давсагны байнгын катетерт яагаад зажим тавих шаардлага гардаг вэ?

1. Давсагны байнгын катетер нь давсагнаас доош түвшэнд байрлуулсан ууттай холбоотой байдаг тул давсаг хэт хоосрох нөхцөл болдог
2. Давсаг шээстэй байвал катетерийн бөмбөлгийг мэдрэхгүй ба агшихгүй
3. Давсаг хэт хоосроход байнгын катетерийн бөмбөлгийг давсаг мэдэрч, агших, давсаг өвдөх шинж илэрдэг тул зажим тавьснаар давсгийг шээстэй байлгах болно.
4. Зажим тавих нь доороос өгсөх халдвар орохоос хамгаалдаг.
5. Зажим тавих нь шээс уутруу задгайрч орохыг багасгадаг.

/623./ Настанд шээс хаагдах ямар шалтгаан байдаг вэ?

1. Өтгөн ихээр хатах
2. Түрүү булчирхайн хавдар
3. Түрүү булчирхайн томролт
4. Шээсний сүвийн нарийсал ба давсаг орчмын хавдраар дарагдах
5. Бөөр шээсний замын чулуу

/624./ Ямар эмчилгээ хийлгэж буй настангийн шээс хаагдаж болох вэ?

1. Антихолинэргик эмүүд
2. Опиоид эмүүд
3. Амитриптилин
4. Нугасаар мэдээ алдуулах
5. Давсагны мэдрэлийн хориг

/625./ Шээс нь хаагдсан настангийн шалтгааныг хэрхэн эмчлэх вэ?

1. Антихолинэргик эмээс болж хаагдсан бол эмийг хасах эсвэл өөрчлөх
2. Өтгөн хатсанаас хаагдсан бол туулга хэрэглэх, лаа, бургуй тавих ба баасыг гаргах
3. Хэвтээгээрэй шээж чадахгүй өвчтөнийг босоогоороо шээс боломж олгох
4. Түрүү булчирхай томорсон бол түүнийг авах
5. Чулуу шээсийг хаагдуулсан бол чулуу хайлуулах эмчилгээ хийх

/626./ Шээс хаагдсан настанд авах арга хэмжээ:

1. Шээс хаагдуулсан шалтгааныг эмчлэх
2. Альфаадренорецепторын хориглогч хэрэглэх
3. Холинэрг эм хэрэглэх
4. Антихолинэстеразын бэлдмэл хэрэглэх
5. Давсганд байнгын катетер тавих

/627./ Шээсний өнгө настанд ямар шалтгаанаар өөрчлөгддөг вэ?

1. Хоол хүнс, жишээ нь, улаан манэин шээсийг улаан болгодог

2. Адриамицин, доксирубицин шээсийн улаан болгодог
3. Дантрон шээсийн улаан, ногоон, хөх өнгөтэй болгодог
4. Фенолфталеин буюу Пурген шээсийг ягаан болгодог
5. Pseudomonas aureginosa-гийн халдвар нь шээсийг цэнхэр болгодог

/628./ Настанд дэмийрэл ямар шалтгаанаар хамгийн элбэг үүсдэг вэ?

1. Халдвар авч халуурах
2. Өлсөх ба цусны сахар багасах
3. Баас удаан хугацаагаар хатах
4. Шээс хаагдах
5. Эмийг замбараагүй хэрэглэх

/629./ Настанд тулгардаг эрүүл мэндийн зонхилох асуудлууд юу вэ?

1. Ухаан муудах, ой санамж сулрах
2. Хараа, сонсгол муудах
3. Шээс задгайрах
4. Хөдөлгөөний эвсэл муудах
5. Хүч тэнхээ муудах

/630./ Настангийн өвчнийг эмчлэхэд анхаарах ёстой зүйлс юу вэ?

1. Настан олон архаг өвчтэй байдаг тул олон эм хэрэглэсэн байдаг тул эмийн харилцан үйлчлэлээс хордох магадлал өндөртэй байдаг.

2. Настанд элэг, бөөрний үйл ажиллагаа муудсан байдаг тул эмийг ялгаруулах чадвар алдагдсан байна.

3. Настанд эмийг харьцангуй бага тунгаар эсвэл цагийг нь холдуулж хэрэглэх нь зүйтэй.

4. Настан олон эм хэрэглээд дүжирсэн байдаг тул эмийгөндөр тунгаар хэрэглэх ёстой.

5. Настанд олон архаг өвчтэй тул олон эмийг өндөр тунгаар хэрэглэх ёстой.

/631./ Настанд яагаад унаж, гэмтэл авах эрсдэл өндөр болдог вэ?

1. Хөдөлгөөний эвсэл муудах
2. Хараа, сонсгол муудах
3. Яс сийрэгжих
4. Цусны кальц ихсэх
5. Цусны кали ихсэх

/632./ 72 настай өвгөн гэдэсний халдвар авч, суулгалт үүссэн. Тэр хоногт 5 удаа усархаг шингэн зүйлээр баасан ба халуурсан. Түүнд ямар эрсдэл байгаа ба ямар тусламж үзүүлэх вэ?

1. Түүнд шингэн алдах эрсдэл өндөр байгаа ба шингэн дутагдал, халууралтын улмаас дэмийрэх эрсдэл өндөр байгаа.

2. Халуун бууруулах эм уулгах

3. Түүний суулгалтын шалтгааныг нянгийн эсрэг эмээр эмчилж, шингэн алдалтыг Рингер лактатын эсвэл физиологийн уусмал судсанд дуслаар хийж нөхөх хэрэгтэй.

4. Настай хүн хуурайшсан байдаг тул шингэн алдах эрсдэл бага байдаг.

5. Шингэн алдах эрсдэлгүй тул суулгалт аяндаа намдахыг хүлээх

/633./ Залгихад түвэгтэй болох нь настанд ямар уршигтай вэ?

1. Тураалд хүргэдэг
2. Хахаж цацах
3. Тамир тэнхээгүй болгох
4. Унаж, гэмтэх
5. Шээс задгайрах

/634./ Настанд ямар аминдэм, эрдэс бодис илүү хэрэгцээтэй байдаг вэ?

1. Д аминдэм
2. Кальц
3. В 12 амин дэм
4. Натр
5. Сахар

/635./ Анхан шатны эмч настанг үзэх бүрдээ ямар зүйл асуух, ямар үзлэг заавал хийх ёстой вэ?

1. Артерийн даралт
2. Биеийн жин

3. Хоолны дуршил
4. Шээсний гарц, үнэр, өнгө
5. Цусны сахар

/636./ Настанд шээс задгайрах шинж ямар шалтгаанаар үүсч болох вэ?

1. Давсагны булчин сулрах
2. Бөөр, шээсний замын өвчин
3. Тэнэгрэл, зөнөгрөл
4. Дэмийрэл
5. Чихрийн шижин

/637./ Настанд шээс задгайрах шинж ямар шалтгаанаар үүсч болох вэ?

1. Давсагны булчин сулрах
2. Өтгөн хатах
3. Бие засах газар хугацаандаа хүрч чадахгүй байх
4. Бие засах ёстойгоо мартаж
5. Эмийн гаж үйлчилгээ

/638./ Настанд ямар шалтгаанаар нойрны эмгэг үүсдэг вэ?

1. Бухимдал
2. Түгших эмгэг
3. Гутрал
4. Янз бүрийн биеийн эмгэг, жишээ нь үе мөчний өвдөлт, амьсгал давчидах, зүрхээр өвдөх
5. Шөнө олон дахин босч шээх шалтгаан

/639./ 82 настай эмгэн насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Тэр зөнөсөн тул заримдаа ач нараа танихгүй, элдэв юм ярьдаг. Түүнийг хүүхдүүд нь хооллохгүй бол өөрөө хоолоо идэх, халбагдах чадваргүй болсон. Шээс нь задвайрсан тул нэг удаагийн живх хэрэглэдэг. Хувцасаа өмсөх чадвар муудсан, товчны нүхээ олдоггүй тул хүүхдүүд нь хувцасладаг. Энэ эмгэний эрүүл мэнд амь насанд ямар эрсдэл байгаа вэ?

1. Хэвтрийн цооролт үүсэх эрсдэлтэй тул арьсыг шалгах
2. Хэвтрийн хатгаа үүсэх эрсдэл
3. Орноос унах, гэмтэл авах эрсдэл
4. Шээсэндээ түлэгдэх эрсдэл
5. Өлсөж дэмийрэх эрсдэл

/640./ 82 настай эмгэн насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Тэр зөнөсөн тул заримдаа ач нараа танихгүй, элдэв юм ярьдаг. Түүнийг хүүхдүүд нь хооллохгүй бол өөрөө хоолоо идэх, халбагдах чадваргүй болсон. Шээс нь задвайрсан тул нэг удаагийн живх хэрэглэдэг. Хувцасаа өмсөх чадвар муудсан, товчны нүхээ олдоггүй тул хүүхдүүд нь хувцасладаг. Эмч эмгэнийг үзэхдээ юуг асууж, юуг үзэж шалгах ёстой вэ?

1. Арьсыг үзэж, хэвтрийн цооролт байгаа эсэхийг шалгах
2. Арьсыг үзэж, нуралт, түлэгдэлт байгаа эсэхийг шалгах
3. Шээсний өнгө, үнэрийг шалгах ба тестерээр нитрат их байгаа эсэхийг илрүүлэх
4. Уушгийг чагнаж, хэвтрийн хатгаа байгаа эсэхийг шалгах
5. Хэн, хэзээ, яаж, юугаар, хоногт хэдэн удаа хооллодог болохыг асууж шалгах

/641./ 82 настай эмгэн насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Тэр зөнөсөн тул заримдаа ач нараа танихгүй, элдэв юм ярьдаг. Түүнийг хүүхдүүд нь хооллохгүй бол өөрөө хоолоо идэх, халбагдах чадваргүй болсон. Шээс нь задвайрсан тул нэг удаагийн живх хэрэглэдэг. Хувцасаа өмсөх чадвар муудсан, товчны нүхээ олдоггүй тул хүүхдүүд нь хувцасладаг. Түүний шээс өтгөн хүрэн өнгөтэй, өмхий үнэртэй байсан ба шээсний тестерт нитрат ихтэй гарсан байна. Бусад үзүүлэлтүүд хэвийн байв. Түүний асран халамжлагч нарт эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Шингэн илүүтэй уулгах
2. Баас хатахаас сэргийлэх ба шаардлагатай бол туулга уулгах
3. Уросептик эм (5 Нок, септрин, бисептол) хэрэглэх
4. Простамол эсвэл Простерид уулгах
5. Шээс хөөх Фуросемид уулгах

/642./ 83 настай эмэгтэй насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Тэр хэвтэрт 3 сар болсны дараа хэвтрийн цооролт үүссэн байв. Хэвтрийн цооролт зонхилон үүсдэг биеийн хэсгийг дурьд.

1. Сүүж орчим
2. Өсгий
3. Далны өнцөг ба сэртэн
4. Дагз
5. Тохой

/643./ 83 настай эмэгтэй насны доройтлын улмаас хэвтэрт орсон. Хэвтрийн цооролтоос урьдчилан сэргийлэхийн тулд асран халамжлагчид ямар зөвлөгөө өгөх ёстой вэ?

1. Настангийн байрлалыг 2 цаг тутам солих
2. Настанг даралт бага үүсгэдэг гудсан дээр хэвтүүлэх
3. Настанд илчлэг, уураг, өөх тос, нүүрс ус, аминдэмээр баялаг хоол хүнс идүүлэх.
4. Настанг хатуу, тэгш гадаргуй дээр хэвтүүлэх
5. Настангийн цус солих

/644./ Тэнэгрэл зөнөгрөлийн эрт үед илрэх шинжүүд:

1. Шинэ мэдээллийг тогтоох, сурах чадваргүй байх
2. Түвэгтэй зорилгыг биелүүлэх чадваргүй болох
3. Энгийн асуудлыг шийдвэрлэх чадвар муудах
4. Танил байсан орчиндоо төөрөх
5. Өөрийгөө илэрхийлэх чадвар буурах ба ууртай, уцаартай болох

/645./ Бөөрөөр ялгарах чадвар мудахтай холбоотой, настанд бага тунгаар хэрэглэх ёстой эмүүдийг дурьд:

1. Аминогликозид
2. Ванкомицин
3. Флуороквиналон
4. Пенициллин
5. Дигоксин

/646./ 65-аас дээш настай настанд Аспириныг хэрхэн хэрэглэх ёстой вэ?

1. Цус алдах хандлагатай ба ходоодны шархтай настанд Aspirin хэрэглэхгүй байх.
2. 80-аас дээш настай хөгшинд Аспириныг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэхээс зайлсхийх
3. Шалтгаан тодорхой бус толгой эргэх шинжтэй настанд Аспирин хэрэглэхээс зайлсхийх
4. Настанд Аспириныг хоногт 150 мг-аас илүү өндөр тунгаар хэрэглэх нь цус алдах эрсдлийг ихэсгэдэг ба ходоод хамгаалах H<sub>2</sub> хориглогч ба Протоны шахуургын ингибитор хавсарч хэрэглэх нь зүйтэй
5. Аспириныг Варфаринтэй хамт хэрэглэхээс зайлсхийх

/647./ Настанд олон эм хэрэглэх шаардлагатай бол эмийн харилцан үйлчлэлээс сэргийлэх зорилгоор эмч ямар арга хэмжээ авах вэ?

1. Нэг өвчнийг хоногт нэг удаа хэрэглэх нэг эмээр эмчлэхийг хичээх
2. Настангийн шинж тэмдэг бүрийг эмчлэх гэж хичээх хэрэггүй
3. Эмийг бага тунгаар эхлэж, шаардлагатай бол тунг аажим ихэсгэх эсвэл аажим нэгээс ихгүй шинэ эм нэмэх
4. Эмчилгээ эхэлснээс хойш 2-4 долоо хоногийн дараа үр дүнг үнэлэх ба үр дүнгүй нь тогтоогтвол эмийг хасах

5. Үзлэг болгоны явцад эмийг хэрхэн (тун, цаг, үйлчилгээ, гаж үйлчилгээ, хэрэглэх арга) хэрэглэж байгааг дэлгэрэнгүй шалгах ба шаардлагатай бол эмийг нэг нэгээр нь аажим хасах

/648./ Настанг амьсгалын замын архаг бөглөрөлт өвчнөөс урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ?

1. Тамхи хэрэглэхийг зогсоох
2. Амьсгалын дасгар хийх
3. Тараглалттай бол турах дасгал хийх
4. Дархлаажуулах
5. Амьдралын хэв маягийг өөрчлөх

/649./ Настанд амьсгалын замын архаг бөглөрөлт өвчин үүсэх эрсдэлт хүчин зүйлсийг тоочих:

1. Тамхи
2. Ахуйн ба ажлын байрны тоос
3. Амьсгалын замын халдварт өвчнөөр ойр ойрхон өвчлөх

4. Харшил

5. Удамд амьсгалын замын архаг өвчний түүхтэй эсвэл Альфа 1 антитрипсины дутагдал /650./ Амьсгалын замын архаг бөглөрөлт өвчин илаарших боломжгүй ба эмчилгээ үр дүнгүй болж, амьсгаадах, амьсгал давчидах шинж арилахгүй байвал ямар арга хэмжээ авах вэ?

1. Антибиотик схемээр, илүү том тунгаар авах
2. Хөнгөвчлөх эмчилгээнд хамруулах
3. Эуфиллин тариагаар хийх
4. Морфин 2,5-5 мг-аар уулгах
5. Допамин, гепарин тариагаар хийх

/651./ 82 настай эмгэн дунд чөмөгний хугаралтай. Түүнийг гэмтэлт хүргэсэн боловч, яс сийрэг, шүрүп тогтохгүй гээд ясыг нь хадаагүй буцаасан. Тэр маш их өвдөлттэй байгаа ба Хэвтэрт орсон байв. Түүнд одоо ямар тусламж үйлчилгээ хэрэгтэй вэ?

1. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ
2. Өвдөлт намдаах эмчилгээ
3. Хэвтрийн цооролтоос сэргийлэх арга хэмжээ
4. Тогооны хөө уулгах
5. Хоолигны мах идүүлэх

/652./ 78 настай өвгөн 62 настайдаа зүрхний шигдээс болж байсан. Одоо зүрх кардиосклероз болсон тул зүрхний архаг дутагдалтай, байнга амьсгааддаг, хоёр хөл нь хавантай, элэг томорсон, уушги хавантай, хэвлийд шингэнтэй. Түүнд илааршуулах эмчилгээ үр дүн өгөх болов уу? Түүнийг хаана, хэрхэн эмчлэх нь дээр вэ?

1. Түүнийг эрчимт эмчилгээний тасагт эмчилнэ
2. Түүнийг хөнгөвчлөх эмчилгээний хоспист эмчилнэ
3. Түүнийг зүрх судасны тасагт эмчилнэ
4. Тэр өөрөө зөвшөөрсөн тохиолдолд хөнгөвчлөх эмчилгээний хоспист эмчилнэ
5. Түүнийг настангийн сувилалд эмчилнэ

/653./ Настангийн асрамжийн газар нь хөнгөвчлөх эмчилгээний хосписоос юугаар ялгаатай вэ?

1. Стандарт нь өөр. Хөнгөвчлөх эмчилгээний хоспист 1 эмчид 6-8 өвчтөн ноогддог.
2. Стандарт нь өөр, настангийн сувилалд 1 эмчид 20 -40 настан ноогдоно.
3. Хөнгөвчлөх эмчилгээний хоспист бие, сэтгэлийн зовиур шаналгаатай настанд хөнгөвчлөх эмчилгээ хийдэг
4. Настангийн асрамжийн газар насны доройтолтой настанг хооллох, усанд оруулах, живх солих зэрэг асаргаа, сувилгаа хийгддэг
5. Санхүүжилт нь өөр байх ёстой, хөнгөвчлөх эмчилгээний хоспис нь эрүүл мэндийн төсөв, даатгалаас сахүүжих ёстой, настангийн асрамжийн газар нь эрүүл мэндийн төсөв, нийгмийн халамжийн сангаас санхүүжих ёстой

/654./ Бөөрний архаг үрэвсэлтэй настан 62 настай ба түүний шээс их үнэртэй, хүрэн шар өнгөтэй гардаг ба түүний арьс байнга загатнадаг гэсэн зовиуртай. Түүнд өрхийн эмч ямар тусламж үзүүлэх вэ?

1. Шээсийг тестерээр шинжлэх
2. Тэр бөөрний дутагдалтай ба шээсний замын халдвартай байх магадлалтай.
3. Түүнд уросептик эм уулгах
4. Арьсыг хоногт 2-оос олон удаа хэсэгчлэн угаах
5. Антигистамины бэлдмэл уулгах

/655./ Хүчлэлийн (stress incontinence) шээс задгайрал настанд ямар үед үүсдэг вэ?

1. Ханиахад шээс дусагнах
2. Найтаахад шээс дусагнах
3. Хүнд зүйл өргөх гэж хүчлэхэд шээс дусагнах
4. Унаандаа хоцрох гэж яарах үед шээс дусагнах
5. Ариун цэврийн өрөөнд шээх гэж орж амжилгүй дусагнана

/656./ Тэвдэх үед даруй шээс задгайрал нь (urge incontinence) настанд ямар үед үүсдэг вэ?

1. Унаандаа хоцрох гэж яарах үед шээс дусагнах
2. Ариун цэврийн өрөөнд шээх гэж орж амжилгүй дусагнана
3. Гэртээ орох гэж түлхүүрээ хаалганд хийх үед дусагнана
4. Ханиах, найтах үед шээс дусагнана

5. Хүнд зүйл өргөх гэж хүчлэхэд шээс дусагнах  
/657./ Хэт урсгалтай шээс задгайрал нь (overflow incontinence) настанд ямар тохиолдолд үүсдэг вэ?

1. Ханиах, найтайх үед шээс дусагнана
2. Шээхгүй удаан шээсээ барихад
3. Хүнд зүйл өргөх гэж хүчлэхэд шээс дусагнах
4. Чихрийн ба чихрийн бус шижинтэй настан их ууснаас шээс задгайрна
5. Унаандаа хоцрох гэж яарах үед шээс дусагнах

/658./ Настанд шээс задгайрах өөр ямар шалтгаан байж болох вэ?

1. Нуруу нугасны гэмтэл
2. Тэнэгрэл, зөнөгрөл
3. Тархины хавдар
4. Тархинд цус харвалт
5. Хавдрын улмаас үүссэн үтрээ, давсагны эмгэг цорго

/659./ Шээс задгайрсан настанд ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Уух шингэнийг багасгах
2. Орны хажууд сандал -хөтөвчтэй болох
3. 2 цаг тутам шээж, давсгаа сулалж байх
4. Амархан тайлах өмдтэй байх
5. Шээс хөөх эмийг зогсоох

/660./ Настанд шээс задгайрал байгаа эсэхийг тогтоохын тулд олон улсын ямар асуумжийг тавих ёстой вэ?

1. Та хүсээгүй байхдаа шээсээ алддаг байсан уу?
2. Та ханиах, найтаах, дасгал хийх үедээ шээсээ алддаг байсан уу?
3. Та ариун цэврийн өрөө хүрэх замдаа шээсээ алдаж байсан уу?
4. Таны шээс дусагнадаг тул та ариун цэврийн хэрэглэл, живх хэрэглэж байсан уу?
5. Та шээсээ барьж чадахгүй байсан тохиолдол танд бий юу?

/661./ Ямар эмгэгтэй настан шөнө орондоо шээдэг вэ?

1. Шээс нь задгайрсан ба үе мөчний өвчнөөс хурдан босч чаддаггүй настан.
2. Шээс нь задгайрсан ба тэнэгрэл зөнөгрөлтэй настан
3. Хүчлэлийн шээс задгайралтай ба ханиад туссан настан
4. Чихрийн шижинтэй ба шээсээ барьж чаддаггүй настан.
5. Зүрхний дутагдлын улмаас хаван нь шөнө буурдаг ба шээс задгайрсан настан

/662./ Шээс задгайрлыг оношлохын тулд өрхийн эмч настанд ямар сорил хийж болох вэ?

1. Давсаг дүүрэн шээстэй зогсоогоод ханиахыг настангаас хүсэх ба ханиах үед шээс даруй гарч байвал хүчлэлийн шээс задгайрал гэж үзнэ
2. Шээс задгайрлыг илрүүлэх олон улсын асуумжийг хэрэглэж асуумж авна
3. Давсаг дүүрэн шээстэй зогсоогоод, ханиахыг настангаас хүсэх ба ханиах үед шээс хожуу гарч байвал давсагны булчин суларсантай холбоотой шээс задгайрал гэж үзнэ
4. Урографийн шинжилгээг тодруулагч бодис судсанд тарьсны дараа хийнэ.
5. Цистоскопийн шинжилгээ хийнэ

/663./ Настанд зүрхний дутагдал үүсгэх зонхилох шалгааныг тоочих:

1. Титэм судасны эмгэг, зүрхний шигдээс
2. Артерийн гипертенз
3. Кардиомиопати
4. Бамбайн хордлого
5. Чирхийн шижин

/664./ Настангийн биеийн жин буурах нь ямар шалтгаантай байж болох вэ?

1. Хорт хавдар
2. Сэтгэл гутрах эмгэг
3. Бамбайн хордлого
4. Сүрьеэ
5. Асаргаа муу байх

/665./ Нас дагаж хараанд ямар эмгэг бус өөрчлөлт илэрдэг вэ?

1. Шилжих өнгөний ялгааг гаргах чадвар мууддаг
2. Ойрын хараа мууддаг

3. Харанхуйд тахиан сохор болох магадлал ихэсдэг

4. Төвийн хараа үгүй болох

5. Захын хараа үгүй болох

/666./ Настангийн төвийн хараа буурахад ямар эрсдэлт хүчин зүйл нөлөөлдөг вэ?

1. Өндөр нас, эмэгтэй хүйс

2. Зүрх судасны өвчин

3. Тамхины хэрэглээ 3 дахин ихэсгэдэг

4. Каретиноид буюу А аминдэм багатай хүнс хэрэглэх

5. Наранд хэт их удаан байх

/667./ Настангийн төвийн хараа муудахаас сэргийлж өрхийн эмч ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Тамхины хэрэглээг зогсоох

2. Наранд удаан гарахгүй байх ба нарны өөдөөс харахгүй байх

3. С аминдэмийг 500 мг-аар хоногт уух

4. Е аминдэмийн 400 ОУН-ээр хоногт уух

5. А аминдэм 5000 нэгжээр ба бета Каротенийг 15 мг-аар уух /\*/ ба цинк, зэс зэрэг микроэлементтэй иж бүрдэл хэрэглэх

/668./ Настанд зонхилон тохиолдох чихрийн шижин ямар шинжээр илэрдэг вэ?

1. Их хэмжээтэй шээх

2. Ам цангаж, их уух

3. Шалтгаангүйгээр турах

4. Хоолны дуршил ихсэх

5. Арьс хуурайших ба амархан гэмтэх, тууралт гарах

/669./ Чихрийн шижинтэй настанд бөөр шээсний замаас ямар шинж зонхилон илэрдэг вэ?

1. Их хэмжээтэй шээх

2. Шөнө босч шээх

3. Бөөр шээсний замын халдвар амархан ойр ойрхон тусах

4. Шээсэнд чихэр илрэх

5. Шээсний хувийн жин өндөр байх

/670./ Нас ахих тусам хүн яагаад бага иддэг болдог вэ?

1. Хоол боловсруулах тогтолцоонд шүүрэл багасдаг тул

2. Ходоодны хэмжээ багасдаг тул

3. Хөдөлгөөн багасдаг тул хэрэгцээ багасдаг тул

4. Хоолны дуршил буурдаг тул

5. Шүд муутай болдог тул

/671./ Нас ахих тусам сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чадварт ямар өөрчлөлт гардаг вэ?

1. Зөвхөн сүүтэй цайгаар хоол хийж, өөр хоол идэхгүй болно

2. Гэдсэнд лактаза исэгийн дутагдал үүсдэг тул сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах чадвар буурдаг

3. Настай болох тусам зөвхөн сүү уудаг болно

4. Сүү уухад суулгадаг болно

5. Хөгшчүүл хүүхэдтэй ижил түл сүүгээр л хооллох болно

/672./ Настан яагаад хоолонд сармис хэрэглэж байх нь маш чухал вэ?

1. Халдварт өвчнөөс сэргийлэх тул

2. Бөөрний үйл ажиллагаанд сайн тул

3. Шээс хөөх, хаван бууруулах үйлчилгээтэй тул

4. Цус шингэрүүлэх, цусны эргэлтийг сайжруулах, атеросклероз, зүрхний шигдээсээс сэргийлэх үйлчилгээтэй тул

5. Хар сүнсийг зайлуулдаг тул

/673./ Настан яагаад сүү цагаан эдээ хэрэглэж байх ёстой вэ?

1. Хөгшрөлтөөс сэргийлдэг тул

2. Сүү цагаан эдээ шингээхдээ настан илүү сайн тул

3. Зүрхний тэтэм судасны хомсдлоос сэргийлдэг тул

4. Кальцаар баялаг тул ясны сийрэгжилтээс сэргийлдэг тул

5. Тархины цусан хангамжийг сайжруулдаг тул

/674./ Нас ахих тусам хоол боловсруулах тогтолцоонд ямар өөрчлөлт гардаг вэ?

1. Шүд муутай болдог
2. Ходоод гэдэсний шүүрэл багасдаг тул хоол боловсруулах чадвар мууддаг
3. Лактаза ферментийн дутагдал үүсдэг тул сүүг боловсруулах, шингээх чадвар мууддаг
4. Лактаза ферментийн идэвхи сайжирдаг тул сүүг боловсруулах, шингээх чадвар сайжирдаг.

5. Их хэмжээний хоол идэх шаардлагатай болдог

/675./ Настанд дараах аминдэмийн бүрдлээс алийг өгөх нь тохиромжтой вэ?

1. Ундавит
2. Гериавит
3. Остеовитал
4. Прегнавит
5. Гендавит

/676./ Настангнд судас нарийсах, хатуурах эмгэгээс сэргийлэхийн тул ямар аминдэмийн бүрдэл уулгах вэ?

1. Кальцинова
2. Остеовитал
3. Прегнавит
4. Ундавит
5. Гендавит

/677./ Настанг яс сийрэгжилтээс сэргийлэхийн тулд ямар аминдэмийн бүрдэл уулгах вэ?

1. Ревит
2. Ундавит
3. Прегнавит
4. Остеовитал
5. Гендавит

/678./ Нас ахих тусам эрэгтэйчүүдийн шээс, бэлгийн замд ямар өөрчлөлт илэрдэг вэ?

1. Настай эрэгтэйчүүдийн түрүү булчирхай томордог
2. Настай эрэгтэйчүүдийн үрийн шингэний гаралт буурна
3. Түрүү булчирхай давсаг дарж, ойр ойрхон шээс хүрэх, шөнө босч шээх, шээсний хүч сулрах шинж илрэнэ
4. Түрүү булчирхай томорсноор шээсний сүвийг дарж, шээс дүлж гарах, шээс тасалдаж гарах, давсан дутуу сулрах мэт шинж илэрнэ
5. Настай эрэгтэйчүүдийн бэлгийн чалх буурна, бэлэг эрхтэн хөвчрөх нь багасна

/679./ 76 настай өвгөн шөнө босч шээдэг болсон тул нойр алдаад байна гэсэн зовиуртай өрхийн эмчид хандав. Тэр шатаар явах үед амьсгааддаг байсан бол одоо тайван байх үедээ ч амьсгааддаг болсон. Орой болоход түүний хоёр шилбэ, шагайгаар хавансан байдаг. Шөнө босч шээдэг болсон гэж өгүүлсэн байв. Тэр ямар эмгэгтэй байх магадлалтай вэ?

- A. Чихрийн шижин
- B. Түрүү булчирхай томрох хам шинж
- C. Чихрийн бус шижин
- D. Зүрхний дутагдал, хаван шөнө бууснаас шээс шөнө элбэгшсэн байж болзошгүй
- E. Цистит

/680./ 78 настай эмэгтэй ясны сийрэгжилтийг үзүүлэхэд яс 10% сийрэг болсон байгааг илрүүлсэн. Түүнд өрхийн эмч Кальц, Даминдэм бичиж өгсөн ба кальцаар баялаг тул сүү, цагаан идээ илүүтэй хэрэглэхийг зөвлөсөн. Тэр эмэгтэй залуугаасаа эхлээд чихэртэй байхуу, кофе уудаг байсан ба сүү, цагаан идээ хэрэглэж заншаагүй байв. Сүү, тараг хэрэглэж эхэлсэн өдрөөсөө тэр суулгаж, суулгалтанд Котримоксазол, Фталазол, Бифидум бактерин, Линекс зэргийг уусан боловч суулгалт намдахгүй 10 хоног. Тэр ямар шалтгаантай суулгасан бэ?

- A. Кальцийн бэлдмэл уусан тул
- B. Сүү нь муудсан тул суулгасан
- C. Лактазагийн дутагдалтай тул суулгасан
- D. Дисбактериоз болсон тул
- E. Д аминдэм суулгуулдаг тул

/681./ 69 настай эрэгтэйн тохой, өвдөгний арьсан дээр, чихний дотор талын арьсан дээр том гүвдрүүт боргоцой шиг ургацтай. Гүвдрүүг хаглахад аарц шиг цагаан зүйл гарна. Өвдөгний



үеэр явахад өвддөг тул өвдөлт намдаахаар Ибупрофен уусан ба эмчид хандсан. Түүний шээсний шинжилгээнд оксалат, урат зэрэг давс ихээр илэрсэн. Түүнд ямар өвчин байх магадлал өндөр байна.

- A. Хэрх өвчин
- B. Баруун өвдөгний ясны сүрьеэ
- C. Остеоартрит
- D. Тулай
- E. Шенлейн Генохын өвчний үе мөчний хэлбэр

/682./ Симпатик мэдрэлийн төв хаана байрладаг вэ?

- A. Их тархины бор гадарт
- B. Нугасны S2-S4 үелэлд
- C. Харааны төвгөрт
- D. Дунд тархины дээврийн хэсэгт
- E. Нугасны C8-L3 үелэлд

/683./ Бүдүүн гэдэсний хэсгүүдийг нэрлэ

- 1. caecum
- 2. colon
- 3. rectum
- 4. appendix vermiformis
- 5. colon sigmoideum

/684./ Дотоод шүүрлийн төвийн эрхтэнд аль нь хамаарагдах вэ?

- 1. Бамбай булчирхай
- 2. Өнчин тархи
- 3. Сэрээ булчирхай
- 4. Боргоцой бие
- 5. Бөөрний дээд булчирхай

/685./ Дотоод шүүрлийн захын эрхтэнд аль нь хамаарагдах вэ.

- 1. Бамбай булчирхай
- 2. Өндгөвч
- 3. Бамбайн дэргэдэх булчирхай
- 4. Бөөрний дээд булчирхай
- 5. Боргоцой бие

/686./ Цус төлжүүлэх төвийн эрхтэнд аль нь хамрагдах вэ?

- 1. Дэлүү
- 2. Шавиа чөмөг
- 3. Тунгалагийн зангилаа
- 4. Сэрээ булчирхай
- 5. Тунгалаг төст эдүүд

/687./ Сэрэл дамжуулах тогтолцооны аль бүрдлээр сэрэл ховдлын булчингийн ширхэг лүү дамжих вэ?

- 1. Тосгуур-ховдлын зангилаа
- 2. Пуркинъегийн ширхэг
- 3. Гиссийн багц
- 4. Тосгуурын зангилаа
- 5. Хөхлөг булчингууд

/688./ Дотоод шүүрлийн булчирхай түүнээс ялгарах шүүрлийг уялдуулан сонгоно уу?

- 1. Бамбай булчирхай A. паратгормон
- 2. Өндгөвч B. прогестерон
- 3. Бөөрний дээд булчирхай C. тестостерон
- 4. Төмсөг D. тирозин
- 5. Бамбайн дэргэдэх булчирхай E. кортизол

- A. 1B, 2E, 3D, 4C, 5A
- B. 1D, 2B, 3E, 4C, 5A
- C. 1A, 2E, 3D, 4C, 5B
- D. 1B, 2C, 3D, 4E, 5A

Е. 1А, 2С, 3В, 4Е, 5D

/689./ Хоол боловсруулах замаас шимэгдсэн хорт бодисууд хаана ямар замаар хоргүйжих вэ?

- А. Эсийн дотор ферментүүдийн нөлөөгөөр задарч
- В. Цусны урсгалд хоргүйжүүлэгч бодисуудтай нэгдэж
- С. Бөөрөнд идэвхитэй хэлбэрийн цууны ба хурган чихний хүчилтэй нэгдэж
- Д. Элгэнд идэвхитэй хэлбэрийн хүхрийн ба глюкуроны хүчлүүдтэй холбогдож
- Е. Нарийн гэдсэнд ферментүүдийн нөлөөгөөр задарч

/690./ Өөх тос боловсруулах липаза фермент хаана үүсэх вэ?

- А. Элгэнд
- В. Нойр булчирхайд
- С. Нарийн гэдсэнд
- Д. Цөсний замд
- Е. Ходоодны салстад

/691./ Эрүүл хүний цусны нийт липидийн түвшинг заана уу?

- А. 0,5-5 г/л
- В. 5-10 г/л
- С. 6-9 г/л
- Д. 2-4 г/л
- Е. 1,7-7,0 г/л

/692./ Гиперкальциеми илэрдэг эмгэгүүдийг заах

1. Лейкоз
2. Д-гипервитаминоз
3. Ясны эдийн анхдагч атрофи
4. Цочмог панкреатит
5. Гипопаратиреоидизм